

Улсын бүртгэлийн
дугаар
Аравтын бүрэн
Ангиллын код:

Нууцын зэрэглэл: Б
Албан хэрэгцээнд
Төсөл гүйцэтгэх гэрээний
дугаар:1в/1323/2025.04.17

БАТЛАН ХАМГААЛАХЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

**“ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД БАТЛАН
ХАМГААЛАХ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА” ШИФР: “ГАДААД ХАМТЫН
АЖИЛЛАГАА”**

Захиалгат судалгааны төслийн тайлан
2024-2025

Төслийн удирдагч:	З.Болдбаатар - БХЭШХ-ийн АБСТ-ийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Цэргийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор
Төслийн гүйцэтгэгч:	Т.Наранхүү - БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төвийн дарга, хурандаа Г.Одбаяр - БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын ахлах шинжээч, хурандаа Ч.Сэрээнэн - БХЭШХ-ийн Аюулгүй байдал судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч Д.Батбаяр - БХЭШХ-ийн Аюулгүй байдал судлалын төвийн төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, докторант Г.Сугар - БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан
Санхүүжүүлэгч байгууллага:	Батлан хамгаалах яам
Захиалагч байгууллага:	БХЯ-ны ШУТИЗ
Тайлан өмчлөгч:	Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. 13302 Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 39-р хороо, Ахмадын болон алба хаагчдын хөгжлийн төв Цахим хаяг: http://www.mids.gov.mn ;

Улаанбаатар. 2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	3
------------------------------	---

УДИРТГАЛ	5
----------------	---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1.1 Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны онолын үндэс . . .	9
1.2 Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны хамаарал	21
1.3 Гаднын зарим улс орны гадаад хамтын ажиллагааны туршлага, сургамж .	29
1.4 Дүгнэлт	42

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ БАТЛАН ХАМГААЛАХ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

2.1 Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны бодлого, чиглэл.	44
2.2 Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны өнөөгийн байдлын шинжилгээ	50
2.3 Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд батлан хамгаалах гадаадын хамтын ажиллагааны үзүүлэх нөлөөлөл	65
2.4 Дүгнэлт	73

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАТЛАН ХАМГААЛАХ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

3.1 Олон улсын болон бүс нутгийн батлан хамгаалах хамтын ажиллагааны төлөв	74
3.2 Батлан хамгаалах хамтын ажиллагааны сорилтууд	95
3.3 Батлан хамгаалах хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж, санал зөвлөмж .	99
3.4 Дүгнэлт	103

БАТЛАН ХАМГААЛАХЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

105

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ.....	112
-----------------------------	-----

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Товчлол	Тайлбар
ҮАБ	Үндэсний аюулгүй байдал
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ШХАБ	Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага
АСЕМ	Азийн болон Европын уулзалт (Asia-Europe Meeting)
ЕХ	Европын Холбоо
ДХБ	Дэлхийн Худалдааны Байгууллага
АСЕАН	Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо (Association of Southeast Asian Nations)
ARF	Азийн бүс нутгийн аюулгүй байдлын форум (ASEAN Regional Forum)
CICA	Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх бага хурал (Conference on Interaction and Confidence-Building Measures in Asia)
ГХБ	Гадаад хамтын ажиллагаа ба бодлого
БХБ	Батлан хамгаалах бодлого
ҮНБ	Үндэсний нэгдмэл байдал
ГХЯ	Гадаад хэргийн яам
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
УИХ	Улсын Их Хурал
БХЯ	Батлан хамгаалах яам
ЦХХА	Цэрэг, хүчний хамтын ажиллагаа
ЭХА	Эдийн засгийн хамтын ажиллагаа
НХА	Нийгмийн хамтын ажиллагаа
КХА	Кибер хамтын ажиллагаа
МХА	Мэдээллийн хамтын ажиллагаа
ХАБ	Хамтын аюулгүй байдлын онол (Collective Security Theory)
ХДТО	Харьцангуй давуу талын онол (Theory of Comparative Advantage)
ХХО	Харилцан хамаарлын онол (Theory of Interdependence)
Неореализм	Олон улсын харилцааны неореалист онол (Kenneth Waltz)
Либерализм	Олон улсын харилцааны либералист онол (Keohane, Nye)
Конструктивизм	Олон улсын харилцаанд нийгмийн бүтцийн онол (Alexander Wendt)
Институционализм	Байгууллага, дүрэм журмаар хамтын ажиллагааг тайлбарлах онол

Товчлол

ГХБО

ГХБЗ

UNMISS

KFOR

БНӨСҮ

QUAD

AUKUS

ACEAN

CSTO

OSCE

Тайлбар

Гадаад хамтын ажиллагааны онол

Гадаад хамтын ажиллагааны зарчим

United Nations Mission in South Sudan (Өмнөд Суданд
явагдаж буй НҮБ-ын ажиллагаа)Kosovo Force (НАТО-гийн Косовод байрлах олон улсын
цэргийн хүчин)

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс

АНУ, Япон, Энэтхэг, Австралийн Холбоо

Австрали, Их Британи, АНУ-ын Холбоо

Зүүн Өмнөд Азийн Орнуудын Холбоо

Хамтын Аюулгүй байдлын Гэрээний Байгууллага

Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны
Байгууллага

УДИРТГАЛ

21-р зуунд дэлхийн улс орнуудын харилцаа улам бүр харилцан уялдаа, хамааралтай болж, үндэсний аюулгүй байдал зөвхөн дотоод хүчин зүйлээс бус, гадаад орчны өөрчлөлтөөс гүн гүнзгий хамаарах боллоо.

Эдийн засгийн даяаршил, бүс нутгийн интеграци, технологийн дэвшил, харилцаа холбооны хурд нэмэгдэхийн хэрээр улс орнуудын аюулгүй байдал зөвхөн хил, нутаг дэвсгэрийн баталгаагаар хэмжигдэхгүй, харин эдийн засаг, технологи, мэдээлэл, цэрэг -батлан хамгаалах, байгаль орчин зэрэг олон талт хүчин зүйлсийг цогцоор нь тооцож авч үзэх шаардлагыг буй болоод байна.

Дэлхийн аюулгүй байдлын орчин сүүлийн жилүүдэд хурцадмал болж, терроризм, кибер аюул, бүс нутгийн маргаан, улс төр, геополитик технологийн өрсөлдөөн нь жижиг болон дунд хэмжээний улсуудын батлан хамгаалах чадавхад хүчтэй нөлөө үзүүлэх боллоо.

Жижиг улс орнууд ч олон талт гадаад хамтын ажиллагаагаар өөрсдийн аюулгүй байдлыг баталгаажуулах боломжтой гэдгийг анхаарч энэ чиглэлд эрчимтэй ажиллаж байна. Дэлхий дахинд улс орнууд, аж ахуйн нэгжүүд, хувь хүмүүс хоорондын харилцан хамаарал мэдээллээр дамжин улам бүр гүнзгийрч, гадаад хамтын ажиллагаа нь улс төр, эдийн засаг, аюулгүй байдал, хөгжлийн зайлшгүй нэг хэсэг нь болох боллоо.

Энэхүү үйл явц нь зөвхөн хил хязгаарыг давсан худалдаа, хөрөнгө оруулалт төдийгүй, харилцан итгэлцэл, үр өгөөжтэй түншлэлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж өгч байна. Эдүгээ үеийн улс орнуудын хөгжилд олон улсын харилцаа, гадаад хамтын ажиллагаа нь улс орнуудын аюулгүй байдал, эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийг хангах гол хүчин зүйлийн нэг байсаар байна.

Дэлхий дахинд геополитик, цэрэг, эдийн засаг, технологийн өрсөлдөөн идэвхжиж, улс орнуудын батлан хамгаалах зардал нэмэгдэж, энэ чиглэлийн хамтын ажиллагааны ач холбогдол цаашдаа өсөх хандлагатай байна.

Улс орны аюулгүй байдлыг баталгаажуулахад гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх нь нэн чухал бөгөөд манай улс нь том гүрнүүдийн хоорондын тэнцвэрийг хадгалахад батлан хамгаалах хамтын ажиллагааг зөв зохистой хэрэгжүүлэх нь энэ тэнцвэрт байдлыг хадгалах, цэргийн итгэлцлийг бий болгоход чухал ач холбогдолтой юм.

Манай улсын аюулгүй байдалд бүс нутгийн улс төр, эдийн засаг, батлан хамгаалах үйл явц дам болон шууд нөлөө үзүүлдэг. Энэ нөхцөл байдалд батлан хамгаалах хамтын ажиллагааг зөв зохицуулах, тэнцвэртэй, идэвхтэй бодлого хэрэгжүүлэх шинэ шаардлага тулгарч байгаа болно.

Үндэсний аюулгүй байдлыг хангах гадаад хамтын ажиллагаа нь бусад улс оронтой дипломат, эдийн засаг, нийгэм, цэрэг, шинжлэх ухаан, технологи, соёлын харилцааг тогтоох үйл ажиллагаа бөгөөд түүний зорилго нь харилцан ашигтай хамтын ажиллагаа, тогтвортой хөгжил, итгэлцэл, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх явдал байдаг.

Орчин үеийн олон улсын харилцааны ээдрээтэй, хүнд цаг үед үндэсний аюулгүй байдлыг хангах нь зөвхөн улс орны дотоод хүчин зүйлсээр хязгаарлагдахгүй бөгөөд гадаад харилцаа, дипломат бодлого, батлан хамгаалах

олон талт харилцаа, бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагаатай салшгүй уялдаж, идэвхтэй бүтээлч ажиллагаагаар хангагдах хэрэгцээг үүсгэж байгаа юм.

Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны уялдаа, хамаарал, нөлөөллийн асуудал нь төрийн бодлогын стратегийн чухал сэдэв бөгөөд олон улсын харилцаа, үндэсний аюулгүй байдлын чиглэлд өргөн хэрэглэгддэг судлагдахуун юм.

Энэ бүхнээс харахад батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагааг зөв зохистой хөгжүүлэх, хоёр хөрш орны тэнцвэрт байдлыг хангах, гуравдагч хөршийн бодлогыг зөв уян хатан хэрэгжүүлж, энхийг эрхэмлэсэн гадаад харилцааг өнөөгийн шаардлагад нийцүүлэн явуулах зайлшгүй шаардлага үүсэж байгаа болно.

Ийм ч учраас Монгол улсын Засгийн газрын 2024 -2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 дахь хэсэгт “...Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх....” гэж заасан.

Энэхүү зорилтын хүрээнд БХЯ-ны ШУТИСЗ-ийн даалгавраар 2025 ондоо багтаан “Үндэсний аюулгүй байдлыг хангахад батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны үзүүлэх нөлөөллийн судалгаа” сэдэвт судалгааны даалгаварт ажлыг хийж гүйцэтгүүлэхээр БХЭШХ-ийн Аюулгүй байдал судлалын төвд хариуцуулсан.

Судлагдсан байдал:

Судалгааны ажлыг хийх явцад батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны чиглэлээр тусгайлан хийгдсэн судалгааны бүтээл ховор талдаа байсан ба энэ асуудлыг үндэсний аюулгүй байдал болон гадаад харилцааны чиглэлээр илүүтэй авч үзэж түүндээ батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны асуудлыг өнгөцхөн хөндсөн байдаг нь олонтой харагдаж байсан ба энэ хүрээнд хийгдсэн сүүлийн үед олон нийтэд хэвлэгдэн ашиглагдаж байгаа зарим илт бүтээлүүдийг ашигласныг та бүхэнд танилцуулж байна. Үүнд: Sarlagtay, M. O. (2012). *Mongolia's Immediate Security Challenges: Implication to Defense Sector and The Regional Cooperation*. In National Institute for Defense Studies (Ed.), *Security Outlook of the Asia Pacific Countries and Its Implications for the Defense Sector* (NIDS Joint Research Series No. 7, pp. 103-116). Tokyo: NIDS; Tuvshintugs, A. (2010). Mongolia and the prospects for a multilateral security mechanism in Northeast Asia. *Review of Japanese & Asian Political Studies / RJAPS*, 26, 28-40. (PDF); Ministry of Defence of Mongolia. (1998). *Mongolia: Defence White Paper 1997/1998* (English translation). Ulaanbaatar: Ministry of Defence. (PDF); Government of Mongolia, National Security Council. (2010). *National Security Concept of Mongolia* (English). Ulaanbaatar: National Security Council. (PDF); Canada Forces / Canadian Forces College. (2019). *Mongolian Defence Policy* (research paper). Canadian Forces College. (PDF); Friedrich-Ebert-Stiftung (FES) Mongolia. (2021). *Small-power diplomacy: Mongolia's peacekeeping and multilateral security engagement* (policy brief / report). Ulaanbaatar: FES Mongolia. (PDF); Institute for Strategic Studies (ISS) of Mongolia. (various years). *Reports and policy briefs on Mongolia's role in regional peace cooperation and defence reforms* — (collection of short studies and commentary). Ulaanbaatar: ISS. (web portal); Mongolian Journal of International Affairs. (1996/2015). *Fundamentals of the Military Doctrine of Mongolia*. *Mongolian Journal of International Affairs*, 3, 73-83. <https://doi.org/10.5564/mjia.v3i0.432>; Lkhaajav, B. (2018). *The Significance of Mongolia's Foreign Policy and Security Apparatus on a Global and Regional Scale* (Master's capstone). University of San Francisco Repository. (PDF);

ResearchGate / academic preprints: *Concept of National Security of Mongolia* — compilation/analysis (various authors/translations). (ResearchGate deposit). (PDF); International Committee of the Red Cross (ICRC). (2025). *Promoting Humanitarian Principles at Khaan Quest 2025* (article/report). Geneva: ICRC. (web article); U.S. Indo-Pacific Command / PACOM. (2025). *Khaan Quest 2025 — exercise overview and press release*. (web article); Montsame / Mongolian state press (collection). (various years). *Reports on Mongolia's international defence cooperation, exercises and deployments* (news reports and official releases); Kasumov / AVIM / regional analyses. (2020). *Mongolia's search for balance in its foreign policy* — policy analysis (online article); Asian Development Bank (ADB). (2020). *Mongolia: Economic Prospects and implications for regional cooperation* — background report (includes security-economic linkages). Manila: ADB. (PDF).

Судалгааны зорилго:

Судалгааны ажлаар Монгол улсын үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны онол, практикийн судалгаан дээр тулгуурлан Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны өнөөгийн байдалд шинжилгээ хийж түүнийг бэхжүүлэх арга замыг тодорхойлох зорилго тавьсан болно.

Судалгааны зорилтууд:

Энэхүү зорилгыг хангах хүрээнд судалгааны ажлыг Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны онол, практикийн асуудалд судалгаа хийх; Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны өнөөгийн байдалд шинжилгээ хийх; Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн санал, зөвлөмжийг тодорхойлох гэсэн зорилтуудыг даалгаварт ажлын шаардлагад нийцүүлэн авч үзэж, хийсэн болно.

Судалгааны объект:

Үндэсний аюулгүй байдал

Судлах зүйл:

Үндэсний аюулгүй байдлыг хангахад батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны үзүүлэх нөлөөлөл, өргөжүүлэх боломж

Судалгааны арга:

Мэдээллийг харьцуулан жиших, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, системийн хандлагын аргуудыг хэрэглэв.

Судалгааны ажлын “*Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны онол, практикийн асуудал*” сэдэвт нэгдүгээр бүлгийг Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны онолын үндэс, Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны харилцан хамаарал, Гаднын зарим улс орны гадаад хамтын ажиллагааны практик, туршлага, бүлгийн дүгнэлт гэсэн гурван дэд бүлэгтэйгээр судалгааны ажлыг хийсэн.

Судалгааны ажлын “*Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны өнөөгийн байдлын шинжилгээ*” сэдэвт хоёрдугаар бүлгийг Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны бодлого чиглэл, Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны өнөөгийн байдлын шинжилгээ, Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны үзүүлэх нөлөөлөл гэж гурван дэд бүлэг, дүгнэлтэйгээр хийсэн.

Судалгааны ажлын “Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн санал, зөвлөмж” сэдэвт гуравдугаар бүлгийг Олон улсын болон бүс нутгийн батлан хамгаалах хамтын ажиллагааны төлөв, Монгол улсын батлан хамгаалах хамтын ажиллагааны сорилтууд, Батлан хамгаалах хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж, санал, зөвлөмж гэсэн гурван дэд бүлэг, дүгнэлттэйгээр хийж гүйцэтгэлээ.

Арга зүйн зөвлөмж:

Судалгааны захиалгат ажлыг Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх бодлогын зөвлөмж, Төв Азид энхийг сахиулах болон цэрэг - техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлогын санал гэсэн хоёр хувилбараар судалгааны ажилдаа тулгуурлан зөвлөмжийг хийсэн болно.

Судалгааны ажлын шинэлэг тал:

БХЯ-ны захиалгат судалгааны ажил нь батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг хөгжүүлж, өргөжүүлэх талаар тусгайлан анхаарч судалгаа хийж, өнгөрсөн хугацаанд хийгдсэн батлан хамгаалах хамтын ажиллагаанд дүгнэлт өгч, түүнийг цаашид анхаарч хөгжүүлэх асуудлуудыг тодорхойлж гаргаснаараа шинэлэг болсон гэж үзэх үндэстэй байна.

Судалгааны захиалгат ажлын хүрээнд 2025 оны 10-р сарын 17 нд “Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж, арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг ҮБХИС, АБСХ, ТИС, БХЯ-ны гадаад хамтын ажиллагааны газар, ДХИС, ССХ зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжүүдийг энэхүү судалгааны ажилдаа тусгасан болно. Мөн захиалгат ажлын хүрээнд “Зүүн хойд азийн аюулгүй байдал: Батлан хамгаалах хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж” сэдэвт судалгааны эмхэтгэл ном гаргасан.

Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол:

Захиалгат энэхүү судалгааны ажил нь үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны онол, арга зүйн асуудлууд болон тэдгээрийн хоорондын хамаарлыг судалж, Үндэсний аюулгүй байдлыг хангахад батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны үзүүлж буй нөлөөллийг өнөөгийн бодит байдлын практик жишээн дээр судлан гаргаж, түүнийг цаашид улам боловсронгуй болгож хөгжүүлэх бодлогын санал, зөвлөмж гаргаж, Энхийг сахиулах болон цэрэг- техникийн хамтын ажиллагааны шинэ чиглэл болох Төв азид анхаарах асуудлуудыг хөндөж тавьсан нь практик ач холбогдолтой болсон. Мөн энэхүү судалгааны бүтээлийг сургалт, судалгаанд ашиглах боломжтой болсон гэж үзэж байна.

Тайлангийн боловсруулалт, бүтэц хэмжээ

Захиалгат судалгааны ажлын тайланг Монгол улсын эрдэм шинжилгээний тайлан, бүтэц, шаардлага MNS 24925 2004, MNS5371: 2004 стандарт шаардлагад нийцүүлэн боловсруулав. Захиалгат ажлын тайлан нь удиртгал, гурван бүлэг, зургаан дэд бүлэг, бүлэг бүрийн дүгнэлт, зөвлөмж, эх сурвалжийн жагсаалт бүхий 124 хуудас материалаас бүрдэж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

1.1 ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫН ҮНДЭС

"Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны онолын үндэс" гэдэг нь тухайн улсын аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагаатай холбоотой үзэл баримтлал, арга зүй, суурь зарчим, шинжлэх ухааны тайлбаруудыг хамарсан өргөн хүрээний ойлголт ухагдахуун юм.

Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс нь:

Үндэсний аюулгүй байдлын тухай онол нь тухайн улс орны оршин тогтнох, тусгаар, бүрэн эрхт байдал, нийгмийн тогтвортой хөгжил, иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой өргөн хүрээний ойлголтуудыг хамрахаас гадна гаднын аюул, заналын эсрэг төр, нийгэм, иргэн гурвын нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах нэгдмэл үйл ажиллагааг судалдаг. Тухайн улс үндэстэнд учирч болзошгүй аюул байж, аюулгүй байдлыг хангах тухай авч үзэх шаардлага бий болдог. Аливаа аюул, занал нь харилцан хамаарал бүхий хоёр талыг агуулдаг. Үүнд: нэг дэх нь аюул, заналын эх үүсвэр түүнийг тээгч буюу субъект тал, хоёр дах нь аюул, занал чиглэсэн объект тал юм. Аюул, заналын эх үүсвэр нь тодорхой нөхцөлд өөрөө эсвэл төрөл бүрийн нийлэмж байдлаар аливаа дайсагнагч хандлага, үйл ажиллагаагаар илэрхийлэгч нөхцөл, хүчин зүйл байдаг. Энэ бүхнээс үзэхэд "аюул" нь улс, нийгэм, хувь хүн болон ямар нэг объект, тогтолцооны бүтэц үйл ажиллагааг алдагдуулах хүчин зүйлсийг агуулдаг, хохирол учруулах, устгах чадвар бүхий хийсвэр оршиж буй хүч. Занал нь аюул хэмээх ойлголттой гарвал нэгтэй, илэрхий, ил тод тодорхой болсон аюулаар илэрхийлэгдэх, бодит байдал бөгөөд улс, нийгэм, хувь хүн, амьтай бүхнийг айдас, хүйдэст хүрэгдэг үзэгдэл. Үндэсний аюулгүй байдлыг зөвхөн цэрэг - улс төрийн хүрээнд бус эдийн засаг, нийгэм, байгаль орчин, мэдээлэл, кибер орон зай зэрэг олон хэмжээст ойлголтоор өргөн хүрээнд авч үздэг. Үндэсний аюулгүй байдал нь нийгэм, улс төрийн, олон улсын харилцааны, цэрэг-стратегийн онолуудад төв байр суурь эзэлдэг.¹

Үндэсний аюулгүй байдлын онолын суурь чиг хандлагууд

Реализм нь олон улсын харилцааны онолын хамгийн эртний бөгөөд өргөн хэрэглэгддэг хандлагуудын нэг бөгөөд үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, эрх мэдлийн бүтэц зэрэг асуудлыг шинжлэх ухааны түвшинд тайлбарлах онолын суурь үзэл баримтлал юм. Энэ онолын уг гарлыг Хүннүгийн үеийн төрийн онол, Пелопоннесийн дайн, Макиавелли, Хоббс зэрэг сэтгэгчдийн төрийн тухай үзэл санаанд тулгуурлан тайлбарладаг бол орчин үеийн олон улсын харилцаанд Ханс Моргентау, Кеннет Уолц нарын бүтээлүүдийг сонгодог реализм, неореализмын төлөөлөл хэмээн үздэг.

¹ Waldemar Kitler, "National Security Theory and Practice"

Реализмын онолын гол суурь нь олон улсын систем нь анархи шинжтэй, өөрөөр хэлбэл төвлөрсөн удирдлага, хяналтгүй оршдог тул улс бүр өөрийн үндэсний ашиг сонирхол, тусгаар тогтнолыг хамгаалах шаардлагад тулгуурлан үйл ажиллагаагаа тодорхойлдог гэсэн үзэлд оршино. Энэ нөхцөл байдал нь улс орнуудын хооронд эрх мэдэл, хүчний төлөө өрсөлдөөн зайлшгүй явагдах, харилцаа нь итгэлцэл бус харин харьцангуй давуу байдлын эрэлхийлэл дээр тогтдог болохыг илтгэнэ.

Сонгодог реализм нь хүний мөн чанарыг эрх мэдэл, ашиг сонирхлын төлөө тэмүүлдэг гэж үзэж, түүнийг улс хоорондын харилцаанд шилжүүлэн тайлбарладаг. Харин неореализм буюу бүтцийн реализм нь улс төрийн анархи орчин, олон улсын системийн бүтэц нь хүчний тэнцвэрийн тогтолцоог бий болгож, улсуудын зан төлөвийг тодорхойлно гэж тайлбарладаг.

Реализмын онол нь үндэсний аюулгүй байдлын тухай ойлголтыг уламжлалт буюу цэрэг, улс төрийн хүчин зүйлтэй илүү холбон үздэг. Тодруулбал, тухайн улсын гадаад бодлого нь хамгийн түрүүнд тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, цэргийн хүч чадлаа хамгаалахад чиглэдэг бөгөөд олон улсын хамтын ажиллагааг түр зуурын, ашиг сонирхолд нийцсэн тохиолдлын үзэгдэл гэж үздэг.²

Ийнхүү реализмын онол нь олон улсын харилцааны өрсөлдөөнт мөн чанарыг онолын түвшинд тайлбарлаж, үндэсний аюулгүй байдлын онолын суурийг бүрдүүлдэг бөгөөд өнөөг хүртэл олон улсын бодлогын дүн шинжилгээ, стратегийн судалгаанд төв байр суурь эзэлсээр байна.

Реализм ба Монгол Улс

Реализмын үүднээс авч үзвэл Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хамгийн чухал асуудал нь газарзүйн байршил, геополитикийн орчин юм. Монгол Улс хоёр их гүрэн болох Орос, Хятадын дунд оршдог тул тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаа хадгалах нь бодлогын нэн тэргүүний зорилт байсаар ирсэн.

Цэргийн хүчин чадал харьцангуй сул тул Монгол Улс хүчний тэнцвэрийг олон улсын хамтын ажиллагаа, гуравдагч хөршийн бодлогоор хангахыг эрмэлздэг.

Реализмын онолоор тайлбарлавал Монгол Улсын гадаад бодлого бол үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлаа хангахын төлөөх тасралтгүй үйл явц бөгөөд олон улсын хамтын ажиллагааг ч ашиг сонирхлын хүрээнд түр зуурын гэж үзэх боломжтой.

Либерализм нь олон улсын харилцааны онолын чухал чиглэлүүдийн нэг бөгөөд реализмын хүч төвтэй тайлбарыг няцааж, улсуудын хамтын ажиллагаа, харилцан хамаарал, олон улсын байгууллагын үүргийг илүүтэй тодотгодог. Либерализмын гол үзэл санаа нь улс орнууд харилцан ашигтай хамтын ажиллагаагаар дамжуулан энх тайван, аюулгүй байдлыг хангах боломжтой гэсэн үзэл санаан дээр тулгуурладаг.³

Энэхүү онолын дагуу олон улсын тогтолцоог зөвхөн хүчний өрсөлдөөнөөр биш, харин нийтлэг үнэт зүйл, хууль эрх зүйн тогтолцоо, эдийн засгийн харилцан

² Stanford Encyclopedia of Philosophy — “Political Realism in International Relations”

³ Princeton.edu — “Liberalism and International Relations Theory” (A. Moravcsik)

хамаарал, ардчилсан тогтолцооны нөлөөгөөр тодорхойлдог. Тухайлбал, ардчилсан улс орнууд хоорондоо дайн хийх нь ховор байдаг (ардчиллын энх тайвны онол), эдийн засгийн интеграц нь зөрчлийг багасгадаг, олон улсын байгууллагууд хамтын ажиллагааг тогтвортой байлгахад чухал үүрэгтэй гэж үздэг.

Иймээс либерализм нь үндэсний аюулгүй байдлыг зөвхөн цэргийн хүчинд бус, харилцан ашигтай хамтын ажиллагаа, дипломат харилцаа, бүс нутгийн интеграци, олон улсын байгууллагын идэвхтэй оролцоонд тулгуурлан тайлбарладаг.

Либерализм ба Монгол Улс

Либерализмын онолын үүднээс Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь зөвхөн хоёр хөрштэй харилцаанаас хамаарахгүй, харин олон улсын байгууллагын оролцоо, бүс нутгийн хамтын ажиллагаа, эдийн засгийн интеграцид тулгуурлан бэхжиж байна.

НҮБ, АСЕМ, ШХАБ зэрэг олон улсын болон бүс нутгийн байгууллагад идэвхтэй оролцож буй нь энх тайван, хамтын ажиллагааны орчныг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Гуравдагч хөршийн бодлого нь зөвхөн улс төрийн баталгаа бус, эдийн засгийн харилцан хамаарлыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг дэмжих либерал хандлагын илэрхийлэл юм.

Ардчиллын үнэт зүйлс, хүний эрхийн баталгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын чухал тулгуур болж байна.

Конструктивизм нь 20-р зууны сүүлээр хөгжсөн харьцангуй шинэ онол бөгөөд олон улсын харилцааг зөвхөн бодит хүчин зүйлсээр биш, харин үзэл санаа, үнэт зүйл, танин мэдэхүй, нийгмийн бүтцийн оролцоогоор тайлбарладаг. Энэхүү онолын гол онцлог нь "олон улсын бодит байдал нь тогтмол өгөгдсөн зүйл биш, харин нийгмийн харилцаа, үзэл санаа, итгэл үнэмшил, хэлэлцээрээр бүтдэг" гэсэн үзэл санаанд тулгуурладаг.⁴

Конструктивизмын онолоор улсуудын хоорондын харилцааг зөвхөн материаллаг хүчин зүйл биш, харин тухайн улс өөрийгөө болон бусдыг хэрхэн тодорхойлж буй талаарх ойлголт (identity), мөн бусдыг хэрхэн хүлээн зөвшөөрч буй талаарх үзэл санаа тодорхойлдог. Жишээлбэл, нэг улс нөгөөгөө "түнш" эсвэл "дайсан" гэж үзэх нь бодит үйл явцыг тодорхойлох үндсэн хүчин зүйл болдог.

Үндэсний аюулгүй байдлын тухайд конструктивизм нь зөвхөн цэрэг-улс төрийн хүчин зүйлээр хязгаарлахгүй, харин нийгмийн үнэт зүйл, түүхэн ухамсар, соёлын онцлог, үзэл суртлын хүчин зүйлсийн оролцоог тодотгож өгдөг.

Конструктивизм ба Монгол Улс

Конструктивизмын онолын үүднээс Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь зөвхөн материаллаг хүчин зүйлээр хязгаарлагдахгүй, харин түүхэн ухамсар, соёлын үнэт зүйл, олон улсын тавцанд өөрийгөө хэрхэн тодорхойлж буйгаас хамаардаг.

⁴ InternationalRelations.org — "Constructivism in International Relations"

Монгол Улс өөрийгөө “энхийг эрхэмлэгч, цөмийн зэвсэггүй бүс” гэж тодорхойлсноор олон улсын хамтын нийгэмлэгт эерэг имиж бүрдүүлж, аюулгүй байдлын баталгаагаа үзэл санааны түвшинд бэхжүүлсэн.

“Гуравдагч хөршийн бодлого” нь зөвхөн стратегийн сонголт бус, харин Монгол Улсын “нээлттэй, ардчилсан, энх тайвныг эрхэмлэгч” гэсэн үнэт зүйлийн илэрхийлэл юм.

Түүхэн ухамсар, нүүдэлчин соёлын өвөрмөц үнэт зүйл нь үндэсний дархлаа, аюулгүй байдлын ойлголтод нийгмийн бүтцийн хүчин зүйлсийн чухлыг харуулдаг.

Үндэсний аюулгүй байдлын онолын суурь зарчмуудад:

- Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах зарчим

Үндэсний аюулгүй байдлын гол цөм нь улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг баталгаажуулах явдал юм. Энэ нь гадаадын аливаа халдлага, колоничлол, эдийн засаг, соёлын хэт хамаарлаас ангид байхыг шаардана. Тусгаар тогтнол нь зөвхөн улс төрийн утгаар бус, эдийн засаг, нийгмийн тогтолцооны хувьд ч чөлөөт, бие даасан байдалд тулгуурлана.⁵

- Иргэн төвтэй хамгаалалтын зарчим

Аюулгүй байдлын онолын үндэс нь зөвхөн төрийн институцуудын аюулгүй байдал бус, иргэдийн амар амгалан, эрх чөлөө, нийгмийн баталгааг хамгаалахад чиглэнэ. Иргэн бол улс төрийн эрх мэдлийн суурь, нийгмийн тогтвортой байдлын баталгаа учир түүний амьдралын чанарыг хамгаалах нь үндэсний аюулгүй байдлын салшгүй бүрэлдэхүүн гэж үздэг.⁶

- Нэгдмэл байдал ба үндэсний эв нэгдлийн зарчим

Үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад дотоодын эв нэгдэл, ард түмний нийтлэг үнэт зүйлс чухал байр суурь эзэлдэг. Нийгмийн бүлгүүдийн хоорондын зохицол, улс төрийн тогтолцооны харилцан итгэлцэл нь дотоодын тогтвортой байдлыг хангах гол хүчин зүйл болж өгдөг.⁷

- Гадаад орчинтой тэнцвэрт харилцааны зарчим

Үндэсний аюулгүй байдал нь зөвхөн дотоод хүчин зүйлээр хязгаарлагдахгүй, харин олон улсын харилцааны орчинтой салшгүй уялдаатай. Улс орон гадаад орчинтойгоо тэнцвэртэй, харилцан ашигтай, үл довтолох зарчмыг баримталсан бодлого явуулах замаар өөрийн аюулгүй байдлыг баталгаажуулдаг.⁸

- Хөгжлийн тогтвортой байдлын зарчим

Аюулгүй байдал ба хөгжил хоёр харилцан нөхцөлдөх ойлголт юм. Хөгжлийн тэгш бус байдал, эдийн засгийн хамаарал, нийгмийн шударга бус байдал нь аюулгүй байдлын эрсдэлийг бий болгодог. Тиймээс урт хугацааны тогтвортой

⁵ ScienceDirect — Sovereignty (олон улсын эрх зүйн болон улс төр- Суверенитет — улс орны гадаад эрх мэдэл болон өөрөө удирдах чөлөөт байдлын хэлбэр)

⁶ The People-Centered Approach to Security — UNDP-ийн баримт бичиг, хүн төвтэй аюулгүй байдлын хандлага

⁷ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал — “Үндэсний эв нэгдэл” нь үндэсний язгуур ашиг сонирхол

⁸ Balance of Power Theory — PolSci Institute (тэнцвэрийн) хүчний онолд үндэслэн, улс орнууд гадаад орчны хүчнүүдтэй харьцан тэнцвэрт байдал.

хөгжилд чиглэсэн бодлого нь үндэсний аюулгүй байдлын онолын суурь зарчим болж өгнө.⁹

- Урьдчилан сэргийлэх ба дасан зохицох зарчим

Аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь зөвхөн шууд аюулд хариу үзүүлэхээс гадна урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, орчин үеийн сорилтод дасан зохицох чадварт суурилна. Энэ нь төрийн бодлого, стратегийн төлөвлөлтийн уян хатан байдлыг шаарддаг.

Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс нь олон талт зарчимд тулгуурладаг бөгөөд тэдгээр нь тусгаар тогтнол, иргэн төвтэй үзэл баримтлал, эв нэгдэл, гадаад харилцааны тэнцвэрт байдал, хөгжлийн тогтвортой байдал, урьдчилан сэргийлэх, дасан зохицох чадвар зэрэгт төвлөрдөг. Эдгээр зарчмуудыг оновчтой хэрэгжүүлснээр улс орон гадаад, дотоодын аюул заналд тэсвэртэй, тогтвортой хөгжлийг хангах үндэс сууриа бүрдүүлдэг.

Тусгаар тогтнол ба бүрэн эрхт байдал нь Улсын оршин тогтнолын баталгаа болдог.

Иргэдийн эрх, эрх чөлөө, нийгмийн тогтвортой байдал нь Аюулгүй байдлын нийгмийн суурь болно.

Хөгжлийн баталгаа нь Аюулгүй байдал зөвхөн хамгаалах биш, хөгжлийг хангах нөхцөлтэй уялддаг.

Нэгдмэл бодлого, үйл ажиллагаа нь Улс төр, эдийн засаг, цэрэг, нийгэм, мэдээлэл, эрх зүй, экологи зэрэг бүх салбарын нэгдмэл цогц бодлого, үйл ажиллагаагаар төлөвлөгдөж явагддаг.

Үндэсний аюулгүй байдлын бүтцийн гол чиглэлүүд:

- Улс төр, цэрэг-стратегийн чиглэл нь Гадаад орчны өөрчлөлт, хүчний харьцаа, геополитикийн хүчин зүйлүүдийг хамруулан авч үздэг.

- Эдийн засгийн чиглэл нь Үндэсний баялаг, нөөц, эдийн засгийн тогтвортой өсөлтийг авч үздэг.

- Нийгмийн ба хүмүүнлэгийн чиглэл нь Хүн амын аюулгүй байдал, боловсрол, эрүүл мэнд, соёлын оршин тогтнолыг хамруулан авч үзэг.

- Байгаль орчны чиглэл нь Экологийн тэнцвэр, байгалийн баялгийн зөв хувиарлалт, ашиглалтыг авч үздэг.

- Мэдээллийн чиглэл нь Үнэн зөв мэдээллийн урсгал, кибер аюулгүй байдлын асуудлуудыг авч үздэг.

Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны онол арга зүйн үндэс

“Үндэсний аюулгүй байдал” болон “Гадаад хамтын ажиллагааны онолын үндэс”-ийг судлахад нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй өргөн хэрэглэгддэг. Эдгээр ойлголтыг судлахдаа улс төр судлал, олон улсын харилцаа, аюулгүй байдлын судлалын уламжлалт болон орчин үеийн арга зүйг ашигладаг бөгөөд голчлон дараах арга зүй түгээмэл хэрэглэгддэг:

Онол-арга зүйн суурь арга

⁹ “Sustainability and National Security” — Drazen Smiljanić кгийн судалгаа санал болгож буй бичиглэл, тогтвортой хөгжил

- Философи-онолын шинжилгээ - Аюулгүй байдал, хамтын ажиллагааны үндсэн зарчим, ойлголтыг онолын түвшинд тайлбарлах, түүхэн-философийн хөгжлийн чиг хандлагатай холбон үздэг.¹⁰

- Системийн шинжилгээ - Улс орны дотоод, гадаад орчны хүчин зүйлсийг бүхэл системийн хүрээнд авч үзэж, харилцан хамаарлыг тайлбарлана.

- Харьцуулсан арга - Янз бүрийн улс орны үндэсний аюулгүй байдлын бодлого, гадаад хамтын ажиллагааны туршлагыг харьцуулж, ижил болон ялгаатай талуудыг илрүүлэх.

Түүхэн арга

- Улс орны аюулгүй байдал, гадаад бодлого, хамтын ажиллагааны онолын үзэл баримтлал түүхэн хугацаанд хэрхэн өөрчлөгдөж ирснийг судална.

- Түүхэн тохиолдлууд, олон улсын харилцааны практикийг шинжилснээр онолын үндсийг гүнзгий ойлгох боломж бүрддэг.

Эмпирик арга

- Баримт материалын шинжилгээ - Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомж, гадаад бодлогын баримт бичиг, олон улсын гэрээ хэлэлцээрийг задлан шинжлэх.

- Статистик, мэдээллийн дүн шинжилгээ - Аюулгүй байдал, хамтын ажиллагааны үзүүлэлтүүд (эдийн засгийн хамаарал, зэвсэглэл, худалдаа, дипломат харилцааны тоон мэдээлэл гэх мэт)-ийг ашиглан дүгнэлт гаргах.

Харьцуулалт ба судалгаа (case study)

- Тухайн улсын аюулгүй байдлын бодлого болон гадаад хамтын ажиллагааны тодорхой кейсийг сонгон авч судалснаар онолын зарчмуудыг практикт хэрхэн хэрэгжиж буйг шинжлэх.

- Жишээ нь: Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого, бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцсон туршлагыг судлах.

Интердисциплинар (олон салбарын хосолсон) арга

- Аюулгүй байдлыг зөвхөн улс төрийн хүрээнд бус эдийн засаг, нийгэм, соёл, мэдээлэл, экологийн уялдаа холбоотой авч үзэх.

- Социологи, эдийн засаг, олон улсын эрх зүй, стратегийн судалгааны аргуудыг хавсран ашигладаг.

Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны онолын үндсийг судлахад онолын (философи, систем, харьцуулалт), түүхэн, эмпирик, кейс судалгаа, интердисциплинар гэсэн арга зүйг хослуулан ашигладаг. Энэ нь зөвхөн онолын дүгнэлт гаргахаас гадна бодит нөхцөл байдалд уялдуулан практик ач холбогдолтой судалгаа хийх боломжийг бүрдүүлдэг. Үүнээс гадна доорх аргуудыг мөн ашигладаг.

- Аюул, эрсдэлийг урьдчилан мэдэх, үнэлэх, ангилах арга зүй.

- Урьдчилан сэргийлэх, саармагжуулах, даван туулах аргачлал.

- Бодлогын баримт бичиг, стратегийн төлөвлөлтөд тусгах

Энэ бүхнээс дүгнэхэд үндэсний аюулгүй байдлын онолын үндэс нь улс орны оршин тогтнол, хөгжлийг хангахтай холбоотой суурь ойлголт, зарчим, чиг хандлага, арга зүйн нэгдэл юм.

¹⁰ <https://www.tandfonline.com/doi/full/10.1080/18335330.2014.940822>

Үндэсний аюулгүй байдлыг хангах нь нь тухайн улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард түмний аюулгүй , эрх чөлөөтэй амьдрах орчин, нийгмийн тогтвортой байдал, эдийн засгийн хөгжил зэргийг дотоод болон гадаад заналхийллээс хамгаалж, баталгаажуулах үйл ажиллагааны цогц юм. Үндэсний аюулгүй байдал нь өргөн хүрээтэй цогц ухагдахуун бөгөөд тусгаар тогтнол нь улс орон гадаадын ямар нэгэн улс, байгууллагаас хараат бус, өөрийн дотоод, гадаад бодлогоо бие даан хэрэгжүүлэх эрхтэй байхыг хэлнэ. Бүрэн эрхт байдал нь улс орон өөрийн хууль тогтоомжийн хүрээнд бүх төрлийн асуудлаа шийдэх эрх мэдэлтэй байхыг илэрхийлдэг. Нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал нь улсын хил хязгаар гадаад, дотоодын аливаа хүчин зүйлээр зөрчихгүй байх, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хадгалж, хамгаалахыг хэлнэ. Газар нутгийн хяналт алдагдвал тусгаар тогтнолд заналхийлэл үүсдэг. Үндэсний ашиг сонирхол нь улс орон өөрийн оршин тогтнох, хөгжих иргэдийн сайн сайхан амьдралыг хангахад чиглэсэн хандлага бөгөөд энэ нь улс төрийн, эдийн засгийн, эргийн, байгаль орчин, соёлын, мэдээллийн ашиг сонирхол гэх мэт олон төрөл байдаг. Аюул заналхийлэл нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр болон бодитоор нөлөөлөх магадлалтай дотоод болон гадаад хүчин зүйлсийг авч үздэг бөгөөд энэ нь цэрэг-зэвсгийн, эдийн засгийн дарамт шахалт, гадаадын улс төрийн нөлөөлөл, хэт туйлширсан үзэл суртал, кибер халдлага, мэдээллийн дайн гэх мэт олон чиглэлээр илэрдэг. Үндэсний нэгдмэл байдал нь иргэд, үндэстэн, угсаа гарал, шашин шүтлэг үл харгалзан эх оронч үзэлтэй, эв нэгдэлтэй үндэсний язгуур эрх ашгуудаа хамгаалж, гадаадын хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх явдал гэж үздэг. Үндэсний аюулгүй байдал нь олон чиглэл бүрэлдэхүүн хэсгүүдтэй бөгөөд эдгээр нь мэдээллийн аюулгүй байдлын, гадаад бодлогын аюулгүй байдлын, хүнсний аюулгүй байдлын, эрчим хүчний аюулгүй байдлын, соёл иргэншлийн аюулгүй байдлын, эдийн засгийн аюулгүй байдлын, байгаль орчин, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын гэх мэтээр байдаг. Үндэсний аюулгүй байдлыг хангах гол субъектуудад Ерөнхийлөгч - ҮАБЗ-ийн тэргүүн, ҮАБЗ, Засгийн газар, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин, Тагнуулын ерөнхий газар, Цагдаа болон хил хамгаалах байгууллагууд болон бусад үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй агентлаг, байгууллагууд ордог. Үндэсний аюулгүй байдлын шинж чанарыг авч үзвэл уг ойлголт нь гадаад, дотоод нөхцөл байдал, цаг хугацаанаас болоод түүнийг хангах үйл ажиллагаа өөрчлөгдөж байдаг. Үндэсний аюулгүй байдлыг зөвхөн хамгаалах бус, аюулыг урьдчилан илрүүлэх, сэргийлэх, даван туулах чадварыг байнга шаардаж байдаг. Үндэсний аюулгүй байдлыг хангах нь үндэсний язгуур эрх ашгаа хамгаалах, тусгаар тогтнол болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах, иргэдийн аюулгүй, тогтвортой оршин амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, улмаар улс орны тогтвортой хөгжилд шаардлагатай орчныг бий болгоход чиглэж байдаг. Глобал буюу дэлхийн аюулгүй байдал нь хүн төрөлхтний нийтлэг эрх ашиг, оршихуйн үндэс болсон асуудлуудтай холбогддог. Үүнд: цөмийн зэвсгийн тархалт, уур амьсгалын өөрчлөлт, цар тахал, кибер аюул, терроризм зэрэг хил хязгааргүй аюул, заналхийлэл багтдаг. Глобал аюулгүй байдлыг хангах үйл явц нь олон улсын хамтын ажиллагаа, нэгдсэн бодлого, зохицуулалт, НҮБ болон бүс нутгийн байгууллагын оролцоонд тулгуурладаг. Энэхүү үйл явцад нэг улсын хүчин

чармайлт хангалтгүй бөгөөд бүх хүн төрөлхтний хамтын идэвхтэй хүчин чармайлт шаардлагатай байдагт оршино.

Гадаад хамтын ажиллагааны онолын үндэс:

Орчин үеийн дэлхий дахинд улс орнууд, аж ахуйн нэгжүүд, хувь хүмүүс хоорондын харилцан хамаарал улам бүр гүнзгийрч, гадаад хамтын ажиллагаа нь эдийн засаг, улс төр, соёл, нийгмийн хөгжлийн зайлшгүй нэгэн хэсэг болсон. Энэхүү үйл явц нь зөвхөн хил хязгаарыг давсан худалдаа, хөрөнгө оруулалт төдийгүй, харилцан итгэлцэл, үр өгөөжтэй түншлэлийг бий болгох зорилго агуулж байдаг. Олон улсын харилцааны орчин үеийн хөгжилд гадаад хамтын ажиллагаа нь улс орнуудын аюулгүй байдал, эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийг хангах гол хүчин зүйл хэвээр байсаар байна. Улс хоорондын хамтын ажиллагааны онол нь улс орнууд яагаад хамтран ажилладаг, хамтын ажиллагаа ямар нөхцөлд тогтвортой байдаг, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тайлбарлахад чиглэдэг. Энэ нь олон улсын харилцааны онолын суурь ойлголтуудын нэг бөгөөд улс төр судлал, эдийн засаг, аюулгүй байдал, дипломат харилцааны уялдааг зохицуулж хангах ач холбогдолтой. Гадаад хамтын ажиллагааны онол нь улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааны агуулга, зорилго, хэрэгжих арга хэлбэрийг тайлбарлаж, шинжлэх ухааны үндэслэлээр тодорхойлох онолын суурь ойлголтуудыг хамруулан авч судалдаг. Гадаад хамтын ажиллагаа нь улс орны бусад улс оронтой дипломат, эдийн засаг, нийгэм, цэрэг, шинжлэх ухаан, технологи, соёлын харилцаа хийх үйл ажиллагаа бөгөөд түүний зорилго нь харилцан ашигтай хамтын ажиллагаа, тогтвортой байдал, аюулгүй байдлыг нэмэгдүүлэх явдал байдаг.

Гадаад хамтын ажиллагааны онолын суурь хандлага

- Реализм - Аюулгүй байдал, эрх мэдэл, хүчний тэнцвэрт тулгуурласан хамтын ажиллагаа
- Либерализм - Олон улсын байгууллага, дүрэм журам, харилцан ашиг сонирхолд тулгуурласан хамтын ажиллагаа
- Конструктивизм - Үнэ зүйл, соёл, үзэл санаа, итгэлцлийн нөлөөгөөр хамтын ажиллагааг бүрдүүлэх тухай.
- Кейнсийн эдийн засгийн онол, неолиберал институционализм нь олон талт хамтын ажиллагааг тогтвортой байлгах гол хүчин зүйл нь болдог.

Реализмын хандлага

Реализмын онолд улс орнууд хамтын ажиллагааг үндсэндээ үндэсний ашиг сонирхол болон аюулгүй байдлаа хамгаалах механизм гэж үздэг. Хамтын ажиллагаа нь түр зуурын шинжтэй бөгөөд улс бүрийн зорилго бол өөрийн хүч чадлыг нэмэгдүүлэх, өрсөлдөгчийн давуу байдлыг сааруулахад чиглэнэ гэж тайлбарладаг (Morgenthau, 1948). Тиймээс реализмд хамтын ажиллагаа тогтворгүй, хүчний тэнцвэрийн хүрээнд хязгаарлагдмал байдаг.¹¹

Либерализмын хандлага

Либерализм нь хамтын ажиллагааг олон улсын байгууллага, эрх зүй, эдийн засгийн харилцан хамаарал дээр суурилж тогтвортой хөгжиж болохыг онцолдог.

¹¹ <https://plato.stanford.edu/archives/fall2014/entries/realism-intl-relations/>

Либералистуудын үзэж байгаагаар, улс орнууд хамтын ажиллагаагаар дамжуулан нийтлэг ашиг сонирхлоо дээдэлж, энх тайван ба хөгжилд хүрэх боломжтой (Keohane & Nye, 1977). Ардчиллын энх тайвны онол, бүс нутгийн интеграцийн онол нь либерализмын хандлагын тод жишээ юм.¹²

Конструктивизмын хандлага

Конструктивизм нь хамтын ажиллагааг зөвхөн материаллаг ашиг сонирхолд тулгуурлахгүй, харин үзэл санаа, үнэт зүйл, нийгмийн бүтцийн бүтээгдэхүүн гэж үздэг. Улсуудын хоорондын хамтын ажиллагаа нь тэдний өөрийн болон бусдын дүр төрх (identity), харилцан ойлголцол, соёлын үнэт зүйлсээс хамаарч бүрэлддэг (Wendt, 1992). Жишээлбэл, ижил түүх, соёлын суурьтай орнуудын хооронд хамтын ажиллагаа илүү бат бөх тогтох магадлал өндөр.¹³

Харьцангуй Давуу Талын Онол (Theory of Comparative Advantage)

Эдийн засгийн ухаанд Дэвид Рикардогийн боловсруулсан харьцангуй давуу талын онол нь гадаад хамтын ажиллагаа, тэр дундаа олон улсын худалдааны хамгийн суурь онол юм. Энэ онолын гол санаа нь улс орнууд тухайн бүтээгдэхүүнийг бусад улс орноос харьцангуй бага зардлаар үйлдвэрлэх боломжтой бол түүнийгээ дагнан үйлдвэрлэж, харин өөр улс орноос харьцангуй өндөр зардлаар үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнээ худалдан авах ёстой гэдэгт оршино. Жишээлбэл, Монгол улс мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг бусад улсаас харьцангуй бага өртөгтэйгөөр үйлдвэрлэж, харин технологийн бүтээгдэхүүнийг өндөр өртгөөр үйлдвэрлэдэг бол, технологийн дэвшилтэт улс (жишээлбэл, Япон) эсрэгээрээ байдаг. Энэ тохиолдолд Монгол мал аж ахуйн бүтээгдэхүүн, Япон технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хоорондоо худалдаа хийснээр хоёр тал хоёулаа үр ашигтай ажиллах боломжтой юм. Энэ онол нь гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, болон бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны үндсэн суурь болдог.¹⁴

Институционализм (Institutionalism)

Гадаад хамтын ажиллагааг зөвхөн эдийн засгийн ашиг сонирхлоор тайлбарлахад хангалтгүй. Энд институционализм чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ онол нь гадаад хамтын ажиллагааг зохицуулдаг олон улсын байгууллага, гэрээ, хэм хэмжээ, болон хууль тогтоомжийн үүргийг онцлон үздэг. Институционализмын үндсэн санаа нь: Олон улсын байгууллагууд: НҮБ, Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ), Европын Холбоо (ЕХ) зэрэг байгууллагууд нь улс хоорондын харилцааг дэмжиж, хамтын ажиллагааны тогтвортой орчныг бүрдүүлдэг. Хэм хэмжээ ба дүрмүүд: Гадаад хамтын ажиллагааг зохицуулдаг бичмэл болон бичигдээгүй дүрэм, хэм хэмжээнүүд нь үл итгэлцлийг бууруулж, урьдчилан таамаглах боломжтой харилцааг бий болгоно. Жишээлбэл, олон улсын худалдааны гэрээнүүд нь бараа, үйлчилгээний худалдааны дүрэм журмыг тодорхойлдог.

¹² Robert O. Keohane & Joseph S. Nye — *Power and Interdependence* либералист (neo-liberal)

Institutionalism-ийн гол суурь, олон улсын хамтын ажиллагаа, институт, харилцан хамаарлын онол.

¹³ https://www.researchgate.net/publication/239065011_A_Social_Theory_of_International_Politics

¹⁴ <https://competitionandappropriation.econ.ucla.edu/wp-content/uploads/sites/95/1970/01/Principles-of-Political-Economy-and-Taxation-1817.pdf>

Институционализм - гадаад хамтын ажиллагаа нь зөвхөн улс орнуудын ашиг сонирхлоос гадна, тэдгээрийг зохицуулж буй дүрэм журмаар тодорхойлогддог.¹⁵

Харилцан Хамаарлын Онол (Theory of Interdependence)

Харилцан хамаарлын онол нь гадаад харилцаанд зөвхөн улс төрийн болон цэргийн хүчин чадал чухал бус, харин эдийн засаг, нийгэм, соёлын харилцаа чухал болохыг онцолдог. Энэ онолын гол төлөөлөгчдийн нэг болох Роберт Кеохане болон Жозеф Най нар нь дараах хоёр төрлийн харилцан хамаарлыг тодорхойлсон: Мэдрэмжийн харилцан хамаарал: Нэг улсын үйлдэл нөгөө улсын хувьд шууд мэдрэгдэх, гэхдээ тэдгээр нь бодлогын хэмжээнд хариу үйлдэл үзүүлэхэд хүргэхгүй байх. Жишээлбэл, газрын тосны үнийн өсөлт нь импортлогч улс орнуудын эдийн засагт шууд нөлөөлөх зэрэг хамаарлыг дурдаж болно.

Харилцан хамаарал: Аливаа улс орон болон байгууллагын харилцан хамаарал илүү гүнзгий хүнд хэлбэрээр нөлөөлж болзошгүй үйл ажиллагааг хэлэх юм. Нэг улсын бодлогын өөрчлөлт нөгөө улсын хувьд ашиг сонирхол, эдийн засагт нь ноцтой хохирол учруулж болзошгүй бөгөөд энэ нь зөвхөн эдийн засаг, батлан хамгаалах салбаруудаар хязгаарлагдахгүй хамтын ажиллагааны бүхий салбарыг хамран үйлчилж байдаг. Жишээлбэл, нэг улсын хилээ хаах шийдвэр нь нөгөө улсын эдийн засгийн хувьд ноцтой үр дагавар авчрах. Харилцан хамаарлын онол нь гадаад хамтын ажиллагаа нь өөрийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд бусад улс орнуудтай хамтран ажиллах зайлшгүй шаардлагад тулгуурладаг гэдгийг тайлбарладаг. Учир нь нэг талын үйлдэл нь бусад бүх оролцогч талуудад үр дагавар авчирдаг.¹⁶

Неореализм ба Гадаад Хамтын Ажиллагаа

Неореализм нь олон улсын харилцааг улс орнуудын эрх мэдэл, аюулгүй байдлын төлөөх тэмцэл гэж үздэг. Энэ онол нь гаднын хамтын ажиллагааг хязгаарлагдмал, түр зуурын шинжтэй гэж үздэг. Неореализмын гол төлөөлөгч Кеннет Уолтз нь улс орнууд бусад улс орнуудыг хэт хүчирхэгжихээс сэргийлж, эрх мэдлийн тэнцвэрийг хадгалахыг зорьдог гэж үздэг. Энэхүү онолын үүднээс харвал гадаад хамтын ажиллагаа нь зөвхөн дайсагнагч улс орны эсрэг эвсэл байгуулах, эсвэл түр зуурын ашиг сонирхлын хүрээнд үүсдэг. Энэ онол нь гадаад хамтын ажиллагааны тогтвортой байдалд үл итгэх хандлагатай бөгөөд улс орнуудын дотоод аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхол нь гадаад хамтын ажиллагаанаас илүү чухал гэж үздэг.¹⁷

Гадаад хамтын ажиллагааны онолын үндэс нь нэг цогц ойлголт биш, харин олон салбарын онолуудын нэгдэл юм. Харьцангуй давуу талын онол нь эдийн

¹⁵ <https://humanityontrial.com/bully-states-and-global-anarchy/four-perspectives-on-international-relations/institutionalism-in-international-relations/>

¹⁶

https://www.researchgate.net/publication/233093052_INFORMATION_INTERDEPENDENCE_Keohane_and_Nye%27s_complex_interdependence_in_the_information_age

¹⁷ <https://www.globalsecurity.org/military/library/report/1995/WWZ.htm>

засгийн үндсэн шалтгааныг тайлбарлаж, институционализм нь энэхүү харилцааг зохицуулж буй дүрмийг онцолдог. Харин харилцан хамаарлын онол нь орчин үеийн нийгмийн харилцан уялдаатай байдлыг тодотгож, неореализм нь гадаад хамтын ажиллагааг эрх мэдлийн тэнцвэрт байдлын хүрээнд хязгаарлагдмал гэж үздэг. Өнөөгийн дэлхий ертөнцөд эдгээр бүх онолууд харилцан уялдаатайгаар оршин тогтнож байна. Улс орнууд эдийн засгийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхийн тулд олон улсын байгууллагуудад нэгдэж, харилцан хамаарлын нөхцөлд амьдарч байна. Иймд гадаад хамтын ажиллагаа нь зөвхөн нэг талын ашиг сонирхлоор бус, харин бүх талын оролцоо, итгэлцэл, урт хугацааны үр ашигт тулгуурласан цогц үйл явц юм. Цаашид энэхүү үйл явц нь дижитал хувьсал, уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн цар тахал зэрэг шинэ сорилтуудтай нүүр тулах тусам онолын шинэ чиг хандлагууд бий болох нь гарцаагүй.

Гадаад хамтын ажиллагааны суурь зарчим

- Тэгш эрх, тусгаар тогтнолыг хүндэтгэх
- Дотоод хэрэгт нь үл оролцох
- Харилцан ашигтай байдал
- Итгэлцэл, харилцан ойлголцол
- Хүний эрх, ардчиллын үнэт зүйл¹⁸

Гадаад хамтын ажиллагааны чиглэлүүд

• Аюулгүй байдал, батлан хамгаалах нь итгэлцэл, зэвсэглэлийг хязгаарлах, хамтарсан сургалт, энхийг сахиулах ажиллагаа.

• Эдийн засаг нь худалдаа-чөлөөт худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн интеграци.

• Нийгэм, соёл- боловсрол, шинжлэх ухаан, соёлын солилцоо.

• Хүний аюулгүй байдал нь уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, цар тахал, нийгмийн асуудлаар хамтран ажиллах

Гадаад хамтын ажиллагааны хэлбэр

• Хоёр талын (bilateral) -хоёр улсын хоорондын харилцаа.

• Олон талын (multilateral) -бүс нутгийн болон олон улсын байгууллагаар дамжсан хамтын ажиллагаа НҮБ, АСЕАН, ШХАБ гэх мэт.

• Глобал түвшин - уур амьсгалын өөрчлөлт, кибер аюулгүй байдал, терроризм зэрэг дэлхийн хамтын сорилт.¹⁹

Гадаад хамтын ажиллагааны судалгааны арга зүй

• Харьцуулалт (түр зуурын болон урт хугацааны)

• Түүхэн -онолын задлан шинжилгээ

• Системийн шинжилгээ(олон улсын систем дэх байр суурь)

• Институцийн дүн шинжилгээ (байгууллагын үүрэг, нөлөө)²⁰

Өөрөөр хэлбэл гадаад хамтын ажиллагааны онолын үндэс олон улсын харилцааны онол, хамтын ажиллагааны зарчим, чиглэл, хэлбэр, түвшин болон

¹⁸ <https://www.cambridge.org/core/journals/leiden-journal-of-international-law/article/abs/principle-of-nonintervention/7EE9EC769A3F2CEE10E3DEE1CB30E274>

¹⁹ <https://mongolia.un.org/mn/sdgs/13>

²⁰ https://uk.sagepub.com/sites/default/files/upm-assets/120704_book_item_120704.pdf

судалгааны арга зүйг цогцоор нь авч үзэн ойлгож, улс орнуудын харилцааг онолын хүрээнд тайлбарлахыг багтаан авч үзэж байна.

Гадаад хамтын ажиллагаа нь улс орон байгууллага, эсвэл хувь хүн гадаадын бусад улс орон, байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагаа юм. Энэхүү хамтын ажиллагаа нь олон талт, салбар бүрд өрнөдөг бөгөөд олон улсын харилцаа, дипломат ёс, хууль эрх зүй, эдийн засаг, соёлын харилцаа зэрэг чиглэлүүдээр өргөждөг. Гадаад хамтын ажиллагааны үндсэн зорилго нь хоорондын итгэлцлийг бий болгох, ашиг сонирхлыг зохицуулах, харилцан хамаарал дээр тулгуурлан тогтвортой байдлыг хангах явдал байдаг. Тэгш бус хүчний харилцаанд ч гэсэн хамтын ажиллагаа зайлшгүй хэрэгтэй байдаг. Итгэлцэл нь хамтын ажиллагааны амин сүнс нь бөгөөд итгэлцэл байхгүй бол гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт доголддог. Хамтын ажиллагаа нь зөрчил, маргааныг шийдвэрлэх арга хэрэгсэл болдог. Олон улсын харилцаанд “зөрчил-хамтын ажиллагаа зэрэгцэн оршдог. Тухайлбал, хоёр тал эдийн засгийн салбарт хамтран ажиллаж байхдаа аюулгүй байдлын салбарт өрсөлдөж, зөрчилдөж байдаг. Гадаад хамтын ажиллагаанд (hard power) хатуу хүч-цэрэг, эдийн засгийн дарамтаар хамтын ажиллагаанд нөлөөлөх, (soft power) зөөлөн хүч-соёл, үнэт зүйл, дипломат арга, итгэлцлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх, Орчин үед (smart power) буюу хосолсон хүчийг ашиглах үзэл дэлгэрч байна. Өнөө үед глобалчлал нь улс орнуудын асуудлыг дангаар шийдэх боломжийг багасгаж, хамтын ажиллагааны зайлшгүй шаардлагыг бий болгож байна. Тухайлбал, терроризм, уур амьсгалын өөрчлөлт, кибер аюулгүй байдал, хар тамхины сүлжээ гэх мэт.

1.2 ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХАМААРАЛ

21-р зуунд дэлхийн улс орнуудын харилцаа улам бүр харилцан уялдаа, хамааралтай болж, үндэсний аюулгүй байдал зөвхөн дотоод хүчин зүйлээс бус, гадаад орчны өөрчлөлтөөс гүн гүнзгий хамаарах боллоо. Эдийн засгийн даяаршил, бүс нутгийн интеграци, технологийн дэвшил, харилцаа холбооны хурд нэмэгдэхийн хэрээр улс орнуудын аюулгүй байдал зөвхөн хил, нутаг дэвсгэрийн баталгаагаар хэмжигдэхгүй, харин эдийн засаг, нийгэм, мэдээлэл, байгаль орчны олон талт хүчин зүйлсийг хамрах шаардлагатай болоод байна. Үндэсний аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагааны уялдаа, хамаарал, нөлөөллийн асуудал нь төрийн бодлогын стратегийн чухал сэдэв бөгөөд олон улсын харилцаа, аюулгүй байдлын чиглэлд өргөн хэрэглэгддэг судлагдахуун юм. Тиймээс үндэсний аюулгүй байдал болон гадаад хамтын ажиллагааны харилцан хамаарал, нөлөөллийг онол, туршлага, бодит жишээгээр судлах нь Монгол Улсын стратегийн шийдвэр гаргалтад бодлогын түвшний ач холбогдолтой гэж үзэж байна. Үндэсний аюулгүй байдал ба гадаад хамтын ажиллагаа хоорондоо салшгүй холбоотой, бие биеэ нөхөж, хамгаалдаг систем юм. Монголын хувьд гадаад бодлогын тэнцвэртэй, олон тулгуурт чиг хандлага нь үндэсний аюулгүй байдлыг хангах гадаад хамтын ажиллагааны үндсэн чиглэл байна.

Үндэсний аюулгүй байдал хангагдсан байх нь улс орон бүрийн оршин тогтнол, хөгжил дэвшлийн гол баталгаа юм. Орчин үеийн олон улсын харилцааны нөхцөлд үндэсний аюулгүй байдлыг хангах нь зөвхөн дотоод хүчин зүйлсээр хязгаарлагдахгүй бөгөөд гадаад харилцаа, дипломат бодлого, бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагаатай салшгүй уялдаатай байдаг.

Үндэсний аюулгүй байдал гэдгийг өмнө нь уламжлалт улс төр, цэрэг, дайны заналхийлэлтэй холбон ойлгож байсан бол өдгөө эдийн засгийн хямрал, байгалийн гамшиг, халдварт өвчин, соёл иргэншил, мэдээлэл харилцааны шинэ орчин, нийгмийн сэтгэл зүйд учирч буй уламжлалт бус аюул, заналыг харгалзах шаардлага буй болж, улс төр, дипломатын аргаар асуудлыг шийдэх хандлага тогтож байна.

Үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт, цар хүрээ, хангах арга зам өргөжиж, тулгамдсан асуудлыг цогцоор нь авч үзэх, зөвхөн төрийн ашиг сонирхлыг хамгаалах бус төр, хувь хүн, хуулийн этгээдийн ашиг сонирхлыг аль алиныг нь тэнцвэртэй хангахад чиглэгдэж, аюулгүй байдлыг судлалын гол төвд иргэнийхээ аюулгүй байдалд чухалчилж үздэг болж байна. Хүний эрх, эрх чөлөөний баталгаа, аюулгүй хангалуун амьдрал нь нийгмийн тогтвортой байдал, хөгжил дэвшлийн суурь болсноор үндэсний аюулгүй байдлыг хангах таатай нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

ҮАБ нь улс орны төрийн эрх мэдэл, газар нутгийн бүрэн бүтэн байдал, иргэдийн амьжиргаа, эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн тогтвортой байдал, соёлын өв зэрэг үндэсний эрх ашигт занал учруулах аливаа эрсдэлээс хамгаалагдсан байдал юм. Өрөөр хэлбэл Үндэсний аюулгүй байдал нь улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж, иргэдийн эрх чөлөө, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагааны нэгдлээр хангагддаг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд (2010) үндэсний аюулгүй байдлыг эдийн засаг, нийгэм, мэдээлэл, оршин тогтнох,

дотоод, хүний, хүрээлэн байгаа орчны зэрэг бүрэлдэхүүнтэйгээр тодорхойлсон байдаг.

ҮАБ болон гадаад хамтын ажиллагаа нь нь хэд хэдэн нийтлэг үйл ажиллагааны чиглэлүүдээр харилцан тодорхойлогддог. Тухайлбал, цэргийн аюулгүй байдлыг хангах нь гаднын довтолгоо, терроризм, зэвсэгт мөргөлдөөн, болзошгүй түрэмгийллийг эсэргүүцэх чиглэлд дотоод, гадаад үйл ажиллагаагаа явуулдаг.

Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нь валютын ханшийн хэлбэлзэл, импортын хараат байдал, санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн хувьд нэг улсаас хараат байхаас сэргийлж дотоод талдаа арга хэмжээ авах, гадаад хамтын ажиллагаа нь үүнийг дэмжсэн ажиллагааг гадаад харилцаагаар дамжуулж хийдэг.

Нийгмийн аюулгүй байдлыг хангах нь ажилгүйдэл, ядуурал, нийгмийн бухимдал, төрд итгэх итгэл буурах, ард түмний амьдралын чанарыг хангах зэрэг анхаарч үйл ажиллагаагаа чиглүүлдэг бол гадаад хамтын ажиллагаагаар энэ бодлогыг дэмждэг. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах нь кибер аюул, мэдээллийн гадаад нөлөөллийг хамгаалахад чиглэдэг.

Үндэсний аюулгүй байдал гэдэг ойлголт цаг хугацааны явцад өргөжин тэлж ирсэн. Уламжлалт ойлголтоор бол улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг хамгаалахтай холбогддог байсан бол өнөөдөр эдийн засаг, нийгэм, мэдээлэл, кибер орчин, хүрээлэн буй орчны аюулгүй байдал зэрэг олон чиглэл хамрагдах болсноос улбаалж, гадаад хамтын ажиллагааны үүрэг, оролцоо өсөж байна. Гадаад харилцаа нь дээр дурдсан чиглэл бүрд уялдаа холбоотойгоор нөлөөлдөг. Олон улсын харилцааны онолын хандлагуудаас реализм нь цэрэг-улс төрийн хүчин чадлыг чухалчилдаг бол либерализм нь хамтын ажиллагаа, олон талт дипломатын ач холбогдлыг онцолдог. Харин конструктивизм нь улс хоорондын харилцаанд үнэт зүйл, үнэмшил, соёлын нөлөөг тайлбарладаг. Монгол Улс эдгээр онолын хандлагыг өөрийн онцлог нөхцөлд зохицуулан ашиглаж ирсэн.

Гадаад бодлого нь улс орны болон олон улсын орчинд хэрхэн харилцах, өөрийн ашиг сонирхлоо хамгаалах стратеги юм. Энэ нь дипломат, эдийн засгийн, цэргийн, соёлын болон технологийн чиглэлээр илэрч болно.

Гадаад бодлого нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг бүрд өөрийн зорилгыг агуулж үйл ажиллагааг явуулдаг. Тухайлбал,

- ҮАБ-г хангах нь гаднын аюул занал, сорилтод бэлэн байх.
- Эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах: худалдаа, хөрөнгө оруулалт, стратегийн түншлэлийг хөгжүүлэх.
- Дипломат харилцааг бэхжүүлэх: олон улсын байгууллага, холбоо, гэрээ хэлэлцээрээр улс орноо хамгаалах.²¹

Гадаад хамтын ажиллагаа нь улс орнуудын хооронд олон талт, хоёр талт хэлбэрээр харилцан ашигтай харилцаа тогтоох үйл явц бөгөөд дараах чиглэлүүдийг хамардаг ба энэ нь үндэсний аюулгүй байдлын баталгаанд шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг. Үүнд:

- Дипломат харилцаа - улс төрийн итгэлцэл, гэрээ хэлэлцээр
- Эдийн засгийн хамтын ажиллагаа - худалдаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн туслалцаа

²¹ <https://igovernment.mn/docs/418>

- Батлан хамгаалах хамтын ажиллагаа - хамтарсан сургалт, энхийг сахиулах ажиллагаа, зэвсэг техникийн солилцоо, хамтын ажиллагаа, итгэлцлийг бий болгох
- Соёл, боловсрол, шинжлэх ухаан - хүний нөөцийн чадавх нэмэгдүүлэх, харилцан ойлголцлыг бэхжүүлэх,²²

Монгол Улсын хувьд “гуравдагч хөршийн бодлого”-д тулгуурласан олон тулгуурт гадаад харилцааны стратеги нь Үндэсний аюулгүй байдлын баталгааны чухал хэрэгсэл болсоор байна.

Гадаад хамтын ажиллагаа нь зөвхөн эдийн засгийн хөгжилд бус, улс төрийн тогтвортой байдал, батлан хамгаалах чадавх, бүс нутгийн энх тайван, итгэлцлийг хангахад чухал нөлөө үзүүлдэг. Ер нь гадаад хамтын ажиллагаа бол аюулгүй байдлын баталгааны олон давхар хамгаалалт болдог. Энэ нь хөршүүдтэйгээ сайн харилцаа тогтоох нь хил орчмын тогтвортой байдлыг бий болгодог. Олон улсын түншлэл нь улс оронд эдийн засгийн болон ямар нэг хямралт байдал үүсэхэд дэмжлэг авах боломжуудыг олгодог.

Үндэсний аюулгүй байдлыг хангахад гадаад харилцаа маш чухал стратегийн үүрэгтэй байдаг. Энэ нь зөвхөн улс хоорондын дипломат холбоо төдий бус, улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эдийн засгийн тогтвортой байдал, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шууд нөлөөлдөг. Үүргийг нь дараах хэдэн чиглэлийн хүрээнд авч үзье.

Улс төр, дипломат аюулгүй байдал

- Гадаад харилцаагаар дамжуулан улс орон олон улсын тавцанд хууль ёсны байр сууриа бэхжүүлж, тусгаар тогтнолоо хамгаалдаг.
- Найрсаг харилцаа, хамтын ажиллагаа нь зөрчил, мөргөлдөөнийг урьдчилан сэргийлэх баталгаа болдог.
- Дипломат хэлэлцээ, олон улсын байгууллагуудын хүрээнд оролцож, хамтран ажилласнаар жижиг, дунд улсууд ч аюулгүй байдлын баталгааг олж авдаг.²³

Цэрэг-стратегийн аюулгүй байдал

- Гадаад харилцааны нэг хэсэг болох батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаа нь зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх, сургалт, техник, технологийн солилцоонд чухал нөлөөтэй.

- Олон улсын цэргийн итгэлцэл, хамтын ажиллагаа нь бүс нутгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулж, улс орон руу чиглэсэн цэргийн дарамтыг бууруулдаг.²⁴

Эдийн засгийн аюулгүй байдал

- Гадаад харилцаа нь гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн түншлэл-ийг хөгжүүлснээр дотоодын эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй.

- Эдийн засгийн олон тулгууртай харилцаа нь нэг талын хараат байдлаас хамгаалдаг.

²² <https://www.gov.mn/mn/organization/mofa/service?documentId=3&serviceId=6347bceb-547e-4ff1-8264-48028e08eb50>

²³ <https://igovernment.mn/docs/412>

²⁴ <https://www.iss.gov.mn/wp-content/uploads/2023/03/toim-14-0228.pdf>

Нийгэм, соёлын аюулгүй байдал

Гадаад харилцаагаар дамжуулан соёл, боловсролын солилцоо, ардчиллын үнэт зүйлс, хүний эрхийн хамгаалалт сайжирдаг. Энэ нь иргэдийн сэтгэлзүйн болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах суурь болдог.

Бүс нутгийн болон дэлхийн хамтын ажиллагаа

Улс орон бүс нутгийн хамтын ажиллагааны механизмд идэвхтэй оролцсоноор хамтын аюулгүй байдлын баталгааг бэхжүүлдэг. (жишээ нь: НҮБ, ШХАБ, АСЕМ, ARF, CICA гэх мэт)

Глобал аюул занал (терроризм, уур амьсгалын өөрчлөлт, цар тахал, кибер аюул гэх мэт)-ыг ганцаараа даван туулах боломжгүй, зөвхөн гадаад харилцаагаар дамжуулан хамтын хүчээр шийдвэрлэх боломжтой.

Гадаад харилцаа бол үндэсний аюулгүй байдлыг хангах чухал хэрэгсэл бөгөөд улс орон дотоод бат бөх суурьтайгаа уялдуулан олон улсын орчинд идэвхтэй, ухаалаг байр суурьтай байх нь хамгийн чухал гэж үзэж байна.

Аюулгүй байдал нь гадаад хамтын ажиллагааны үндэс болдог бөгөөд дотоод улс төрийн байдал тогтворгүй, батлан хамгаалах чадавх сул бол гадаад харилцааны өргөн хүрээний боломжууд бүрэн дүүрэн ашиглагдаж чаддаггүй. Аюулгүй байдлаа хангахын тулд гадаад хамтын ажиллагаа хөгжих ёстой, харин гадаад хамтын ажиллагаа амжилттай байх нь аюулгүй байдлын бат бөх сууринаас хамаардаг.

Эдгээр хоёр ойлголт хоорондоо шингэцтэй, харилцан хамааралтай байдаг. Тодруулбал үүнд:

Гадаад бодлого нь үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэнэ:

Дипломат харилцаа, олон улсын гэрээ хэлэлцээр нь цэргийн болон эдийн засгийн аюулгүй байдалд шууд нөлөөлнө.

Жишээ: Хөрш орнуудтай энх тайвны гэрээ байгуулах, худалдааны гэрээ хэлэлцээр нь дотоодын тогтвортой байдлыг нэмэгдүүлнэ.²⁵

Үндэсний аюулгүй байдал нь гадаад бодлогыг тодорхойлдог:

Улс орны аюулгүй байдлын шаардлагаас шалтгаалан гадаад бодлого боловсруулагдана.

Жишээ: Цэргийн аюулгүй байдалд аюул, занал учирч байвал, улс зэвсэг техникийн түншлэл, цэргийн эвсэл, холбоо зэрэг олон улсын байгууллагад хандах, оролцох бодлого хэрэгжүүлнэ.

Эдийн засгийн болон нийгмийн аюулгүй байдал нь гадаад бодлогыг чиглүүлдэг:

Жижиг орнууд гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, олон улсын дэмжлэгээр эдийн засгийн тогтвортой байдлаа хангах бодлого явуулдаг.

Жишээ: Монгол Улс нүүрс, зэс, байгалийн баялгаа гадаадын хөрөнгө оруулалт, худалдаагаар хамгаалах бодлого хэрэгжүүлдэг.

²⁵ <https://www.gov.mn/mn/organization/mfa>

Удирдлага, стратегийн уялдаа:

ҮАБ ба гадаад бодлогын хооронд стратегийн уялдаа байхгүй бол бодлого, үйл ажиллагаа хоорондоо зөрчилдөж, эрсдэл нэмэгддэг.

Жишээ: Хэт нэг талд төвлөрсөн гадаад бодлого нь зарим аюулгүй байдлын асуудлыг мартагдуулж, саармагжуулах эрсдэлтэй

Дэлхийн жишээ

АНУ: ҮАБ-ийн үндсэн баримт бичиг (National Security Strategy) нь гадаад бодлогын чиглэлүүдийг тодорхойлж, дэлхийн цэргийн, эдийн засгийн болон дипломат харилцаанд чиглэл өгдөг.

Монгол Улс: Батлан хамгаалах бодлого, олон талт гадаад бодлого нь хөрш орнууд, бүс нутгийн аюулгүй байдлыг харгалзан боловсруулагддаг

ҮАБ болон гадаад бодлого нь хоорондоо харилцан уялдаа бүхий, нэг нэгнийхээ үндэс, баталгаа болдог. Улс орны эрх ашиг, тогтвортой байдал, эдийн засгийн хөгжил, нийгмийн эв нэгдлийг хамгаалахад хамтдаа үйлчилдэг. ҮАБ-г хангахын тулд гадаад бодлого зөв төлөвлөгдсөн, бүх түвшинд нэгдмэл байх ёстой.

ҮАБ, Гадаад хамтын хамтын ажиллагааны хамаарал

ҮАБ, гадаад хамтын ажиллагааны ерөнхий чиглэлүүд	Үндэсний аюулгүй байдалд үзүүлэх эерэг нөлөө	Эрсдэл, сорилт
Эдийн засгийн хамтын ажиллагаа	Худалдаа, хөрөнгө оруулалт нэмэгдэж эдийн засгийн бат бөх байдал хангагдана. Нийгмийн тогтвортой байдал дээшилнэ.	Гадаад зах зээл хэт хараат болбол эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй
Батлан хамгаалах хамтын ажиллагаа	Итгэлцэл бий болох, хамтарсан сургуулилт, зэвсэг техникийн шинэчлэл, энхийг сахиулах оролцоо идэвхжиж, аюул сөрөг чадвар дээшилнэ.	Гадаад цэргийн эвсэл, түншлэлтэй буруу харилцаа тогтоовол стратегийн эрсдэл үүсэж болзошгүй
Улс төр, дипломатын харилцаа	Хөрш болон стратегийн түншүүдтэй сайн харилцаа тогтоох, болзошгүй мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх	Улс төрийн ашиг сонирхлын зөрчилдөөнд татагдан орох
Соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа	Зөөлөн хүчний нөлөөлөл нэмэгдэж, үндэсний имиж сайжирч, олон улсын итгэлцэл нэмэгдэнэ.	Соёлын нөлөөгөөр дамжин дотоод үнэт зүйлд нөлөөх эрсдэл

Үндэсний аюулгүй байдал болон гадаад хамтын ажиллагаа нь олон чиглэлээр бие биедээ нөлөөлдөг бөгөөд энэ нөлөөлөл нь эерэг болон сөрөг үр дагавартай байж болно. Энэ хэсэгт эдгээр харилцан нөлөөллийг эдийн засаг, батлан хамгаалах, дипломат, соёл, технологи болон мэдээллийн түвшинд авч үзье.

Эдийн засгийн хамтын ажиллагаа ба эдийн засгийн аюулгүй байдал

Эерэг нөлөө

- Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал нэмэгдэж, үндэсний орлогын бааз өргөжин.
- Эдийн засгийн олон тулгуурт бүтэц бүрдэж, ганц зах зээлээс хараат байдлыг бууруулна.
- Хамтарсан төсөл, санхүүгийн туслалцаагаар дэд бүтэц, үйлдвэрлэлийн чадавх нэмэгдэнэ.

Сөрөг нөлөө

- Гадаад зах зээлд хэт хараат болбол эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл үүснэ.
- Импортын хэт хамаарал нь үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг бууруулна.
- Эдийн засгийн хориг, худалдааны маргаан нь аюулгүй байдалд сөрөг үр дагавар авчирна.

Жишээ: Монгол Улс БНХАУ-д нүүрсний экспортын 89 орчим хувиар хараат байдал нь богино хугацаанд эдийн засгийн ашигтай боловч урт хугацаанд эрсдэл дагуулж болзошгүй.

Батлан хамгаалах хамтын ажиллагаа ба цэргийн аюулгүй байдал

Эерэг нөлөө

- Хамтарсан сургуулилт, цэргийн сургалт, зэвсэг техникийн шинэчлэлээр батлан хамгаалах чадавх сайжирна.
- Энхийг сахиулах ажиллагаанд оролцох нь олон улсын нэр хүндийг өсгөж, стратегийн түншлэлийг өргөжүүлнэ.
- Итгэлцэл бий болгож, бүс нутгийн аюулгүй байдлын тогтвортой байдалд хувь нэмэр оруулна.

Сөрөг нөлөө

- Аль нэг талын цэргийн эвсэлд хэт ойртох нь геополитикийн өрсөлдөөнд татагдах эрсдэлтэй.
- Зэвсэглэлд хэт хамааралтай болох нь дотоод батлан хамгаалах бодлогын уян хатан байдлыг алдагдуулна.

Жишээ: Монгол Улсын АНУ-тай хамтарсан “Khaan Quest” энхийг сахиулах сургуулилт нь олон улсын цэргийн дипломат харилцааны жишээ боловч геополитикийн өрсөлдөгч улсуудын анхаарлыг ихээхэн татдаг.

Дипломат харилцаа ба улс төрийн аюулгүй байдал

Эерэг нөлөө

- Дипломат харилцаагаар дамжин маргаантай асуудлыг энхийн замаар шийдэх боломж бүрдэнэ.

- Олон улсын байгууллага, гэрээ хэлэлцээр нь аюулгүй байдлын баталгаанд шууд нөлөөлнө.
- Хөрш болон стратегийн түншүүдтэй тэнцвэртэй харилцаа тогтоож, гадаад бодлогын уян хатан байдлыг хадгална.

Сөрөг нөлөө

- Улс төрийн ашиг сонирхлын зөрчилдөөнд татагдах, олон улсын маргаанд оролцох эрсдэл.
- Гадаад бодлогын чиглэлд туйлшрах нь зарим улстай харилцаа муудах нөхцөл үүсгэнэ.

Жишээ: Монгол Улс НҮБ-ын “Өргөтгөсөн түншлэл”-ийн хүрээнд олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцдог нь улс төрийн нэр хүндийг өсгөсөн боловч зарим бүс нутгийн мөргөлдөөний талуудад мэдрэмжтэй хандах шаардлага үүсгэдэг.

Соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа ба нийгмийн аюулгүй байдал

Эерэг нөлөө

- Ард иргэдийн хоорондын ойлголцол, харилцан итгэлцэл нэмэгдэж, гадаад орчны талаарх эерэг төсөөлөл бий болно.
- Боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагаа нь хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ.
- Аялал жуулчлал, соёлын солилцоо нь эдийн засгийн салбаруудад шууд дэмжлэг үзүүлнэ.

Сөрөг нөлөө

- Соёлын глобалчлал нь үндэсний үнэт зүйл, хэл, уламжлалд сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Гадаадын суртал ухуулга, мэдээллийн нөлөөлөл нь нийгмийн сэтгэл зүйд сөрөг үр дагавар авчирна.

Жишээ: Монгол-Японы соёлын хамтын ажиллагаа нь иргэдийн харилцааг гүнзгийрүүлж, залуучуудын боловсролд эерэг нөлөө үзүүлж байгаа ч барууны масс соёлын нөлөө дотоодын соёлын хэв шинжид сорилт болж байна

Технологи, мэдээллийн аюулгүй байдал

Эерэг нөлөө

- Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа нь инновац, үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлнэ.
- Мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах нь төрийн үйлчилгээний үр ашгийг дээшлүүлнэ.

Сөрөг нөлөө

- Гадаад технологийн хэт хараат байдал нь мэдээллийн аюулгүй байдалд эрсдэл дагуулна.
- Кибер халдлага, мэдээллийн дайн зэрэг шинэ төрлийн аюул нэмэгдэнэ.

Жишээ: Монгол Улсын төрийн мэдээллийн системийн зарим хэсэг гадаад серверт байрлаж байгаа нь кибер аюулгүй байдлын хувьд сорилт болж байна.

Батлан хамгаалах гадаад харилцаа нь үндэсний аюулгүй байдлыг хангахад энх тайваныг хадгалах, итгэлцлийн бэхжүүлэх, чадавхыг нэмэгдүүлэх, гадаад бодлогыг дэмжих олон талын чиг үүрэг гүйцэтгэдэг. Үүнд:

Итгэлцэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх

- Батлан хамгаалах гадаад харилцаа нь улс орнуудын хооронд ил тод байдал, харилцан ойлголцол бий болгож, буруу ойлголт, үл итгэлцлээс үүдэлтэй зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй.
- Жишээ нь, хоёр талт болон олон талт батлан хамгаалах яриа хэлэлцээ, зөвлөлдөх уулзалт нь энх тайван, тогтвортой байдлыг хангах нэг хэрэгсэл болдог

Цэргийн итгэлцлийн арга хэмжээг хэрэгжүүлэх

- Хил орчмын харилцан мэдээлэл солилцох, цэргийн сургууль, сургалтад хамтран оролцох зэрэг нь бүс нутгийн аюулгүй байдлыг тогтвортой байлгах арга хэрэгсэл болдог.
- Энэ нь зэвсэглэл өрсөлдөөнийг бууруулах, үл ойлголцлыг багасгах ач холбогдолтой.

Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох

- Монгол зэрэг жижиг, дунд орнуудын хувьд энхийг сахиулах ажиллагаанд оролцох нь олон улсын тавцанд нэр хүндээ өсгөх, аюулгүй байдлаа гадаад хүрээнд баталгаажуулах чухал хэлбэр болдог.

Цэргийн чадавхыг нэмэгдүүлэх

- Батлан хамгаалах салбарын гадаад харилцаагаар дамжуулж сургалт, техник технологи, туршлага солилцох боломж бүрдэнэ.
- Энэ нь улс орны батлан хамгаалах бие даасан чадавхыг сайжруулж, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулдаг.

Гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын үялдаа

- Батлан хамгаалах гадаад харилцаа нь улс орны гадаад бодлогын хэрэгжилтийг дэмжих, бүс нутгийн болон дэлхийн түвшинд стратегийн тэнцвэрийг хангахад чухал үүрэгтэй.
- Жишээ нь, Монгол Улс “гуравдагч хөршийн бодлого”-оо батлан хамгаалах хамтын ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлж байна.

1.3. ГАДНЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ПРАКТИК, ТУРШЛАГА

Олон улсын болон бүс нутагт геополитик, цэрэг, эдийн засаг, техник, технологийн өрсөлдөөн идэвхжиж, улмаар, батлан хамгаалах зардлаа нэмэх, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх, цэрэг техникийн хувьд шинэ дэвшилтэт технологиудыг нэвтрүүлж, нутагшуулах чиглэлээр улс орнуудын батлан хамгаалах чиглэлийн гадаад хамтын ажиллагааны ач холбогдол өсөж байна. Үүний улмаас улс орнууд аюулгүй байдлаа баталгаажуулахад улс төр дипломатын болон цэргийн дипломат харилцаа, хамтын батлан хамгаалалтыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ач холбогдол өгөх болоо. Манай улсын хувьд бүс нутгийн эдийн засаг, цэрэг-стратегийн чадавхын өсөлт, хөрш орнуудын цэрэг техникийн чадвараас хамаарч, батлан хамгаалах хамтын ажиллагааг зөв зохицуулж, тэнцвэртэй, батлан хамгаалах өөрийгөө хамгаалах байгуулалтад ашигтай, олон талт цэргийн дипломатын идэвхтэй хамтын ажиллагааг хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Манай орны хувьд хүчний тэнцвэр (balance of power) барих бус, харин тэнцвэрийн хүчийг (power of balance) олж, ашиг сонирхлын тэнцвэрийг барих нь аюулгүй байдлын болон гадаад хамтын ажиллагаанд маш чухал болсоор байна.

Манай улс батлан хамгаалах чиглэлээр олон улсын хамтын ажиллагаанд оролцож байна. Энхийг сахиулах ажиллагаанд цэргүүдээ илгээж, хоёр талт гэрээ, сургалт зохион байгуулж байна. Гэвч санхүү, хүний нөөц, дэд бүтэц зэрэг нь зарим талаараа хязгаарлагдмал хэвээр байна.

Дэлхийн аюулгүй байдлын орчин сүүлийн жилүүдэд хурцадмал байна. Терроризм, кибер аюул, бүс нутгийн маргаан, улс төр, геополитикийн өрсөлдөөн нь жижиг болон дунд хэмжээний улсуудын батлан хамгаалах чадавхад нөлөөлж байна. Жижиг улс орнууд ч олон талт хамтын ажиллагаагаар өөрсдийн аюулгүй байдлыг баталгаажуулах боломжтой гэдгийг дараах улсуудын жишээн дээр авч үзье.

Гадаад хамтын ажиллагаа Финлянд Улс

Энэ улсын хамгийн том алхам нь НАТО-д элсэж, төлөвлөлтийн системд нь хамрагдсан явдал юм. Энэ нь тус улсын хил орчмын аюулгүй байдлыг бодитоор хамгаалж баталгаажуулсан байдаг. Төвийг сахисан бодлогоосоо татгалзаж, аюулгүй байдлын гадаад орчноо бодитоор үнэлж, хамтын батлан хамгаалалтын тогтолцоонд шилжиж, 2023 оны намраас НАТО-гийн хойд чиглэлд “Enhanced Vigilance Activities” (EVA) -д оролцож эхэлсэн. Мөн цэргийн хамтын ажиллагааны хүрээнд АНУ-ын цэргүүд Финляндын 15 цэргийн бааз, дэд бүтцийг ашиглах эрхтэй болсон. 2024 оноос Америкийн нисэх онгоцнууд тус улсын нисэх буудлуудыг ашиглах болсон. NORDEFCO-д Nordic Defence Cooperation (Скандинавын орнуудын батлан хамгаалах хамтын ажиллагаа Дани, Финлянд, Исланд, Норвеги, Швед багтдаг) суурилсан хамтарсан зэвсгийн худалдан авалт, стандарчлалыг нэгтгэж, 2021 оноос Финлянд, Швед хамтдаа хуягт машины үйлдвэрлэлийг хувааж хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү батлан хамгаалах хамтын ажиллагааны байгууллага нь батлан хамгаалах чиглэлийн судалгаа, худалдан авалт, сургалт, логистикийн хамтын ажиллагааг уялдуулах, батлан хамгаалах нөөцийг хэмнэх, зардлыг

буруулах, техник хэрэгсэл сургалтын тал дээр хамтран ажиллах, цэргийн чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцох, аюулгүй байдлын орчны тогтвортой байдлыг хангах зэрэгт үйл ажиллагаагаа чиглүүлдэг.²⁶

Гадаад хамтын ажиллагаа Швед Улс

НАТО-гийн бүрэн эрхт гишүүн болсноор Балтын тэнгисийн бүсэд өөрийн хүчний байршуулалтын уялдаагаа бүрэн хангасан. Батлан хамгаалах хамтын ажиллагааны хүрээнд Шведийн агаарын хүчин НАТО-гийн “Air Policing” ажиллагаанд анх удаа оролцож эхэлсэн байдаг. АНУ-ын DCA (Defence Cooperation Agreement) “Батлан хамгаалах хамтын ажиллагааны гэрээ”- нд 2024 оны 12 сарын 18 орсноор АНУ-ын цэргийн 17 байгууламжийг ашиглах эрх авсан. Их Британы тэргүүлдэг хурдан хариу үйлдлийн хүчний хүрээнд Балтын тэнгисийн хамтарсан сургалт, дасгалд байнга оролцдог болсон. Энэ улс нь төвийг сахисан бодлогоосоо татгалзаж, хурдан хугацаанд цэргийн хүч чадлаа босгож бэхжүүлж чадсан. “JEF Exercise Aurora” Сургуулилтад 26000 цэрэг оролцсон нь Шведийн хамгийн том хамтарсан сургалт болсон. Швед улс нь (SAAB - тус улсын батлан хамгаалах, агаарын болон зэвсгийн системийн компани) бүс нутгийн хэрэгцээтэй уялдуулж, аж үйлдвэр судалгаа, хамтарсан Research and Development (R&D) судалгаа, хөгжүүлэлт болон шинэ зэвсэг, технологи, кибер, хиймэл оюун ухаанд суурилсан систем хөгжүүлэлт, экспорт-нэгдсэн цэргийн сургалтуудад түлхүү анхаарч байна. НАТО-той нэгдсэнээр нэгдсэн төлөвлөлт, тагнуул-мэдээллийн сүлжээнд хурдан интеграцлагдаж байна.²⁷

Сингапур Улс

Сингапур нь (FPDA) Малайз, Их Британи, Авсрали, Шинэ Зеланд улстай хамтран олон талт батлан хамгаалах хамтын ажиллагаа явуулж Five Defence Arrangement-ийг байгуулж, 2025 онд (Exercise Concept Directive) 5 жилийн хамтын ажиллагааны зураглал баталж, уламжлалт болон шинэ аюулд кибер дайн, далайн аюулгүй байдлыг хангахад илүүтэй анхаарч ажиллаж байна. АНУ-тай 1990 онд MOU (Facilities), 2005 онд (Strategic Framework Agreement), 2015 онд (Enhanced DCA), 2019 онд цэрэг-стратегийн байгууламж ашиглах протоколыг 15 жилээр сунган хамтарсан сургалт, нисэх эрх зэргийг авч хамтран ажиллаж байна. Тус улсын онцлог хандлага нь (Total Defence) цэргийн, иргэн, эдийн засаг, нийгэм-сэтгэл зүй, дижитал үзэл баримтлал дээр тулгуурласан, чадвар- төвтэй (capability-centric) хамтын ажиллагааг бүх нийтийн батлан хамгаалалт үзэл баримтлалыг хэрэгжүүлдэг. Жижиг нутаг дэвсгэртэй тул гадаад сургалтын талбайнуудыг оновчтой ашиглах гадаад хамтын ажиллагааг хэрэгжүүлдэг.²⁸

²⁶ https://defmin.fi/documents/236553176/238659714/Finland_US_DCA_-_Finland_Prime_-_English.pdf/d4e48fb3-2807-1891-d805-08cdf11cec6/Finland_US_DCA_-_Finland_Prime_-_English.pdf?t=1745495798423

²⁷ <https://www.government.se/contentassets/fa069c4f33504103ab4b5e635f947a34/agreement-on-defense-cooperation-between-sweden-and-the-united-states-of-america.pdf>

²⁸ https://www.mindef.gov.sg/news-and-events/latest-releases/24sep19_fs/

Дээрх орнуудын батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаанаас манай улсын батлан хамгаалалтад хэрэгжүүлж болох дараах туршлагууд байна. Үүнд:

- Олон талт хамтын ажиллагаанд тогтмол оролцох

Жишээ: Сингапур - FPDA (5 улсын тогтолцоо).

Монголд: Зүүн Хойд Азид одоо байгаа CICA, ARF, ADMM-Plus зэрэг механизмд идэвхтэй оролцож, байнгын сургалт, дасгал зохион байгуулах туршлагыг нэмэгдүүлэх.

- Хоёр талт гүн түншлэлийн эрх зүйн суурь байгуулах

Жишээ: Финлянд/Швед - АНУ-тай байгуулсан DCA.

Монголд: Хамтын ажиллагааны чухал түншүүдтэй (жишээ нь Япон, Өмнөд Солонгос, Герман, Энэтхэг) логистик, сургалт, цэргийн сургалтын талбай ашиглах эрхтэй эрх зүйн суурь хэлэлцээр байгуулах.

- Бүс нутгийн хурдан хариу үйлдлийн чадавхыг дэмжих

Жишээ: Швед - JEF (Joint Expeditionary Force).

Монголд: Бүс нутгийн энхийг сахиулах болон гамшгийн тусламжийн хурдан хариулах баг-т ажиглагч эсвэл түншийн хувиар нэгдэх, улмаар сургалт, логикийн интеграцид суралцах.

- Гадаад сургалтын талбайн стратегийг ашиглах

Жишээ: Сингапур - гадаадад (AU, US, IN, FR) байнгын сургалт хийдэг.

Монголд: Том гүрнүүдтэй (ОХУ, Хятад, АНУ, Энэтхэг) харилцан ашигтай сургалтын талбайн хамтын ажиллагаа хөгжүүлэх. Монголын газар нутаг ч өөрөө бусдад сургалтын боломж олгож, харин Монголын цэргүүд гадаад сургалт авч болно.

- Аж үйлдвэр-академи-судалгааны уялдаа

Жишээ: Швед - SAAB зэрэг компани бүс нутгийн зэвсэглэл /системийг хөгжүүлдэг.

Монголд: Батлан хамгаалах салбарын сургалт, судалгаа, технологийн төвүүдийг олон улсын төсөлтэй холбож, кибер, дижитал хамгааллын чиглэлээр жижиг боловч чухал төслүүд хэрэгжүүлэх.

- “Total Defence” буюу бүх нийтийн хамгааллын үзэл баримтлал

Жишээ: Финлянд, Сингапур - цэргийн + иргэн, эдийн засаг, кибер, сэтгэл зүйн хамгаалалтыг нэгтгэдэг.

Монголд: Иргэдийн оролцоотой нийгмийн дархлаа, мэдээллийн орчны хамгаалал, кибер тэсвэрийг үндэсний батлан хамгаалах бодлогын бүрэлдэхүүн хэсэг болгох Финлянд, Швед, Сингапурын туршлагаас харахад жижиг, дунд хэмжээтэй улс орнууд ч гадаад хамтын ажиллагаагаа зөв чиглүүлснээр батлан хамгаалалтын хүчин чадлаа эрс өсгөж чаддаг. Монгол Улс ч энэ туршлагыг нутагшуулбал бүс нутгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх бодит хувь нэмэр оруулж чадна.²⁹

- Олон талт хамтын ажиллагаанд тогтмол оролцох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: CICA, ARF, ADMM-Plus зэрэг механизмын хүрээнд хамтарсан сургалт, сургуулилтад тогтмол оролцох.

Энхийг сахиулах хамтарсан сургуулилтыг Монголд тогтмол зохион байгуулах.

Хүлээгдэж буй үр дүн: Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлын “тогтмол тоглогч” болж, нэр хүнд өснө.

Эрсдэл: Санхүүгийн болон хүний нөөцийн хязгаарлагдмал байдал.

²⁹ <https://www.mindef.gov.sg/defence-matters/defence-topics/total-defence/>

- Хоёр талт гүн түншлэлийн эрх зүйн суурь байгуулах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Стратегийн түнш орнуудтай (Япон, БНСУ, Энэтхэг, Герман гэх мэт) батлан хамгаалах хамтын ажиллагааны тухай “суурь хэлэлцээр” байгуулах.

Сургалт, логистик, цэргийн техник хэрэгсэл ашиглах эрхийн зохицуулалтыг тусгах. Хүлээгдэж буй үр дүн: Хамтын сургалт, технологи, логистикийн чадамж өргөжнө. Эрсдэл: Хөрш орнуудын үл итгэх хандлага, геополитикийн дарамт.³⁰

- Бүс нутгийн хурдан хариу үйлдлийн хүчний чадавхыг дэмжих

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Бүс нутгийн энхийг сахиулах болон гамшгийн тусламжийн хүчний сургуульд ажиглагч/түншийн статусаар оролцох.

Монголын Зэвсэгт хүчний “хурдан хариу үйлдэл үзүүлэх баг”-ийг байгуулах.

Хүлээгдэж буй үр дүн: Гамшиг, аюул заналд түргэн хариулах чадвар нэмэгдэнэ.

Эрсдэл: Санхүү, техник, сургалтын өндөр шаардлага.

- Гадаад сургалтын талбайн стратегийг ашиглах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Том гүрнүүдтэй сургалтын талбай харилцан ашиглах хэлэлцээр байгуулах.

Монголын газар нутгийг олон улсын сургалт, дасгалд санал болгох.

Хүлээгдэж буй үр дүн: Цэргүүдийн мэргэжлийн ур чадвар сайжирч, олон улсын интеграци нэмэгдэнэ.

Эрсдэл: Байгаль орчны нөлөөлөл, дотоодын эсэргүүцэл.

- Аж үйлдвэр-академи-судалгааны уялдаа

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Батлан хамгаалах их сургуулиудыг олон улсын судалгааны төслүүдтэй холбох.

Кибер аюулгүй байдал, дижитал хамгааллын жижиг төсөл хэрэгжүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн: Шинэ технологи нэвтэрч, дотоодын судалгааны чадавх сайжирна.

Эрсдэл: Санхүүжилтийн тогтворгүй байдал, хүний нөөцийн дутагдал.

- “Total Defence” буюу бүх нийтийн хамгааллын үзэл баримтлал

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Цэргийн хамгаалалтыг нийгмийн, эдийн засгийн, мэдээллийн дархлаатай уялдуулах.

Иргэдийн мэдээлэл, кибер орчны дархлааг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэх.

Хүлээгдэж буй үр дүн: Улс орон бүхэлдээ тэсвэртэй, эрсдэлийг даван туулах чадвартай болно.

Эрсдэл: Нийгмийн соёлын түвшин, иргэдийн идэвх сул байж болзошгүй.

Монгол Улс Финлянд, Швед, Сингапурын туршлагад тулгуурлан олон талт ба хоёр талт тэнцвэртэй хамтын ажиллагаа, эрх зүйн баталгаатай түншлэл, нийгмийн бүх нийтийн хамгаалал гэсэн гурван үндсэн чиглэлээр батлан хамгаалах гадаад бодлогоо гүнзгийрүүлэх боломжтой.

Казахстан Улс

Төв Азийн орнууд дундаас Монгол-Казахстан улсын харилцаа, хамтын ажиллагаа хоёр улсын гадаад, дотоод бодлого, түүхэн уламжлал, сүүлийн жилүүдэд тохиосон өндөр түвшний айлчлалын үр дүнд түлхүү хөгжих хандлагатай байна.

³⁰ <https://www.mofa.go.jp/files/000241983.pdf>

Учир нь, 2024 оны 10 дугаар сард Бүгд Найрамдах Казахстан Улс /БНКаЗУ/-ын Ерөнхийлөгч К.Токаевын айлчлалаар "Монгол Улс, БНКаЗУ стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал" гаргасан нь хоёр орны харилцаа, түүний дотор аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах боломжийг нээсэн. Тухайлбал: Монгол- Казахстаны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд БНКаЗУ- ын энгийн болон цэргийн сургуулиудад цэргийн боловсон хүчнээ бэлтгэх, цэрэг- техникийн хамтын ажиллагааны гэрээ байгуулж, зэвсэглэл техникээ шинэчлэх, засварлах, хээрийн сургуулилт хийх, хэлний сургалт явуулах боломж нээгдсэн.

Хамтарсан тунхаглалд Монгол-Казахстан улсын харилцаа, хамтын ажиллагааны таван тулгуур чиглэлийг тодорхойлсны дотор улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь тунхаглалын хамгийн нэгдүгээрт эрэмбэлэгдэж, түүнд тэргүүлэх зэргийн ач холбогдол өгөгдсөн. Тухайлбал: хоёр улсын аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, Батлан хамгаалах яам хоорондын зөвлөлдөх уулзалтын механизм бий болгох, цэргийн атташег харилцан томилох, цэргийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийн зэрэгцээ цэргийн хамтарсан хээрийн сургуулилт зохион байгуулах чиглэлийг тодорхойлсон.

Хоёр орны улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах хамтын ажиллагааны үндсэн зорилго нь төрийн өндөр түвшний айлчлал, яриа хэлэлцээний механизмыг тогтмолжуулж, улс төрийн итгэмжилсэн харилцааг бэхжүүлэх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, хүчний болон хууль сахиулах байгууллага хоорондын харилцааг өргөжүүлж, бүс нутгийн хэмжээнд итгэлцэл, харилцан ойлголцол, тогтвортой байдлыг хангахад чиглэж байна.

Хамтарсан тунхаглалд, хоёр улсын аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, Батлан хамгаалах яам хоорондын зөвлөлдөх уулзалтын механизм бий болгох, цэргийн атташег харилцан томилох, цэргийн хамтын ажиллагааг өргөжүүлэхийн зэрэгцээ хамтарсан хээрийн сургуулилт зохион байгуулах чиглэлийг тодорхойлсон.

Мөн олон улсын терроризм, шашны хэт даврах үзэл, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт болон түүнтэй адил бодис, зэвсгийн хууль бус наймаа, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, цөмийн материалын хууль бус наймаа, хууль бус шилжилт хөдөлгөөний эсрэг хоёр улсын прокурор, шүүх, хууль сахиулах, хил хамгаалах байгууллагууд болон тусгай албадын харилцааг бэхжүүлэхийг онцолсон.

Мөн БНКаЗУ 2025 оноос Монгол Улсад суух цэргийн атташегаа томилсон бөгөөд шинээр томилогдсон цэргийн атташе хурандаа А.Жантаевыг Батлан хамгаалахын сайд Д.Батлут 2025 оны наймдугаар сарын 13-нд хүлээн авч уулзан цэргийн хамтын ажиллагаа, түүний дотор хамтарсан хээрийн сургуулилт хийх боломжийн талаар санал солилцсон. Мөн Монгол Улсаас БНКаЗУ-д суух цэргийн атташегийн асуудал үндсэндээ шийдэгдээд байна.

БНКаЗУ нь үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг батлан хамгаалах аж үйлдвэрийн цогцолбороо цогцоор нь бэхжүүлэх бодлого баримталж, өндөр түвшний үйлдвэрлэлийн технологийг нутагшуулах, цэрэг армия хуягт машин, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, өндөр технологийн орчин үеийн бага оврын цэргийн

зэвсэглэл, техник хэрэгслээр хангах, улмаар экспортод гаргах зорилт тавин ажиллаж байна.

2025 оны дөрөвдүгээр сарын 16-нд БНКазУ-ын парламент "Орон нутгийн хамгаалалтын тухай" хууль баталж, хилийн дагуу 20 бригад, түүний дотор ОХУ-тай хиллэдэг бүс нутагт орон нутгийн хамгаалалтын 8 бригад, БНХАУ-тай хиллэдэг бүс нутагт 4 бригад байрлуулахаар төлөвлөсөн. Тус хуулийн төслийг боловсруулагчид "Украин дахь цэргийн мөргөлдөөнийг харгалзан үзэж, төрөөс цэргийн ажиллагаа явуулах бэлтгэлийг хангах зорилготой хэмээн хөрш орнуудаасаа айж эмээлгүй мэдэгдэж байгаа нь аюулгүй байдлын бодлогоо ОХУ, БНХАУ-тай эн зэрэгцэн, эрх тэгш хэрэгжүүлж буйг харуулж байна.

БНКазУ-ын их дээд сургуулиуд кибер аюулгүй байдал, хиймэл оюун ухаан, цэргийн боловсролд тэргүүлэх ач холбогдол өгч байгаа нь хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улс тэдгээр мэргэжлээр бакалавр, магистр, докторын түвшинд цэргийн боловсон хүчнээ бэлтгэх боломжийг олгож байна.

Мөн Зэвсэгт хүчний албан хаагчдыг цэргийн нисгэгч, холбооны инженер, радио-электроник, нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн мэргэжилтэн зэрэг төрөл мэргэжлийн цэргийн бүх чиглэлээр БНКазУ-ын цэргийн сургуулиудад сургах, үүндээ БНКазУ-ын Засгийн газрын тэтгэлгээр суралцах оюутны квотыг ашиглах нь зүйтэй. Одоогоор энэхүү тэтгэлэгт хамрагдах монгол оюутны тоо гүйцэхгүй байгаа нь казах хэлний хүндрэл бэрхшээлтэй холбоотой.

Монгол Улс Төв Ази, БНКазУ-тай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд казах хэлтэй үндэсний боловсон хүчин дутагдалтай байгаа нь ажиглагдаж байна. БНКазУ мөн адил монгол хэлтэй төрийн албан хаагч байхгүй байгааг хүлээн зөвшөөрдөг бөгөөд хоёр улсын харилцаанд монголын казах иргэдийг ашиглаж байгаа нь давуу гэхээсээ илүүтэй сул талыг бий болгож байна.

Монгол Улс ирээдүйд Төв Ази, ОХУ, БНХАУ гэсэн гурван талын харилцааг уялдуулахад БНКазУ-тай итгэлцсэн, гүнзгий харилцаа хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнд хэл, соёлын бэлтгэлтэй үндэсний боловсон хүчин чухал үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна.

Тиймээс ҮБХИС-ийг түшиглэн дараах зорилгоор казах хэлний сургалтын төвийг байгуулах санаачилга гаргаж, хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

1. БНКазУ-ын цэргийн болон иргэний их, дээд сургуульд кибер, хиймэл оюун, батлан хамгаалах зэрэг чиглэлээр боловсон хүчин бэлтгэх;
2. Ховд, Баян-Өлгий аймагт ажиллаж буй цэргийн анги, нэгтгэлийн албан хаагчдад анхан болон дунд шатны казах хэлний мэдлэг олгох;
3. Төрийн "босоо" удирдлагатай байгууллагын албан хаагчдыг казах хэлний сургалтад хамруулах.

Энэхүү бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Монгол Улсад суугаа БНКазУ-ын ЭСЯ болон цэргийн атташегийн дэмжлэгийг авах, ҮБХИС-ийн дэргэд 1-2 казах хэлний багшийг казахстаны талаас урьж ажиллуулах, монголын талын 4-5 багшийг БНКазУ-д сургах, сургалтын материаллаг баазыг хамтран бүрдүүлэх нь зүйтэй.

Эртний түүхтэй хоёр улс орос хэлээр харилцаж ирсэн уламжлалаа шинэ шатанд гаргаж, казах болон монгол хэл дээр шууд харилцах орчин бүрдүүлэх нь хоёр улсын Ерөнхийлөгчийн түвшинд тохиролцсон "стратегийн түншлэл"-ийг бодит ажил болгон хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

ОХУ Өрнөдийн хоригт орсонтой холбогдуулан монголын зэвсэглэл техникийн шинэчлэл, засвар үйлчилгээг БНКаЗУ-д хийх, худалдан авалт хийх боломжтой бөгөөд үүний тулд тус улстай цэрэг-техникийн хамтын ажиллагааны гэрээг БНКаЗУ байгуулах нь зүйтэй.

Хоёр талын зохион байгуулдаг олон улсын цэргийн хээрийн сургуулилт, цэрэг армийн спортын уралдаан тэмцээн, наадамд харилцан төлөөллөө оролцуулж, гамшиг, үйлдвэрийн осол, терроризмтой тэмцэх хамтарсан сургуулилтыг тогтмол зохион байгуулах нь Монгол-Казахстаны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх нэг чухал арга нь мэргэжлийн боловсон хүчнийг гадаад улсад сургах явдал юм. Тус улсын цэргийн сургуулиудад Монголын цэргийн албан хаагчдыг сургаснаар хоёр тал харилцан бие биеэ ойлгох, мэдлэг, чадвараа дээшлүүлэх боломж бүрдэж байна. Энэ нь Орос, Төв Ази, Казахстаныг ойлгодог залуу офицеруудын халааг бэлтгэхэд тустай. Мөн Ховд, Баян-Өлгий аймагт өссөн, казах хэлний мэдлэгтэй залуучуудыг сонгон шалгаруулж сургах нь бодлогын чанартай алхам юм.

Хамтарсан сургуулилтүүд зохион байгуулах

Хамтарсан сургуулилт нь цэрэг армийн хамтын ажиллагааг сайжруулахад маш үр дүнтэй арга юм. Казахстаны “Хааны эрэлд” сургуульд оролцох болон Ховд, Баян-Өлгий аймагт уулын бүсийн дадлага сургуулийг жил бүр хамтран зохион байгуулах нь хоёр улсын цэргийн ангиудад харилцан суралцах боломжийг олгож байна. Иймэрхүү үйл ажиллагаа нь хоёр талын харилцан ойлголцлыг нэмэгдүүлж, гуравдагч хөршүүдийн “сэрдлэг”-ийг бууруулах ач холбогдолтой юм.

Цэрэг-техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэх

Батлан хамгаалах салбарын техник хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд цэрэг-техникийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг. Казахстантай яаралтай цэрэг-техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах нь Монгол Улсад байгаа хуучирсан ЗХУ-ын үйлдвэрлэлийн зэвсэг, техникийг засварлах, мөн шинээр техник хэрэгсэл худалдан авах боломжийг бүрдүүлнэ. Энэ нь зөвхөн техник хангамжийн асуудлыг шийдээд зогсохгүй, тус улстай стратегийн түншлэлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.³¹

Дипломат төлөөлөгчдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх

Батлан хамгаалахын атташег Элчин сайдын яаманд албан ёсоор томилох нь тухайн улсыг түншийн зэрэгт авч үзэж байгааг илтгэдэг. 2025 онд Батлан хамгаалахын сайдын айлчлалаар атташег албан ёсоор томилсноор хоёр орны харилцан итгэлцэл бэхжих болно. Энэ нь хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд чухал үүрэгтэй.

³¹ <https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/18109.pdf>

Гадаад бодлогын түншлэлийг бэхжүүлэх

Олон улсын харилцаанд хүлээн зөвшөөрөгдсөн, нөлөө бүхий “дунд гүрэн” болохыг эрмэлзэж буй энэ улстай стратегийн түншлэл хөгжүүлэх нь Монгол Улсад тохиолдож болзошгүй хүндрэлтэй нөхцөл байдалд чухал ач холбогдолтой. Тухайлбал, 1990-ээд онд Оросын тал уул уурхайн тэсрэх бодис болон шатахуун нийлүүлэхээс татгалзах үед Монгол Улс АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргаар дамжуулан дэмжлэг хүсэж байв. Мөн Далай ламын айлчлалтай холбоотойгоор Хятадын хил хаагдсан тохиолдолд гаднын дарамт шахалт үүсч байсан. Ийм үед бүс нутгийн нэр хүндтэй түнш орон Монголын төлөө дуугарч, дэмжлэг үзүүлэх нь бодитой бөгөөд хүчтэй нөлөөтэй.

Иймээс тус улстай харилцаагаа бэхжүүлэх нь зөвхөн хоёр талын хамтын ажиллагаанд төдийгүй Орос, Хятад хоёр хөрштэй харилцах орчинд ч эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Дипломат болон улс төрийн хамтын ажиллагаа

Монгол Улс Казахстаныг "гуравдагч хөрш" хэмээн албан ёсоор зарлах нь хоёр хөршийн "зөвхөн АНУ тэргүүтэй барууны орнууд гуравдагч хөрш мөн" гэсэн шүүмжлэлийг үндэслэлгүй болгох ач холбогдолтой бөгөөд тэдний талаас Монгол Улсад хандах хандлагыг сайжруулна.

Казахстан улстай "стратегийн түнш"-ийн харилцаа тогтоож, хамтын ажиллагааны байнгын механизмыг бий болгох нь хүнд хэцүү цагт чухал ач холбогдолтой. Тухайлбал, 1990-ээд онд Оросоос шатахуун, тэсрэх бодис тасалдсан үед болон Далай ламтай холбоотойгоор Хятадын хил хаагдсан үед АНУ зэрэг гуравдагч орнуудаар дамжуулан дарамтыг бууруулж байсантай адил, ирээдүйд олон улсын тавцанд Монголын талд нөлөөлөхүйц байр суурь илэрхийлэх хүчтэй нөлөө үзүүлнэ.

Мөн Монгол Улс уг улсын гадаад бодлогын гол санаачилгуудыг дэмжих нь зүйтэй. Тухайлбал, “дунд гүрэн” статусыг нь хүлээн зөвшөөрсөн байр суурь илэрхийлэх, шашин хоорондын яриа хэлэлцээг хөгжүүлэхэд хамтран ажиллах, мөн Азид харилцан үйлчлэлцэх ба итгэлцлийг бэхжүүлэх бага хурал (CICA)-ын хүрээнд идэвхтэй оролцохоо нотлох нь бодит ач холбогдолтой.

Аюулгүй байдлын болон батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа

Аюулгүй байдлын чиг үүрэг бүхий байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай. Үүнд:

- Казах болон орос хэлтэй залуучуудаас сонгон шалгаруулж, жил бүр 10 хүртэлх цэргийн албан хаагчийг тус улсын цэргийн сургуулиудад сургах. Энэ нь ОХУ-д суралцаж цаг алдахгүйгээр илүү үр дүнтэй мэдлэг эзэмшиж, Орос, Төв Ази, ерөнхийдөө бүс нутгийн орнуудыг гүнзгий ойлгодог залуу офицеруудыг бэлтгэхэд тустай.

- Хилийн цэрэг, гааль, цагдаагийн сургуулиудад жил бүр 5-10 хүн бодлогоор бэлтгэх. Ингэснээр цаашид тус улсын хүчний байгууллагын удирдлагад ажиллах

мэргэжилтнүүдтэй хамт суралцсан харилцааны сүлжээтэй боловсон хүчин бий болно.

- “Хааны эрэлд” зэрэг цэргийн сургуулилтад идэвхтэй оролцож, Ховд, Баян-Өлгий дэх хэсгүүдтэй хамтарсан уулын бүсийн дадлага сургалтыг жил бүр зохион байгуулах. Энэ нь хоёр талын цэргийн ангиуд харилцан суралцах боломжийг нэмэгдүүлж, хоёр хөршөөс үүсэх болгоомжлолыг бууруулах ач холбогдолтой.

- Цэрэг-техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулснаар хуучин ЗХУ-ын үйлдвэрлэлийн зэвсэг, техникийг засварлах болон шинэ тоног төхөөрөмж авах боломж өргөжнө.

- 2025 онд тухайн улсад суугаа Элчин сайдын яаманд Батлан хамгаалахын атташег албан ёсоор томилон ажиллуулах нь Монгол Улс уг улсыг бодит түнш гэж үзэж буйгаа харуулж, харилцан итгэлцлийг нэг шат ахиулна.

Эдийн засаг болон боловсролын хамтын ажиллагаа

БНКаЗУ-ны боловсролын квотыг зохистой ашиглах нь чухал. Одоогоор 25 квот (15 бакалавр, 5 магистр, 5 доктор)-ыг олгож байгаа бөгөөд үүнд казах хэлтэй хүн оролцдог. Эдгээр квотыг хувийн ашиг сонирхлоор ашиглах явдлыг зогсоож, казах хэлтэй, Казахстаны нөхцөл байдлыг ойлгодог боловсон хүчний нөөц бүрдүүлэх зорилгоор бодлогоор залуучуудыг сургах хэрэгтэй.

Мөн Хятадын баруун бүсийн дэд бүтэц (төмөр зам, хил, гаалийн боомтууд)-ыг ашиглах талаар хамтран судалгааг эхлүүлж хэрэгжүүлэх шаардлагатай байгааг одоогийн нөхцөл байдал харуулж байна. Цагааннуур, Улаанбайшинаар дамжин Казахстанд хүрдэг дэд бүтцийг сайжруулж, ОХУ-ын хил, гаалийн хүнд суртлыг арилгах талаар хамтран ажиллах боломжтой.

БНКаЗУ нь Оросын бодлогын dynamics болон Хятадын баруун бүсийн нөхцөл байдлыг ойлгоход стратегийн ач холбогдолтой төдийгүй эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Иймд уг улс нь Төв Азид чиглэсэн Монголын гадаад бодлогын хамгийн ойролцоо байрлах, голлох тулгуур түншийн нэг хэвээр байна. Батлан хамгаалах хамтын ажиллагааны асуудал: Монгол Улс бүс нутгийн улс орнуудтай батлан хамгаалахын хүрээнд тогтвортой, олон давхаргат хамтын ажиллагаа хөгжүүлэх боломжтойг Кыргызстаны туршлага тод томруун харуулдаг. Тус улс бүсийн хэмжээнд цэргийн сургалт, хамтарсан дасгал, хил хамгаалалтын чадавх бэхжүүлэх хөтөлбөрт идэвхтэй оролцсоноор аюулгүй байдлын хамтын ажиллагаагаа шат дараатай өргөжүүлж, үндэсний хамгаалалтын институтын чадавхыг мэдэгдэхүйц сайжруулсан. Энэ нь Монгол Улс Казахстантай төдийгүй Төв Азийн бусад улстай батлан хамгаалахын түншлэлийг гүнзгийрүүлэхдээ авч болзошгүй сургамж, загвар болох боломжтой.

XXI зуунд дэлхий дахины болон бүс нутгийн аюулгүй байдлын орчин эрчимтэй өөрчлөгдөж, олон улсын харилцаанд шинэ сорилтууд бий болж байна. Глобалчлалын үйл явц, бүс нутгийн геополитикийн өрсөлдөөн, терроризм, хил дамнасан гэмт хэрэг, кибер аюул зэрэг хүчин зүйлс нь улс орнуудын батлан хамгаалах бодлого, гадаад харилцаанд шинэ шаардлага тавьж байгаа билээ.

Энэ нөхцөлд Төв Азийн улс орнуудын хувьд батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах, бүс нутгийн

тогтвортой байдлыг бэхжүүлэх стратегийн чухал хүчин зүйл болж байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Кыргызстан Улсын батлан хамгаалах хамтын ажиллагаа нь түүний үндэсний аюулгүй байдлын бодлогын салшгүй хэсэг бөгөөд Оросын Холбооны Улс, Хятад, Казахстан зэрэг хөрш орнуудтай стратегийн түншлэл, мөн олон улсын болон бүс нутгийн байгууллагууд дахь идэвхтэй оролцоотой нягт уялдаатай хөгжиж иржээ.

Кыргызстан Улс

Кыргызстан нь газарзүйн байрлалын хувьд Төв Азийн гол зангилаанд оршдог тул түүний батлан хамгаалах бодлого бүс нутгийн болон олон улсын хүчин зүйлтэй салшгүй холбоотой. Батлан хамгаалах бодлогын онолын үндсийг дараах байдлаар тодорхойлж болно:

Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах зарчим - Гадаадын аливаа цэргийн нөлөөлөл, аюул заналд өртөхөөс сэргийлэх.

Бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зарчим - Төв Азийн улс орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх.

Хамтын аюулгүй байдлын зарчим - Олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын хүрээнд (ОДКБ, ШХАБ гэх мэт) аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Нийтийн аюулгүй байдлыг баталгаажуулах зарчим - Терроризм, хил дамнасан гэмт хэрэг, мансууруулах бодисын наймаа зэрэг уламжлалт бус аюул заналд хамтын хүчээр хариу арга хэмжээ авах.³²

Бүс нутгийн хүрээнд батлан хамгаалах хамтын ажиллагаа

Кыргызстан Улс бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд дараах чиглэлээр онцгой идэвхтэй оролцож байна:

ОДКБ (Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага)

- Кыргызстан нь ОДКБ-ын идэвхтэй гишүүн бөгөөд хамтарсан сургуулилт, энхийг сахиулах ажиллагаа, цэрэг-техникийн тусламжийн хүрээнд чухал байр суурь эзэлдэг. Оросын цэргийн 201-р бааз болон Кантийн агаарын бааз нь бүс нутгийн аюулгүй байдлын тогтвортой байдалд хувь нэмэр оруулдаг.

ШХАБ (Шанхайн хамтын ажиллагааны байгууллага)

- ШХАБ-ын хүрээнд Кыргызстан нь терроризмын эсрэг хамтарсан сургуулилт (“Энхийн эрхэм зорилго”), мөн хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх салбарт хамтран ажиллаж байна.³³

Хоёр талын батлан хамгаалах хамтын ажиллагаа

Казахстан, Хятад, Орос зэрэг хөрш орнуудтай батлан хамгаалах салбарт гэрээ хэлэлцээр байгуулан, хамтарсан сургалт, боловсон хүчин солилцоо явуулдаг.

Бүгд Найрамдах Кыргызстан Улсын батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаа нь Төв Азийн улс орнуудын хамтын ажиллагааны хөгжлийн чиг хандлага, мөн бүс нутгийн аюулгүй байдлын нөхцөл байдалтай салшгүй холбоотой. Төв Азийн

³² <https://jamestown.org/kyrgyzstans-national-security-concept-legally-enshrines-strategic-balance/>

³³ <https://eng.sectesco.org/20230922/-Joint-anti-terrorism-drill-of-the-SCO-and-CIS-Eurasia-Antiterror---2023-959008.html>

геополитикийн онцлог нь том гүрнүүдийн ашиг сонирхол огтлолцож, терроризм, хил дамнасан гэмт хэрэг, хэт даврагч үзэл, эдийн засгийн эмзэг байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаарч байгаа тул бүс нутгийн хамтын ажиллагааны ач холбогдол улам нэмэгдэж байна.

Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага (ОДКБ)

Кыргызстан нь ОДКБ-ын бүрэн эрхт гишүүн бөгөөд тус байгууллагын аюулгүй байдлын тогтолцоонд идэвхтэй оролцдог. ОДКБ-ын хүрээнд:

Хамтарсан сургуулилт, цэргийн сургалтууд - Жил бүр зохион байгуулагддаг “Нэгдсэн хүч”, “Энхийн эрхэм зорилго” зэрэг хамтарсан сургуулилтад Кыргызстан цэргийн хүчин оролцож, терроризм, экстремизмийн эсрэг ажиллагаанд бэлтгэгддэг.

Цэрэг-техникийн тусламж - Оросын Холбооны Улс болон ОДКБ-ын бусад гишүүдээс батлан хамгаалах техник, зэвсэглэл, сургалтын дэмжлэг тогтмол авдаг.

Стратегийн байр суурь - Кыргызстаны Кантийн агаарын бааз нь ОДКБ-ын хүрээнд бүс нутгийн агаарын аюулгүй байдлыг хамгаалах стратегийн чухал цэг болж байна.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)

Кыргызстан ШХАБ-ын гишүүн орны хувьд бүс нутгийн терроризмын эсрэг болон цэргийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцдог.

Терроризмын эсрэг сургуулилт - ШХАБ-ын хүрээнд зохион байгуулагддаг “Энхийн эрхэм зорилго” зэрэг сургуулилтад тогтмол оролцож, цэргийн хүчин чадал, хамтын ажиллагааны уялдаа холбоогоо нэмэгдүүлдэг.

Бүс нутгийн аюулгүй байдлын механизмууд - Терроризмын эсрэг бүс нутгийн байгууллага (RATS)-д идэвхтэй оролцож, мэдээлэл солилцоо, хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлдэг.

Хятад-Кыргызстан улсын хамтын ажиллагаа - Хятадтай хийсэн батлан хамгаалах хамтын ажиллагаа нь техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, мөн алан хядах ажиллагааны эсрэг бодлогод чиглэж байна.

Хөрш орнуудтай хоёр талын хамтын ажиллагаа

Оросын Холбооны Улс -Кыргызстаны хамгийн том батлан хамгаалахын түнш бөгөөд цэргийн бэлтгэл сургалт, техник хэрэгсэл нийлүүлэлт, хамтарсан баазын ажиллагаанд гол байр суурь эзэлдэг.

Казахстантай - Хил хамгаалалт, хуурай замын цэргийн сургалт, хамтарсан цэргийн сургуулилтад хамтран оролцож, хоёр улсын аюулгүй байдлын уялдаа холбоог бэхжүүлж байна.

Тажикистан улстай - Хил дамнасан аюул занал (терроризм, хар тамхины наймаа)-ын эсрэг хамтын ажиллагаа чухал байр суурь эзэлдэг.

Узбекистантай - Сүүлийн жилүүдэд Узбекистан-Кыргызстаны батлан хамгаалах хамтын ажиллагаа идэвхжиж, хил хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэж байна.³⁴

Бүс нутгийн тогтвортой байдалд оруулж буй хувь нэмэр

Кыргызстан нь Төв Азийн аюулгүй байдлын сүлжээнд голлох үүрэгтэй орнуудын нэг бөгөөд:

Терроризм, экстремизмийн эсрэг хамтын ажиллагаа - Бүс нутгийн хэмжээнд тогтмол хамтарсан сургуулилт зохион байгуулж, террорист бүлэглэлүүдийн аюулыг бууруулахад оролцож байна.

Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх - Хар тамхины хууль бус наймаа, зэвсгийн хууль бус худалдаа, хууль бус цагаачлалтай тэмцэх бүс нутгийн хамтарсан ажиллагаанд идэвхтэй байна.

Энхийг сахиулах оролцоо - Бүс нутгийн болон олон улсын энхийг сахиулах ажиллагаанд цэргүүдээ илгээж, олон улсын тавцанд нэр хүндээ нэмэгдүүлж байна.

Кыргызстан Улсын батлан хамгаалах хамтын ажиллагаа нь бүс нутгийн тогтвортой байдал, терроризмын эсрэг хамтын ажиллагаа, том гүрнүүдийн стратегийн тэнцвэрийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Гадаад бодлого, олон улсын оролцооны онцлог

Кыргызстаны батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаа нь зөвхөн бүс нутагт хязгаарлагдахгүй, олон улсын хүрээнд өргөжиж байна.

- НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох - Кыргызстаны цэргийн алба хаагчид НҮБ-ын мандатын хүрээнд хэд хэдэн бүс нутагт үүрэг гүйцэтгэжээ.

- Европын холбоо, АНУ-тай харилцаа - Цэрэг-стратегийн томоохон түншлэл тогтоохгүй ч болов, аюулгүй байдлын шинэ чиглэл болох кибер аюулгүй байдал, хил хамгаалалт зэрэг салбарт хамтран ажиллаж байна.

Сорилт, бэрхшээл

Кыргызстаны батлан хамгаалах хамтын ажиллагаанд тулгарч буй сорилтуудыг дараах байдлаар дүгнэж болно:

1. Эдийн засгийн чадавх сул - Батлан хамгаалах төсөв хязгаарлагдмал тул гадаад хамтын ажиллагаанаас ихээхэн хамааралтай.
2. Дотоод улс төрийн тогтворгүй байдал - Улс төрийн хувьсгал, дотоодын сөргөлдөөн нь батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлдөг.
3. Терроризм ба экстремизм - Бүс нутагт исламын радикал бүлгүүдийн нөлөө тогтмол аюул учруулж байна.
4. Геополитикийн өрсөлдөөн - АНУ, Орос, Хятад зэрэг гүрнүүдийн ашиг сонирхлын огтлолцол нь гадаад хамтын ажиллагаанд тэнцвэр олоход төвөгтэй.

³⁴ <https://www.ankasam.org/anka-analizler/current-developments-in-russia-kyrgyzstan-military-cooperation/>

Бүгд Найрамдах Кыргызстан Улсын батлан хамгаалах хамтын ажиллагаа нь түүний үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг бөгөөд бүс нутгийн тогтвортой байдал, олон улсын хамтын ажиллагааны чухал тулгуур болж байна.

- ОДКБ, ШХАБ зэрэг бүс нутгийн байгууллагын хүрээнд хамтарсан сургуулилт, терроризмын эсрэг хамтын ажиллагаа нь батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлж байна.

- Орос, Казахстан, Хятад зэрэг хөрш орнуудтай байгуулсан хоёр талын гэрээ хэлэлцээр нь батлан хамгаалах салбарын уялдааг бэхжүүлж байна.

- Гэсэн хэдий ч дотоод улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хязгаарлагдмал чадавх нь батлан хамгаалах хамтын ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлсөөр байна.

Цаашид Кыргызстан улс батлан хамгаалах хамтын ажиллагаагаа эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, бүс нутгийн тэнцвэртэй, харилцан ашигтай харилцааг эрхэмлэх нь үндэсний аюулгүй байдлын баталгааг хангах гол нөхцөл болох юм.

НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Энэхүү бүлэгт үндэсний аюулгүй байдал болон гадаад хамтын ажиллагааны онолын үндэс, үзэл баримтлал, арга зүйн хүрээ, мөн Монгол Улсын нөхцөл байдалд холбогдох онцлогийг шинжилж, суурь онолын ойлголтуудыг авч үзлээ.

Юуны өмнө, үндэсний аюулгүй байдал нь зөвхөн цэрэг-улс төрийн хамгаалалт, батлан хамгаалах бодлогоор хязгаарлагдахгүй, харин эдийн засгийн тогтвортой хөгжил, нийгмийн зохион байгуулалт, мэдээллийн аюулгүй байдал, кибер орон зай дахь эрсдэлийн менежмент, хүрээлэн буй орчны тогтвортой байдал зэрэг олон хэмжээст ойлголтыг хамарсан цогц шинжтэй болох нь судалгаанаас харагдаж байна. Энэ нь аюулгүй байдлыг зөвхөн нэг салбарт бус, хүн-нийгэм-улс-бүс нутаг-дэлхий гэсэн шаталсан түвшинд харилцан уялдаа бүхий байдлаар авч үзэхийг шаарддаг болохыг харуулж байна. Үүнээс гадна, аюул ба эрсдэл гэсэн хоёр ойлголтыг ялгаж тодорхойлох нь чухал бөгөөд бодит аюулыг зогсоох, эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг хослуулан хэрэгжүүлэх нь үндэсний аюулгүй байдлыг хангах онолын болон практик шаардлага болохыг дүгнэв.

Хоёрдугаарт, олон улсын харилцааны онолын чиг хандлагууд болох реализм, либерализм, конструктивизмын онолын тайлбаруудыг харьцуулан судалснаар Монгол Улсын аюулгүй байдлын нөхцөлд эдгээрийг хэрхэн уялдуулан ашиглаж болох боломжийг тодорхойлов. Реализмын хандлагаар Монгол Улсын хувьд газарзүйн онцлог, хоёр их гүрний дунд орших геополитикийн орчин, тусгаар тогтнолын баталгаажуулалт онцгой ач холбогдолтойг харуулж байна. Харин либерализмын онолын хүрээнд Монгол Улс олон улсын байгууллагууд, бүс нутгийн хамтын ажиллагаа, гуравдагч хөршийн бодлогоор дамжуулан өөрийн аюулгүй байдлыг бэхжүүлэх боломжтойг нотоллоо. Конструктивизмын хандлага нь Монголын түүхэн ухамсар, нүүдэлчин соёлын өвөрмөц үнэт зүйл, ардчилсан үнэт зүйлд суурилсан “энхийг эрхэмлэгч улс” гэсэн олон улсын имижийг ашиглан аюулгүй байдлаа баталгаажуулах боломжийг тодотгож байна.

Гуравдугаарт, гадаад хамтын ажиллагааны онолуудыг — харьцангуй давуу тал, институционализм, харилцан хамаарал, неореализм — суурь судалгааны хүрээнд задлан шинжлэхэд эдгээр нь улс орнуудын хамтын ажиллагааны мөн чанарыг тайлбарлахад чухал ач холбогдолтой болох нь харагдлаа. Харьцангуй давуу талын онол нь улс орнууд эдийн засгийн үр ашгаа харилцан солилцох замаар хамтран ажиллах боломжийг тайлбарладаг бол институционализм нь хамтын ажиллагааг тогтвортой байлгахын тулд олон улсын байгууллагууд, хэм хэмжээ, эрх зүйн тогтолцооны ач холбогдлыг тодотгодог. Харилцан хамаарлын онол нь улс орнуудын эдийн засаг, нийгэм, соёлын уялдаа холбоо улам бүр гүнзгийрэхийн хэрээр хамтын ажиллагаа зайлшгүй болохыг нотолж байна. Неореализмын онол нь хамтын ажиллагаа тогтворгүй, харилцан ашиг сонирхлын хүрээнд түр зуурын шинжтэй гэж үздэг бөгөөд энэ нь бодит нөхцөлд жижиг улс орнуудын эмзэг байдлыг илүү тодотгож өгч байна. Иймээс эдгээр онолуудын харилцан нөхцөлдсөн уялдаа нь хамтын ажиллагааны тогтвортой байдлыг тайлбарлах суурь онолын үндэс болж байна.

Дөрөвдүгээрт, үндэсний аюулгүй байдал болон гадаад хамтын ажиллагаа нь салшгүй уялдаа холбоотой, харилцан бие биеэ нөхдөг болохыг тодорхойллоо. Дотоод аюулгүй байдлын бат бөх суурьгүйгээр гадаад хамтын ажиллагаа өргөжин

хөгжих боломжгүй бөгөөд нөгөө талаас олон улсын хамтын ажиллагаа, түншлэл, гуравдагч хөршийн бодлого зэрэг өргөн хүрээний идэвхтэй оролцоогүйгээр үндэсний аюулгүй байдлыг тогтвортой баталгаажуулах боломжгүй юм. Энэ харилцан хамаарал нь Монгол Улсын хувьд стратегийн түвшинд тод томруун илэрч, гадаад бодлого нь аюулгүй байдлыг хангах гол хэрэгсэл болж байгааг харуулж байна.

Эцэст нь, суурь судалгааны хүрээнд хийсэн энэхүү дүгнэлт нь үндэсний аюулгүй байдал болон гадаад хамтын ажиллагааны харилцан уялдааг онолын түвшинд системтэйгээр тайлбарлаж, цаашдын судалгаанд практик ач холбогдол бүхий суурь ойлголт, арга зүйн чиглэлийг тодорхойллоо. Энэ нь дараагийн бүлгүүдэд кейс судалгаа, харьцуулсан дүн шинжилгээ, бодлогын үнэлгээ хийхэд суурь үндэс болж, Монгол Улсын аюулгүй байдлын судалгаа, гадаад бодлогын төлөвлөлтөд онолын болон практик хосолсон суурь баримжаа өгч байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ БАТЛАН ХАМГААЛАХ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

2.1 БАТЛАН ХАМГААЛАХ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, ЧИГЛЭЛ

Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны бодлого, чиглэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэстэй салшгүй холбоотой.

Дээрх бодлогын баримт бичгүүдийн агуулгад үндэсний аюулгүй байдлыг хангахад “улс төр, дипломатын аргыг урьтал болгоно” гэж заасан.

Энэхүү “улс төр, дипломатын арга” нь “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” гэсэн төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын үндсэн чиглэлүүдийг агуулсан тул аюулгүй байдлаа хангах улс төр, дипломатын арга, механизмыг бий болгох, хэрэгжүүлэхийг чухалчлан чиглүүлсэн.

“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д:

- “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа байна. Энэ хүрээнд олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ”,

- “Энхийг эрхэмлэсэн гадаад бодлогоо тууштай баримталж, энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжинэ”,

- “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ”,

- “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ”,

- “Хөрш хоёр орон, АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Европын Холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно”,

- “Монгол Улсын олон улсын аюулгүй байдлыг баталгаажуулах асуудлаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн тогтоолуудын үзэл санааг хэрэгжүүлэх чиглэлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөлийн гишүүн орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллана”,

- “Ази, Номхон далайн бүс нутаг Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааны

механизм бий болгоход чиглэсэн бүс нутгийн орнуудын бодлого, үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж оролцоно” гэжээ.

Дээр дурдсан бодлогын баримт бичгүүдийн хүрээнд Үндэсний аюулгүй байдлыг хангахад батлан хамгаалах салбарын зүгээс гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, Монгол Улсын аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангахад дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх болон харилцаа, хамтын ажиллагаатай улс орнууд, олон улсын байгууллагуудтай харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, цэргийн дипломатын албыг бэхжүүлэх, батлан хамгаалах чадавхыг дээшлүүлэх, Зэвсэгт хүчний хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэсэн гадаад хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх, харилцаа, хамтын ажиллагаатай улс орнуудтай олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, Зэвсэгт хүчнийг энхийг дэмжих ажиллагаа, олон улсын сургалт, дадлагад оролцуулах бодлогын хэрэгжилтийг хангах, гадаад улс, олон улсад зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд зочид, төлөөлөгч оролцуулах, цэргийн боловсон хүчнийг гадаад орнуудад сургаж, бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр амжилттай ажиллаж байна.

“Гадаад бодлогын үзэл баримтлал”-д:

- “Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал мөн”

- “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн”

- “Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна”

- “Монгол Улс бусад улстай харилцахдаа бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтнох бүрэн эрхийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, түүнчлэн хоёр талын харилцааны үндсэн баримт бичгүүдэд заасан бусад зарчмыг удирдлага болгоно”

- “Дэлхий, бүс нутагт нөлөө бүхий улсуудтай харилцаа, хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэхийг зорихын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ”

- “Олон улсын харилцааны хөгжил, дэлхийн болон бүс нутгийн улс төрийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогын чиглэл, зорилтыг уян хатан тогтооно” гэсэн үндсэн зорилтуудыг тодорхойлсон байна.

Дипломат ажиллагаа бол олон улсын эрх зүйн хэм хэмжээг хүндэтгэх, харилцан буулт хийх, зөвшилцөх замаар бусад үндэстэнтэй харилцах арга юм. Энэ утгаараа дипломат ажиллагаа бол гадаад бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга зам болно. Улс төр-дипломатын аргыг ашиглахдаа гадаад бодлогын дүн шинжилгээнд суурилсан хувилбарыг сонгох шаардлагатай байна.

УИХ-аар 2000 онд баталсан Дипломат албаны тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 3.1-д “Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрхзүйн хэм хэмжээний хүрээнд Монгол Улсын төрийн гадаад бодлогын зорилт, чиг үүргийг нэгдмэл, залгамж чанарыг хадгалах замаар хэрэгжүүлэх мэргэшсэн үйл ажиллагааг дипломат алба гэнэ” хэмээн тодорхойлж, 5.1.7-д “Монгол Улсын нэгдмэл, залгамж чанартай гадаад бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Монгол Улсын төр, засгийн албан ёсны байр суурийг илэрхийлнэ” хэмээн ГХЯ-ны чиг үүргийг тус тус тодорхойлсон. Хуулийн дагуу Монгол Улсын нэгдмэл, залгамж чанартай гадаад бодлогыг хэрэгжүүлэх ажлыг ГХЯ зохион байгуулж, Монгол Улсын төр, засгийн албан ёсны байр суурийг илэрхийлдэг боловч улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах, аливаа эрсдэл сорилтыг бууруулах үйл ажиллагаа дан ганц ГХЯ-ны хариуцах ажил биш юм.

Монгол Улс улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах хүрээнд гадаад бодлогодоо үндэсний ашиг сонирхлыг дээдлэх, дэлхийн бүх улстай найрсаг хамтын ажиллагаа хөгжүүлэх болон энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх талаар олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс гаргаж байгаа хүчин чармайлтад өөрийн боломжийн хэрээр идэвхтэй хувь нэмэр оруулах зорилт тавин ажилладаг.

Монгол Улс улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангахад батлан хамгаалах салбар хийгээд түүний гадаад харилцааны асуудал хариуцсан нэгжүүд чухал үүрэг гүйцэтгэж, дэмжлэг үзүүлж, хувь нэмрээ оруулж, олон улсын цэргийн үйл ажиллагаанд тогтмол идэвхтэй оролцсоны үр дүнд монгол цэргийн нэр хүнд өссөнөөр батлагдаж байгаа билээ.

“Монгол улсын улс төрийн гадаад харилцааны бодлого”-д:

Монгол Улсын улс төрийн гадаад харилцааны бодлогын зорилго нь тус улсын аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчин бүрдүүлэх, дипломат болон консулын харилцааг хөгжүүлэх, нөлөө бүхий улсуудтай харилцааныхаа түвшнийг дээшлүүлэх, олон улсын байгууллага дахь үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахад оршино. Үүнд цэрэг-батлан хамгаалах салбарын болон түүний гадаад бодлогод уялдуулж тусгасан заалтаас онцолж дурдахад;

- Монгол Улсад гаднын цэргийн аюул занал учраагүй нөхцөлд цэргийн аливаа холбоонд нэгдэхгүй, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй байх, гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх чиг шугам баримтална.

- Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд бүс нутгийн болон дэлхийн чанартай тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бүх нийтийн үйл хэрэгт хувь нэмэр оруулахыг чармайна гэж заасан. Тухайлбал (зөвхөн цэрэг-батлах хамгаалах салбартай холбогдох заалтыг иш татаж онцлон авсан болно):

- цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсэг үл дэлгэрүүлэх, зэвсэг хураах, олон улсын терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, НҮБ-ын болон олон улсын энхийг дэмжих, сахиулах, сэргээн босгох үйл ажиллагаанд оролцох;

Энэхүү заалттай холбогдох эрх зүйн нэгэн чухал баримтаас дурдахад:

Үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангах чиглэлд хийсэн Монгол Улсын анхны томоохон зоримог алхам нь Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1992 оны 9 дүгээр сарын 25-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 45 дугаар чуулганы индэр дээрээс Ерөнхий санал шүүмжлэлд үг хэлэхдээ: “Монгол Улс зэвсэг хураах хийгээд бүс нутаг, дэлхий дахинд итгэлцлийг бэхжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах үүднээс өөрийн нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлан тунхаглаж байна. Үүнийгээ цаашид олон улсын хэмжээнд баталгаажуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг эрмэлзэх болно” хэмээн зарлаж, улмаар цөмийн зэвсэгтэй таван улсаар хүлээн зөвшөөрүүлсэн нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах бодлогын үр дүнтэй хэрэгжилт болсон юм.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй (Single State Nuclear Weapon free zone) бүс хэмээн зарласан явдлыг олон улсын хамтын нийгэмлэг сайшаан хүлээн авч, дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд үүний илрэл нь “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай тогтоолыг анх 1998 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганаар батлуулсан явдал юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1998 оноос хойш хоёр жил тутам баталж байгаа “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай тогтоолд “тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах, улс төр, эдийн засаг, экологийн аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статусыг бэхжүүлэх” тухайд Монгол Улстай хамтран ажиллахыг НҮБ-ын гишүүн улс, орнуудад уриалсан байдаг нь үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангах бодлого тасралтгүй хэрэгжиж байгаагийн баталгаа гэж болно.

Улс төрийн гадаад харилцааны бодлогоо хэрэгжүүлэхдээ дараах чиглэлийг баримтална хэмээн тодорхойлсон. Үүнд:

- ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ;

- АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлнэ;

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогын нэг чухал зорилт нь тус улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээний хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах, гадаад бодлогын тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэх чиглэлд “гуравдагч хөрш”-тэй нягт хамтран ажиллаж, Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй бүсийн статусыг олон улсын эрх зүйгээр баталгаажуулах хэрэгт дэмжлэг авах явдалд оршино.

Монгол Улс "гуравдагч хөрш"-ийн бодлогынхоо хүрээнд өндөр хөгжилтэй, ардчилсан улс орнуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхийг тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хангах гол арга зам гэж тодорхойлсон. Энэ ч зорилгоор Япон, Энэтхэг, Америк, Турк, Герман, Өмнөд Солонгос, Канад, Австрали зэрэг бүс нутгийн өндөр хөгжилтэй, ардчилсан улс орнуудтай түншлэлийн харилцаа тогтоон хөгжүүлж байна. "Гуравдагч хөрш"-ийн бодлогын гол агуулга нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс төдийгүй дэлхийн нөлөө бүхий бусад улс гүрнүүдийн геополитик, гео-эдийн засаг, стратегийн сонирхол, нөлөө, хамаарлаас давхар шалтгаалж байх улс төр, эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино. Өөрөөр хэлбэл: Өрнө, Дорнын өндөр хөгжилтэй, ардчилсан орнуудтай харилцах харилцаа нь манай "гуравдагч хөрш"-ийн бодлогын суурь болно хэмээн тодорхойлжээ.

Монгол Улсын бодлогын баримт бичгүүдэд тусгаснаар "гуравдагч хөрш"-ийн бодлого нь улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн чиглэлд өндөр хөгжилтэй улсуудтай харилцахад чиглэх бол Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлд хамтран ажиллах бодлого мөн баримталж байна.

- Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох;

"Монгол улсын Батлан хамгаалах бодлогын үндэс"-т:

Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд улсын дотоод, гадаад аюулгүй байдлын орчин нь батлан хамгаалах зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно.

Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндсэн баримт бичигт "Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн" гэж тодорхойлсон байдаг. Энэ бодлогыг хэрэгжүүлэхэд батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаа чухал үүрэгтэй бөгөөд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, цэргийн дипломатын харилцааг бэхжүүлэх, олон улсын гэрээ хэлэлцээр байгуулахад чиглэгддэг.

Чиглэлүүд:

1. Олон улсын хамтын ажиллагаа: Монгол Улс нь олон улсын аюулгүй байдлын асуудалд идэвхтэй оролцож, НҮБ, ШХАБ, АСЕАН зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг. Энэ хүрээнд энхийг сахиулах ажиллагаанд

оролцох, цэргийн сургалтууд, хамтарсан дадлага, семинар зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

2. Цэргийн хамтын ажиллагаа: Монгол Улс нь гадаад улс орнуудтай цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, цэргийн чадавхыг бэхжүүлэх, хамтарсан сургалт, дадлага, хурал, семинар зохион байгуулах замаар гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна.

3. Цэрэг-техникийн хамтын ажиллагаа: Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн хүрээнд гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэхэд чиглэгддэг.

Эдгээр чиглэлүүд нь Монгол Улсын батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийг хангах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, улс орны аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Энэ хүрээнд батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны бодлогын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, гадаад улсуудтай цэргийн итгэлцлийг бэхжүүлэх ажлыг зохицуулах, хамтын ажиллагаатай улс орон, олон улсын байгууллагатай олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулахад дэмжлэг үзүүлэх, цэргийн дипломатын албыг бэхжүүлэх, өргөжүүлэх, үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг хэрэгжүүлнэ.

Энэ нь Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн хүрээнд гадаад хамтын ажиллагаа өргөжиж, цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааны цар хүрээ өсөж, энхийг дэмжих ажиллагаа дахь Зэвсэгт хүчний оролцоо, чадавх нэмэгдсэнээр тус тус хангагдана.

2.2 БАТЛАН ХАМГААЛАХ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ӨНӨӨГИЙН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улс 1990 оноос хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг байгуулах сонголтоо Үндсэн хуулиараа баталгаажуулан нийгмийн бүхий л хүрээг хамарсан улс төр, нийгэм, эдийн засгийн олон талт өөрчлөлт хийсний нэг чухал хэсэг нь батлан хамгаалах салбарын шинэчлэл байв. Энэ нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалд суурилж батлан хамгаалах бодлогыг тодорхойлох, Зэвсэгт хүчний үүрэг зориулалт, зохион байгуулалтад зарчмын өөрчлөлт, шинэчлэлт хийх, батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон талт, өргөн цар хүрээтэй үйл ажиллагаагаар тодорхойлогдож ирсэн.

Иймд гадаад харилцааны олон талт бодлогын хүрээнд Батлан хамгаалах яам гадаад хамтын ажиллагааны чиглэлээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангахад дэмжлэг үзүүлэх, батлан хамгаалах гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, олон улсын тавцанд Монгол Улсын Зэвсэгт хүчний нэр хүндийг өргөх, бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулах, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гадаадын тусламж, дэмжлэг авахад чиглүүлэн хөгжүүлж, цаашид үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах гадаад бодлогын хүрээнд батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаа өргөжин хөгжсөөр, өнөөгийн байдлаар 39 улстай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон хамтын ажиллагаатай байгаагаас 16 улстай нь идэвхтэй, 16 улстай идэвхгүй харилцаатай байна. Эдгээр 39 улсаас цэрэг-техникийн хамтын ажиллагаатай 6 улс /ОХУ, БНХАУ, БНТУ, Украин, Беларусь, Япон улс/ байна.

Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд гадаад улсад суугаа болон гадаадын улсаас манай улсад суугаа цэргийн атташе болон атташегийн алба гол үүрэг гүйцэтгэдэг.

Батлан хамгаалахын атташегийн алба:

Батлан хамгаалахын атташегийн алба нь улс орны аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцүүлэн хоёр талын болон олон талын батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын болон бүс нутгийн түвшинд цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд тухайн сууж буй болон хавсран суугаа орнуудын холбогдох байгууллагууд, бусад орны цэргийн атташегийн албадтай хамтран ажиллаж, шаардлагатай мэдээллийг олзворлох, дүн шинжилгээ хийх, өөрийн улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг сурталчлах, мэдээлэх зэрэг үүргийг гүйцэтгэдэг.

Өдгөө манай Монгол Улсаас ОХУ, БНХАУ, АНУ, Бельгийн Хаант улс, Япон, Турк, ХБНГУ, Вьетнам, Энэтхэг, Польш, БНСУ зэрэг 11 улсад Батлан хамгаалахын атташе, атташегийн алба, мөн НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчийн газарт цэргийн зөвлөх ажиллаж байгаа бол манай улсад ОХУ, БНХАУ, АНУ, БНСУ, БНТУ, Япон, БНКазУ гэсэн 7 улсын Батлан хамгаалахын атташегийн алба ажиллаж байна.

Үүний зэрэгцээ НҮБ, НАТО, ЕАБХАБ зэрэг дэлхийн болон бүс нутгийн хамтын нийгэмлэгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Монгол Улсын батлан хамгаалах гадаад харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай болон бүс нутгийн хамтын ажиллагаатай орнууд болох БНХАУ, БНЭУ, БНСВУ, БНАЛАУ, БНКиргизУ, БНТУ, ИБУИНХУ-ын Батлан хамгаалахын сайд, НАТО-ийн Цэргийн зөвлөлийн дарга, ОХУ-ын ЗХЖШ-ын дарга, НҮБ-ын ЕНБД-ын орлогч бөгөөд Энхийн ажиллагааны газрын дарга, БНТУ-ын ЗХЖШ-ын дарга, Японы Нэгдсэн штабын дарга, НҮБ-ын ЕНБД-ын даргын цэргийн зөвлөх зэрэг өндөр албан тушаалтнууд 2016-2020 онд Монгол Улсад айлчилж, талуудын харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байна.

Монгол Улсын батлан хамгаалах гадаад харилцаа стратегийн түвшинд улс орны аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд бодлогын түвшинд батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалт, талуудын харилцан айлчлалаар салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, дэлхийн болон бүс нутагт үүссэн цэрэг-улс төрийн болоод цаг үеийн нөхцөл байдлын талаар харилцан мэдээлэл, санал солилцох зэргээр хөгжиж байна.

1990-ээд оноос өмнө батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагаа улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан хязгаарлагдмал байдлаар хөгжиж, зөвхөн социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хүрээнд цөөн тооны айлчлал, уулзалтууд болж байжээ.

1991 онд Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар “Батлан хамгаалахын гадаад харилцааны үзэл баримтлал”, “Монголд суух гадаадын цэргийн атташегийн журам”, “Гадаад оронд суугаа Монголын цэргийн атташегийн дүрэм”, “Гадаадын орнуудтай цэргийн салбарт хамтарч ажиллах журам”, “Цэргийн алба хаагчдыг гадаадад явуулах журам”-ын төслүүдийн саналыг анхлан боловсруулж, удирдлагад танилцуулсан зэрэг нь цэргийн дипломат харилцааг эрх зүйн талаас нь шинэчлэх алхам болсон.

1990 оноос эхлүүлсэн батлан хамгаалах шинэчлэлийн хугацаанд гадаад хамтын ажиллагааны хүрээнд холбогдох сайдын түвшний болон яамд хоорондын зөвлөлдөх уулзалтуудаар бодлогын чанартай хэд хэдэн чухал гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулсан ба гарсан шийдвэрүүд өнөөг хүртэл хэрэгжсээр байгааг ач холбогдлоо алдаагүйн нотолгоо гэж хэлж болно.

Энэ хугацаанд 20 орчим удаагийн сайд нарын түвшний харилцан айлчлалууд хийгдэж, тухайн хоёр талын батлан хамгаалах гадаад харилцааг хөгжүүлэх, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлуудаар харилцан санал солилцож байна. Түүнчлэн тогтмол харилцаатай хоёр хөршөөс гадна “гуравдагч хөрш” орнуудтай тухайн хугацааны хамтын ажиллагааны үр дүнг хэлэлцэж, цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсээр байна.

Мөн батлан хамгаалах салбарт хамтын ажиллагаатай гадаадын орнуудтай цэргийн салбарын олон чиглэлээр 130 орчим гаруй гэрээ, хэлэлцээр байгуулж, амжилттай хэрэгжиж байгаа нь манай улсын батлан хамгаалах хөгжлийг ахиулахад зохих үр дүнгээ үзүүлсээр байна.

1991 онд Батлан хамгаалах яам дэлхийн хамгийн том гурван улстай цэргийн албан ёсны харилцаатай болж чадсан нь цаашид өөрийн гэсэн бодлоготойгоор

олон улсын харилцаанд аюулгүй байдлаа улс төрийн аргаар хангахад цэргийнхэн өөрсдөө оролцох бололцоо нээгдсэн юм.

Тухайн онд Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Ш.Жадамба тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д ажлын айлчлал хийж, хоёр улсын Батлан хамгаалахын атташег харилцан томилж суулгах, мөн АНУ-аас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Батлан хамгаалахын атташе Монгол Улсад хавсран суухаар болсон зэрэг үйл явдлыг онцлон дурдах нь зүйтэй хэмээн үзлээ. Уламжлалт сайн харилцаагаа үргэлжлүүлэн хамтран ажиллах чиглэлийн дагуу ОХУ-ын БХЯ-ны сайд манай улсад айлчилж, ОХУ-тай цэргийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслүүд боловсруулагдан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдэж шийдэгдсэн нь цаашдын хамтын ажиллагааны бат бөх суурийг тавих үндэслэл болсон.

Монгол-Америкийн цэргийн хоорондын албан ёсны харилцааг ГХЯ-аар дамжуулан тогтоосны үр дүнд ЗХУ, БНХАУ-д суугаа АНУ-ын Батлан хамгаалахын атташе нар Монгол Улсад айлчилснаар хоёр талын цэргийн харилцаа хөгжих үндэс тавигдсан гэж үзэж болох юм.

1992-1996 онд БХЯ-наас баримтлах бодлого, арга хэмжээний үндсэн чиглэлийг удирдлага болгож, батлан хамгаалахын гадаад таатай нөхцөлийг бий болгох чиглэлийн хүрээнд олон үйл ажиллагаа зохион байгуулсны дотор Монгол Улсаас ОХУ, БНХАУ, АНУ-д суух ЭСЯ-дад батлан хамгаалахын атташе нарыг шинээр томилуулан ажиллуулсан явдал байв. Түүнчлэн ХБНГУ, БНСУ-тай цэргийн харилцааг шинээр тогтоож, АНУ-аас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Хуурай замын цэргийн атташе Монгол Улсын хавсран суух болсноор эдгээр орнуудтай цэргийн салбарт урт хугацаанд хамтран ажиллах боломж нээгдсэн.

Хоёр талт цэргийн харилцааны үндсийг бүрдүүлэх зорилгоор 1992 онд “Цэрэг-техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”, 6 дугаар сарын 28-нд “Цэргийн хамтын ажиллагааны тухай Батлан хамгаалах яамд хоорондын хэлэлцээр” зэрэг хэд хэдэн гэрээ хэлэлцээр байгуулсан эрх зүйн баримт бичгийг үндэслэж тухайн оны эхээр Монгол Улс, ХБНГУ-ын хооронд цэргийн дипломат харилцаа тогтоосон нь талуудын цэргийн салбар дахь харилцаа, хамтын ажиллагааны эхлэл болсон юм.

1995 онд АНУ, ХБНГУ-тай харилцах цэргийн харилцаанд ахиц гарч, ОХУ-тай тогтоосон цэргийн харилцаанд нааштай алхмууд хийгдэж, цаашлаад Израиль, Польш, Канад улсуудтай цэргийн харилцааг албан ёсоор тогтоож, харилцаа өргөжин тэлэх болсон.

1996-1997 онуудад Монгол Улсын Гадаад харилцааны үзэл баримтлал, шинэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг мөрдлөг болгон цэргийн гадаад харилцааг өргөжүүлэх, цэргийн хамтын ажиллагааны үр өгөөжийн нэмэгдүүлэх, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын армиудын олон улсын арга хэмжээнд идэвхтэй оролцох чиглэл баримтлан үйл ажиллагаагаа явуулснаар Монгол Улсад сууж байгаа болон бусад орноос хавсран сууж байгаа гадаадын цэргийн атташе нартай харилцаа идэвхжиж харилцан айлчлах, мэдээлэл солилцох, боловсон хүчин сургах, хамтарсан сургууль явуулах, тусламж дэмжлэг, гэрээр хэлэлцээр байгуулах зэрэг асуудлуудыг зохицуулж ирсэн хөгжлийн идэвхтэй он жилүүд байлаа.

1997 оноос цэргийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа урьд өмнөхөөсөө илүү эрчимжиж, БХЯ-наас гадаад харилцааны үзэл баримтлалыг боловсруулан

цэргийн харилцааг өргөжүүлэн бэхжүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байсны сацуу Батлан хамгаалах улс төрийн гадаад бодлогод улс төр-дипломатын аргыг эн тэргүүнд тавьж, хоёр хөрш болон дэлхийн нөлөө бүхий улс оронтой цэргийн харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлж, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг явуулж байсан.

1998-2000 онуудад батлан хамгаалах салбарын гадаад харилцааг өргөжүүлэхэд чиглэсэн хэд хэдэн чухал арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулснаас дурдахад; 1999 онд Швейцарийн Холбооны Улс, БНТУ, Их Британи Умард Ирландын Вант Улс, БНКазУ-тай батлан хамгаалах атташегийн түвшинд харилцаа тогтоосноор атташегийн түвшинд харилцагч орны тоо 14 болон өсөж, БНСУ, Турктэй цэргийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулж, Япон, БНСУ-д Монголын Зэвсэгт хүчний алба хаагчдыг сургаж эхэлсэн. Цэргийн гадаад харилцаа өргөжин тэлэхийн хэрээр гадаад орнуудаас үзүүлж буй тусламжийн хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан 2000 онд Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлан хамгаалах салбарт гадаадын орнуудаас ирүүлсэн буцалтгүй тусламжийн эд хөрөнгийг хуваарилах, зарцуулах, ашиглах, бүртгэж тооцох ажиллагааг зохицуулахын тулд “Гадаадын тусламжийн эд хөрөнгийг зохицуулах журам”-ыг батлан мөрдүүлснээр энэ талын асуудлын хяналтын системийг бүрдүүлэх эхлэлийг бий болгосон.

2000-2015 он

Дээрх онуудад айлчлал, зөвлөлдөх уулзалт, гэрээ хэлэлцээрүүд нэмэгдэж, гадаад харилцаа тогтвортой хөгжиж байсны нэг илрэл нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан 2002 онд Монголд айлчлах үеэрээ НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд оролцохыг уриалсан ба үүний дагуу тухайн 2002 онд НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагч, багийг оролцуулах холбогдох хууль тогтоомжийн хүрээнд анх удаа Монголын Зэвсэгт хүчний хоёр алба хаагч энхийг сахиулагчаар үүргээ амжилттай гүйцэтгэснээр өнөөгийн энхийг сахиулагчдын зам мөрийг нээсэн явдал байв.

Энэ нь “АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Европын Холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно” гэсэн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын заалт биеллээ олж, аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангахад онцгой үүрэг гүйцэтгэж байна.

Анхны хоёр цэргийн алба хаагчийн үйл хэргийн түүчээ болж, Иракийн дайны дараах сэргээн босгох, хүмүүнлэгийн ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Олон үндэстний цэргийн ажиллагаанд Монголын цэргийн баг оролцож үүргээ амжилттай гүйцэтгэсэн нь манай улс бие даасан гадаад бодлоготой улс болохоо харуулсны зэрэгцээ НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд бусад улс орны цэргүүдтэй хамтран үүрэг гүйцэтгэх чадвартайн бодит нотолгоо болсон.

2005 онд Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа өргөжиж, Монгол Улсын цэргийн багийг НҮБ-ын мандаттайгаар Сьерра-Леон болон Косовод олон

улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах болсноор Зэвсэгт хүчний нэр хүнд олон улсын тавцанд өсөж, энэ чиглэлээр цаашид ахихад түлхэц болсон.

2009 онд Засгийн газрын хуралдаанаар, ТАБНЧадУ-д явагдаж байсан НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд мото-буудлагын батальон илгээх шийдвэр гарсан; Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр Зэвсэгт хүчнээс ХБНГУ-ын цэргийн багтай хамтран Афганистан Улсад үүрэг гүйцэтгэх асуудлыг шийдвэрлүүлж, монголын цэргийн багийг ажиллагааны газар орон руу илгээж эхэлсэн зэрэг нь Үндэсний аюулгүй байдлыг улс-төр, дипломатын аргаар хангах маш чухал баталгаа болж байлаа.

Батлан хамгаалах гадаад харилцаанд тодорхой байр суурь эзлэх болсон энхийг сахиулах ажиллагаанд монгол цэргийн үүрэг гүйцэтгэх ур чадвар, нэр хүнд олон улсад танигдсаны үр нөлөөгөөр анх удаа манай улсын Зэвсэгт хүчний 850 хүнтэй мото-буудлагын батальон дэлхийн хамгийн залуу улс болох БНӨСҮ-д НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд 2012 оноос өнөөг хүртэл үүргээ нэр төртэй гүйцэтгэж олон улсад Зэвсэгт хүчний нэр хүндийг улам өсгөөд зогсохгүй манлайлан оролцож байна.

2015 оноос хойш Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Филиппин Улсын Батлан хамгаалах яамд хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг (2022 он); Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс, БНАЛАУ-ын Батлан хамгаалах яамд хоорондын гэрээ (2022 он); Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах, айлчлал солилцооны тухай Монгол Улс, АНЭУ-ын Батлан хамгаалах яамд хоорондын гэрээ (2023 он) байгуулагдаж салбарын гадаад хамтын ажиллагаа улам өргөжсөөр байна.

2016-2024 он

Батлан хамгаалахын сайд, ТНБД (Төрийн нарийн бичгийн дарга), ЗХЖШ-ын дарга тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д 10 удаа, ОХУ-д 9 удаа, АНУ-д, 3 удаа, БНСУ-д 7 удаа, БНТУ-д 3 удаа, БНЭУ-д 3 удаа, Япон Улсад 5 удаа, Катар Улсад 2 удаа, ХБНГУ-д 3 удаа, БНСВУ-д 3 удаа, Итали, Тайланд, Сингапур, Канад, Франц, Унгар, АНЭУ, БНБелУ, БНКиргизУлс, БНӨСҮ, БНАЛАУ, Фижи Улсад тус тус 1 удаа нийт 60 орчим удаагийн албан болон ажлын айлчлал хийсэн бол;

Монгол Улсад гадаадын орны батлан хамгаалахын сайд болон дэд сайдын албан ёсны ба ажлын айлчлал, ЗХЖШ-ын төлөөлөгчдийн 70 орчим удаагийн айлчлалууд зохион байгуулагджээ. Үүнээс ОХУ-аас 12, БНХАУ-аас 2, Япон Улсаас 7, АНУ-ын болон тус улсын Номхон далай дахь цэргийн командлалаас 9, БНСУ-аас 3, БНФУ-аас 3, ХБНГУ-аас 2, БНСВУ-аас 4, БНАЛАУ-аас 2 удаа, БНКиргизУ, Австрали, АНЭУ, Их Британи, БНТУ, Канад Улс, Итали, Австрали зэрэг улсаас тус тус 1 удаагийн айлчлал зохион байгуулагдсан байна.

2020-2021 онд дэлхий нийтээр тархсан Ковид цар тахлын улмаас зарим төлөвлөгөөт гадаад арга хэмжээнүүд хойшилж байв.

Мөн дээрх хугацаанд гадаад улсын Батлан хамгаалах яамдуудтай нийт 70 орчим удаагийн зөвлөлдөх болон ажлын уулзалтуудыг зохион байгуулж БХЯ-д хооронд хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ, тодорхой асуудлуудын арга замыг тодорхойлж, үр дүнтэй ажиллаж иржээ.

Гэрээ, хэлэлцээр, санамж бичиг

Батлан хамгаалах салбарт хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэхэд байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичгүүд нь хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, гадаад харилцааны чиглэлийг тодорхойлоход томоохон түлхэц болж, ач холбогдлоо хадгалсаар байгаа төдийгүй цаашид олон улстай харилцаагаа ахиулахад үр дүнтэй эрх зүйн зохицуулалт юм. Тухайлбал;

ОХУ-ын Цэрэг-техникийн хамтын ажиллагааны холбооны албаны орлогч захирал тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад 2016 хийсэн айлчлалын үеэр Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрийн үйлчлэлийг 2016 он дуустал сэргээх тухай Засгийн газар хоорондын протоколд гарын үсэг зурсан.

2016 онд “Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан.

2017 онд ОХУ-ын Кызилын кадетын сургуульд Монголоос сонсогч суралцуулах тухай гэрээ байгуулж, ОХУ-ын Батлан хамгаалахын сайдын 177 дугаар тушаалаар Монголын анхны 3 сонсогч 2017 оноос Кызилын кадетын сургуульд суралцаж эхэлсэн.

2019 онд ОХУ-аас Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрийн үйлчлэлийг 2023 он дуустал сэргээх тухай Засгийн газар хоорондын протоколд талуудын БХЯ-дын удирдлагын төлөөлөл гарын үсэг зурав.

2019 онд Цэргийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.

2019 онд Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг Батлан хамгаалахын сайдын БНСВУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Ханой хотноо байгуулав.

Сургалт

2018 онд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, тусгай үүрэг болон энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр яамны гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн гадаадын улсуудын цэргийн академи, их дээд сургууль болон урт богино хугацааны сургалт дамжаанд нийт 1600 орчим цэргийн алба хаагч суралцаж хамрагджээ. Үүнээс ОХУ-ын цэргийн академи, их дээд сургуульд суралцагсдын тоо зонхилох хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нэг талаараа цэргийн сургалт, бэлтгэлийн тогтолцоо ижил төстэй байдагтай холбоотой байж болох юм.

ОХУ-д Кызилын кадетын сургуульд 2019-2020 оны хичээлийн жилээс шинээр суралцуулж сурагчид эхэлсэн. Үүнийг цэргийн мэргэжлийн боловсролыг өсвөр наснаас нь олгож ирээдүйн цэргийн боловсон хүчнийг бэлтгэх төрийн цэргийн бодлогоор зохицуулж буйгаас гадна хоёр улсын БХЯ-д хоорондын зөвлөлдөх уулзалтууд, харилцан айлчлалын үр дүн гэж хэлж болно.

2021, 2023 онуудад АНУ-ын “Олон улсын боловсрол, сургалт /IMET/”-ын санхүүжилт, “Дэлхийн Энхийн санаачилга /GPOI/” хөтөлбөрийн санхүүжилт болон Канад Улсын “Цэргийн сургалт, боловсролын хөтөлбөр /МТЕР/”-ийн хүрээнд зохион байгуулагдсан дунд, богино хугацааны сургалт, дамжаанд давхардсан тоогоор нийтдээ 200 орчим цэргийн алба хаагч суралцаад байна.

Цар тахлын нөхцөл байдлын улмаас зарим сургалт, дамжаа, олон улсын цэргийн арга хэмжээнүүд цуцлагдаж байсан төдийгүй тусгай үүргийн нислэгээр эх орондоо ирсэн урт хугацааны сургалттай цэргийн алба хаагчид цахим хэлбэрээр сургалтаа үргэлжлүүлж байв.

1994-2025 оны хооронд гадаадын улс оронд суралцсан цэргийн алба хаагчдын статистик мэдээллийг хүснэгтээр танилцуулахад:

д/д	Улс, орон	Суралцагчдын тоо	Тайлбар
1	ОХУ	1863	-
2	БНХАУ	701	-
3	ХБНГУ	289	-
4	БНСУ	116	-
5	Англи Улс /Ирланд/	14	-
6	АНУ	614	-
7	Япон Улс	105	-
8	БНТУ	177	-
9	БНЭУ	195	-
10	Франц Улс	22	Зогссон
11	Авсрали Улс	12	-
12	Польш Улс	14	-
13	Канад Улс	232	-
14	Катар Улс	74	Зогссон
15	БНСВУ	12	-
16	Швед Улс	6	Зогссон
17	Египит Улс	4	Зогссон
18	Люксембург	42	Зогссон
19	Финлянд Улс	2	Зогссон
20	Иран Улс	6	Зогссон
21	Швейцари	3	Зогссон
22	Непал Улс	5	-

Хамтарсан дадлага, сургууль

Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын энхийг дэмжих ажиллагаа болон олон талт үүрэг гүйцэтгэх чадвар, цэргийн хэргийн онол-практикийн мэдлэгийн түвшнийг дээшлүүлэх, цэргийн итгэлцлийг гүнзгийрүүлэх, харилцан туршлага солилцох, үүнд түшиглэсэн судалгаа шинжилгээний ажлын баазыг бэхжүүлэх зорилгоор өөрийн болон гадаадын улсуудад зохион байгуулагддаг төрөл бүрийн цэргийн хамтарсан сургууль, дадлагын тоо, цар хүрээ нэмэгдсээр байна.

Манай улс социалист системийн үед ЗХУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран зохион байгуулж байсан цөөн тооны цэргийн хээрийн сургуулилт нийгмийн шилжилтийн дараа буюу 1990-ээд оноос хойш хоёр улсын дотоод нөхцөл байдлаас шалтгаалж тодорхой хугацаанд завсардсан.

Харин 2000-аад оны үеэс Монгол улс, ОХУ-ын батлан хамгаалах хамтын ажиллагаа дахин сэргэсний дараа “Дархан” нэрээр эхэлсэн “Сэлэнгэ” хамтарсан сургууль (*Ковид цар тахлын үед буюу 2021онд тасалдсан*) жил бүр явагддаг болсон. Улмаар энэ нь ганц ОХУ-аар хязгаарлагдахаа больж, цэргийн шинэчлэлийн жилүүдэд хамтын ажиллагаа тогтоосон АНУ, Хятад, БНСУ, БНТУ, БНЭУ, Япон зэрэг орнуудтай хамтарсан дадлага, сургууль зохион байгуулдаг болсон ба эдгээрээс АНУ-тай хамтарсан “Хааны эрэлд” олон улсын энхийг сахиулах ажиллагааны өмнөх сургууль, мөн тус улстай хамтарсан тусгай хүчний хоёр талын “Баланс Мэжик” сургууль, Монгол, Оросын Зэвсэгт хүчнүүдийн хамтарсан “Сэлэнгэ” хээрийн сургууль, БНЭУ-тай хамтарсан “Нүүдэлчин Заан”, БНТУ-тай хамтарсан “Анадолу” зэрэг сургуулиуд тогтмол явагдан уламжлал болсон байна.

Зээл, тусламж:

Хамтын ажиллагааны хүрээнд батлан хамгаалах салбарын зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах чиглэлээр зээл тусламжийн нэр төрөл, үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна.

Олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлт, дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчинд шинэ сорилтууд бий болсонтой холбогдуулан улс орнууд аюулгүй байдлын үзэл баримтлал, төрийн бодлогодоо батлан хамгаалах төсөв, зардлаа нэмэгдүүлэх болон зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогодоо ихээхэн анхаарч байна.

2021 онд ОХУ, АНУ, ХБНГУ, БНСУ, Япон зэрэг улсаас нийтдээ 90 орчим тэрбум төгрөгийн өртөг бүхий зэвсэг хэрэглэл, цэргийн болон тусгай зориулалттай техник, тоног төхөөрөмж хүлээн авснаар Монгол Улсын батлан хамгаалах салбарт чухал хувь нэмэр оруулсан байна.

2022 онд ОХУ, АНУ, ХБНГУ, БНЭУ, БНАУ-аас 200 гаруй тэрбум төгрөгийн өртөг бүхий зэвсэг, цэргийн болон тусгай зориулалттай инженерийн машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл хүлээн авсан нь өмнөх жилийн үзүүлэлтээс даруй хоёр дахин өссөн байна.

2023 онд ОХУ, АНУ, БНСУ, БНЭУ-аас 20 гаруй тэрбум төгрөгийн өртөг бүхий хэрэглэл, инженерийн машин, механизм хүлээн авсан нь өмнөх онуудтай харьцуулахад хэд дахин буурсан бөгөөд 2024 оны зээл тусламжийн дун 46 тэрбум төгрөгийн үзүүлэлттэй байна.

Монгол Улс цэргийн шинэчлэлийн гол зорилгоо “мэргэжлийн цэрэгт суурилсан, цэргийн мэргэжлийн өндөр бэлтгэлтэй бие бүрэлдэхүүн, орчин үеийн зэвсэглэл, цэргийн техник бүхий чадварлаг Зэвсэгт хүчнийг байгуулна” хэмээн тодорхойлсон байдаг. Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах арга хэмжээг гадаадын зээл, тусламжийн хэлбэрээр хамтын ажиллагаатай орнуудын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээ, санамж бичгийг үндэслэн хэрэгжүүлж байна.

Батлан хамгаалах салбарт 2021-2024 онуудад зээл, буцалтгүй тусламжаар хүлээн авсан зэвсэг, техник, тоног төхөөрөмж:

Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбарын цэргийн зэвсэглэл, техникийг шинэчлэн сайжруулах, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ОХУ, АНУ, ХБНГУ, БНЭУ, БНАУ, БНСУ, Япон улсуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу 2021-2024 онуудад буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн нийт 385,7 тэрбум төгрөгийн үнэ бүхий зэвсэглэл, тусгай зориулалттай техник, автомашин, эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

Олон улсын энхийг сахиулах ажиллагаа

Монгол Улсын Засгийн газар 1999 оны 7 дугаар сарын 28-ны өдөр “Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай” 115 дугаар тогтоол гаргасан нь монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцох явдлыг бодит хэрэг болгох суурь тавигдсан гэж үздэг.

Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тухайн үеийн Гадаад хэргийн яам, БХЯ, ЗХЖШ хамтран идэвхтэй ажиллаж, Зэвсэгт хүчнээс энэ чиглэлээр бэлтгэгдсэн зарим цэргийн алба хаагчдыг НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах боломжтой гэж үзсэний үндсэн дээр НҮБ-д хүсэлтээ гаргаж, тус байгууллагын Энхийг сахиулах хүчнийг бүрдүүлэх шийдэлд хүрч байжээ.

1999 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Нью-Йорк хотноо “НҮБ-ын Энхийг сахиулах байнгын хүчний тогтолцоонд хувь нэмэр оруулах талаар Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын хооронд харилцан ойлголцсон санамж бичиг”-т гарын үсэг зурсан нь Монгол Улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүний хувьд НҮБ-ын дүрмийн дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжтой болсны зэрэгцээ Энхийг дэмжих ажиллагаанд оролцох Олон улсын эрх зүйн үндэс нээгдсэн юм.

Харин Монгол Улсын дотоод эрх зүй нь мөн оны 9 дүгээр сард тухайн үеийн Засгийн газрын тогтоол, 2002 онд “Цэрэг, цагдаагийн алба хаагчийг НҮБ-ын Энхийг сахиулах болон Олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай” Монгол Улсын хууль батлагдсанаар цэргийн алба хаагчдаа хилийн чанадад үүрэг гүйцэтгүүлэх боломж бүрдсэн юм.

Улмаар монголын анхны хоёр энхийг сахиулагч Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад НҮБ-ын цэргийн ажиглагчаар үүрэг гүйцэтгэснээр манай улсын Зэвсэгт хүчний Энхийг сахиулах ажиллагаанд оролцох үүд хаалга нээгдсэн.

Энэ цагаас хойш 23 жилийн хугацаанд энхийг дэмжих 16 ажиллагаанд оролцсон туршлагатай улс болсон байна. эдгээрээс 9 ажиллагаа хаагдаж, 8 ажиллагаанд цэргийн алба хаагчдыг илгээн үүрэг гүйцэтгүүлж байна.

Энхийг дэмжих ажиллагаанд 2002 оноос хойш 23 жилийн хугацаанд Монгол Улсын нийт 23000 /давхардсан тоогоор/ орчим цэргийн алба хаагч үүргээ амжилттай гүйцэтгээд байна.

Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдын оролцсон болон оролцож буй энхийг дэмжих ажиллагааг дараах 3 хэсэгт хуваан үзэж судаллаа. Үүнд:

- Олон улсын эвслийн цэргийн ажиллагаа;
- НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа;
- НАТО-гийн цэргийн ажиллагаа;

Олон улсын эвслийн цэргийн ажиллагаа

Ирак Улс дахь “Иракын эрх чөлөө” олон улсын цэргийн ажиллагаа

Монгол Улсын Зэвсэгт хүчний анхны цэргийн баг нь Олон үндэстний төвийн өмнөд дивизийн бүрэлдэхүүнд 2003 оны 8 дугаар сараас 2006 оны 01 дүгээр сар хүртэл Аль-Хиллах хотод “Чарли” баазад аюулгүй байдлыг хангах үүргийг; 2006 оны 01 дүгээр сараас 2008 оны 10 дугаар сар хүртэл Эвслийн хүчний “Эко” баазыг аюулгүй байдлыг хангах үүргийг тус тус гүйцэтгэсэн. Дээрх хугацаанд нийт 10 ээлжийн цэргийн багт 1194 цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэжээ.

Артиллерийн сургалтын хөдөлгөөнт баг

Афганистаны эрх чөлөөг дэмжих акт/2002/, Олон нийтийн хууль/107-327/, “Афганистаны Үндэсний армийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд АНУ-ын Батлан хамгаалах яам, Монгол Улсын Батлан хамгаалах яаманд Афганистаны Үндэсний армийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг 2003 оны 7 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсний дагуу Афганистаны Үндэсний армийн артиллерийн мэргэжлийн бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, эвдрэлтэй байгаа их буунуудад засвар үйлчилгээ хийх үүрэг бүхий сургалтын хөдөлгөөнт багийг томилон ажиллуулах талаар АНУ-ын Батлан хамгаалах яам, Монгол Улсын Батлан хамгаалах яам харилцан тохирч “Афганистаны Үндэсний армид туслах техникийн сургалт, засвар үйлчилгээний багийн тээвэрлэлт, хангалтын тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, АНУ-ын Батлан хамгаалах яам хоорондын техникийн тохиролцоо”-г 2003 онд байгуулсан. Уг тохиролцооны дагуу Монгол Улсын Зэвсэгт хүчнээс артиллерийн сургалтын хөдөлгөөнт баг 2003 оны 10 дугаар сараас эхлэн Афганистаны Үндэсний армийн артиллерийн цэргийн алба хаагчдыг сургаж бэлтгэх, артиллерийн зэвсэглэлүүдэд засвар үйлчилгээ хийх үүрэг гүйцэтгэж эхэлснээс хойш сургалтын хөдөлгөөнт багийн нийт 13 ээлжид 265 цэргийн алба хаагч томилогдог үүргээ амжилттай биелүүлж, Афганистаны Үндэсний арми, АНУ-ын цэргийн командлалаас өндрөөр үнэлэгдэж байсан.

Цэргийн хамгаалалтын рот

АНУ-ын Засгийн газраас 2009 оны 6 дугаар сард Афганистанд зохион байгуулагдсан АНУ-ын тэргүүлсэн эвслийн цэргийн хүчний “Тогтвортой эрх чөлөө” ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс цэргийн хүч нийлүүлэх хүсэлт ирүүлсний дагуу Монгол Улсын Засгийн газар(2009 оны 226 дугаар тогтоолоор) мото-буудлагын рот оролцуулах шийдвэр гаргасан юм. Цэргийн багийн нэгдүгээр ээлж 2009 оны 11 дүгээр сард Афганистан Улсын Кабул хотод байрлах эвслийн цэргийн хүчний “Эггэрс” цэргийн баазын харуул, хамгаалалтын үүргийг гүйцэтгэж эхэлснээс хойш цэргийн багийн нийт 1252 цэргийн алба хаагч үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн.

НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа

Сьерра-Леон Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах “UNMIL” ажиллагаа

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2005 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 1626 дугаар тогтоолд Либери Улсад явагдсан НҮБ-ын энхийг сахиулах “UNMIL” ажиллагааны дэд бүс болох Сьерра Леон Улс дахь Олон улсын Тусгай шүүхийн

хамгаалалтын үүргийг гүйцэтгүүлэхээр заасны дагуу НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас дээрх үүргийг хэрэгжүүлэх мото-буудлагын рот хүртэлх хүчийг оролцуулах саналыг Монгол Улсын Засгийн газарт 2005 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хандаг уламжилсныг хүлээн авч, улмаар Засгийн газар 2005 оны 225 дугаар тогтоолоор тус ажиллагаанд мото-буудлагын рот илгээх шийдвэр гаргасан. Тус ажиллагаанд Монгол Улсын цэргийн баг 2006 оны 01 дүгээр сараас 2011 оны 3 дугаар сар хүртэл оролцох хугацаанд цэргийн багийн нийт 10 ээлжид 2300 цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Чад, ТАБНУ дахь НҮБ-ын энхийг сахиулах “MINURCAT” ажиллагаа

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2009 оны 1861 дүгээр тогтоолын дагуу байгуулагдсан Чад Улс болон Төв Африкийн Бүгд Найрамдах Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах “MINURCAT” ажиллагаанд цэргийн баг (батальон) оролцуулах саналыг Монгол улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газраар дамжуулан Монгол Улсын Засгийн газарт (2008.07.08) НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас ирүүлсний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 253 дугаар тогтоолоор мото-буудлагын (батальон) илгээх шийдвэр гаргасан. Монгол Улсын Зэвсэгт хүчнээс тус ажиллагаанд тус ажиллагаанд мотобуудлагын батальоныг дэлгэн үүрэг гүйцэтгүүлэхээр төлөвлөн тэргүүний ээлжийн салбаруудыг ажиллагааны газар оронд илгээсэн хэдий ч харуул хамгаалалт, эргүүл цувааны хамгаалалт, иргэн-цэргийн харилцаа, түргэн байрлах хүчний болон чухал хүний хамгаалалтын үүргүүдийг гүйцэтгэсэн.

Судан Улсын Дарфур муж дахь НҮБ болон Африкийн холбооны хамтарсан энхийг сахиулах “UNAMID” ажиллагаа

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн хээрийн хоёрдугаар шатны эмнэлгийн цэргийн баг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 62 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2010 оны 142 дугаар тушаалаар 2010 оны 12 дугаар сарын 19-нөөс эхлэн Судан Улсын Дарфур муж дахь НҮБ, Африкийн холбооны хамтарсан энхийг сахиулах “UNAMID” ажиллагаанд оролцож эхэлсэн.

Монгол Улсын хоёрдугаар шатны эмнэлэг нь анхан болон хоёр дахь шатны тусламж, яаралтай сэхээн амьдруулах болон тогтворжуулах аргаа хэмжээ, мэс засал хийх, шүдний эрүүл мэндийн суурь үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй бөгөөд тус ажиллагааны хойд болон баруун секторт НҮБ-ын ажилтан, цэрэг хандивлагч орны цэргийн болон цагдаагийн алба хаагч, орон нутгийн иргэдэд эмнэлгийн үзлэг, үйлчилгээг үзүүлсэн.

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаа

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаанд мото-буудлагын батальоныг үүрэг гүйцэтгүүлэхээр НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 267 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2011 оны 320 дугаар тушаалыг үндэслэн, мото-буудлагын батальоныг ажиллагааны газар оронд илгээх бэлтгэлийг ханган, цэргийн багийн үндсэн тоног төхөөрөмжийг 2012 оны 01 дүгээр сараас эхлэн

тээвэрлэн ажиллагааны газар оронд хүргэж, цэргийн багийн тэргүүний бүлгийг 2012 оны 3-5 дугаар саруудад, үндсэн бүрэлдэхүүнийг 8 дугаар сард ажиллагааны газар оронд илгээсэн нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсаас нойтон түрээсээр бүрэн дэлгэгдэн үүрэг гүйцэтгэсэн анхны мото-буудлагын батальон байсан. Тус мото-буудлагын батальон нь ажиллагааны газар оронд хүчний болон секторын штаб, мужийн удирдлага, НҮБ, олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, ажиллагааны мандат, хүч хэрэглэх дүрмийн дагуу цагийн байдлын хүнд нөхцөлд энгийн иргэдийг хамгаалах, агаарын эргүүл, хол ойрын автомашинтай эргүүл, явган эргүүл, нисэх зурвасын хамгаалалт, агаараас хүнс буулгах ажиллагааны аюулгүй байдал, хамгаалалт, цувааны хамгаалалт, тусгай ажиллагаа болон инженер, бүтээн байгуулалтын ажлыг маш амжилттай гүйцэтгэж тус ажиллагааны Хүчний болон Секторын удирдлагад өндрөөр үнэлэгдсээр байна.

2012 оноос хойших хугацаанд тус ажиллагаанд мото-буудлагын батальоны нийт 14 ээлж үүргээ амжилттай гүйцэтгэсэн бөгөөд 2025 оны 9 дүгээр сараас мото-буудлагын батальоны 15 дугаар ээлж үүрэг гүйцэтгэж эхлээд байна.

НҮБ-ын цэргийн ажиглагч, холбогч, штабын офицерууд

Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн багуудаас гадна цэргийн ажиглагч, холбогч, зөвлөх офицер, штабын офицер, ахлагч гэсэн статустайгаар тус тус оролцуулдаг.

Манай улсын Зэвсэгт хүчнээс анх 2002 онд цэргийн 2 ажиглагч офицерыг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулж эхэлснээс хойш нэг удаад үүрэг гүйцэтгэх цэргийн ажиглагч, холбогч, штабын офицер, ахлагч нарын тоо өссөөр өнөөгийн байдлаар НҮБ-ын UNAMA, MONUSCO, MINURSO, UNAMID, UNISFA, UNMISS ажиллагаанд үүрэг тус тус үүрэг гүйцэтгэж байна. Үүнд:

- Афганистан Улсад явагдсан ажиллагаанд цэргийн зөвлөхөөр 1 офицер цэргийн ажиглагчаар;
- БНАКУ-д явагдаж буй НҮБ-ын ажиллагаанд 2 офицер цэргийн ажиглагчаар;
- Баруун Сахарт явагдаж буй НҮБ-ын ажиллагаанд 4 офицер цэргийн ажиглагчаар;
- Судан Улсын Дарфур мужид явагдаж буй НҮБ/АХ-ын хамтарсан ажиллагаанд 2 офицер цэргийн ажиглагчаар;
- Абией мужид явагдаж буй НҮБ-ын ажиллагаанд 2 офицер цэргийн ажиглагчаар;
- БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын ажиллагаанд 2 офицер цэргийн ажиглагчаар;
- БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын UNMISS ажиллагаанд 14 офицер Хүчний болон Секторын штабын офицeroор;
- БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын UNMISS ажиллагаанд 2 ахлагч Хүчний болон Секторын штабын ахлагчаар тус тус үүрэг гүйцэтгэж байна.

Өнгөрсөн хугацаанд цэргийн алба хаагч НҮБ-ын 8 ажиллагаанд цэргийн ажиглагч, холбогч, штабын офицeroор үүргээ амжилттай гүйцэтгэсэн байна

НАТО-гийн цэргийн ажиллагаа

Косово улс дахь НАТО-гийн “KFOR” олон улсын цэргийн ажиллагаа

НАТО-гийн цэргийн Косовод явуулсан “KFOR” ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний салааны бүрэлдэхүүнтэй цэргийн баг 2005-2006 онуудад оролцож үүрэг гүйцэтгэсэн.

Афганистан улсад явагдсан НАТО-гийн цэргийн “Аюулгүй байдлыг хангах олон улсын хүчин”-ний ажиллагаа

Эргүүл хамгаалалтын рот

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс 2009 онд тус ажиллагаанд мото-буудлагын салааны хэмжээний цэргийн хүч нийлүүлэх хүсэлтийг ХБНГУ-аас ирүүлсний дагуу Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр мото-буудлагын салаа хүртэлх цэргийн багийг ХБНГУ-ын “Фейзабад” цэргийн бааз, нисэх онгоцны буудлын хамгаалалтыг хангах үүрэгтэйгээр ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран оролцож эхэлсэн.

Цэргийн хамгаалалтын салааг 2012 оноос хоёр улсын Батлан хамгаалах яамд хоорондын гэрээний дагуу цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэн эргүүл хамгаалалтын рот болгон өргөжүүлсэн бөгөөд 2009-2014 оны хооронд нийт 10 ээлжийн цэргийн баг үүргээ амжилттай гүйцэтгэсэн.

Баазын хамгаалалтын рот

Монгол Улсын Зэвсэгт хүчин ХБНГУ-ын зэвсэгт хүчинтэй хамтран Афганистан улсад явагдсан “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд мото-буудлагын ротын хэмжээний цэргийн хүчийг НАТО-гийн эвслийн цэргийн байрлал “Мармал бааз”-ын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зорилгоор үүрэг гүйцэтгүүлсэн. Тус ажиллагаа нь дээр дурдсан ажиллагааны үргэлжлэл бөгөөд 2014-2020 он хүртэл 10 ээлжийн цэргийн баг үүргээ амжилттай гүйцэтгэсэн байна.

Нисдэг тэрэгний техникийн засвар үйлчилгээ, сургалтын баг

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу Афганистанд НАТО-ийн тэргүүлсэн “Аюулгүй байдлыг хангах олон улсын хүчин”-ний бүрэлдэхүүнд Нисдэг тэрэгний техникийн засвар үйлчилгээний сургалтын бүлэг нь 2010-2014 онд нийт 8 ээлж үүргээ амжилттай гүйцэтгэсэн.

Сургалтын бүлэг нь Афганистаны үндэсний армийн нисэхийн цэргийн алба хаагчдад “Ми-17” загварын нисдэг тэрэгний техник, тусгай тоноглолын дунд шатны мэргэжилтэн бэлтгэх 10 сургалт, дамжааг зохион байгуулж Афганистаны үндэсний армийг хөгжүүлэх, бие даах чадавхыг нэмэгдүүлэх зорилтыг хангахад дэмжлэг үзүүлэн нийт 170 гаруй нислэгийн механик, техникийн ажилтныг сургаж бэлтгэсэн.

Нисэх зурвасын хамгаалалтын салаа

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу Афганистанд НАТО-ийн тэргүүлсэн “Аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх олон улсын хүчин”-ний бүрэлдэхүүнд Бельгийн Вант Улстай хамтран Кабул хотын Олон улсын нисэх буудал /КАИА/-ын нисэх зурвасын хамгаалалтын үүргийг цэргийн хамгаалалтын салаа 2011 оны 5 сараас гүйцэтгэж эхэлсэн.


2013 оны 9 дүгээр сард “КАИА” баазад хамтран үүрэг гүйцэтгэж байсан Бельгийн цэрэг Афганистанаас гарсантай холбоотойгоор хамтран байгуулсан гэрээ дуусгавар болж, нисэх зурвасын хамгаалалтын салааны ар тал, техник, материал

хэрэгслийн хангалтын асуудлыг АНУ-тай байгуулсан гэрээнд нэмэлтээр тусгаснаар тус ажиллагаанд үргэлжлүүлэн оролцож, цэргийн багийн нийт 7 ээлж үүргээ амжилттай гүйцэтгэсэн.

Үндэсний ахлах төлөөлөгч, штабын офицерууд


Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Афганистан Улсад явагдсан цэргийн ажиллагаанд АНУ-тай хамтран оролцсонтой холбоотойгоор АНУ-ын Флорида мужийн Тампа хот дахь Төвийн командлалын штабт 2003 оноос хойш Монгол Улсыг төлөөлсөн холбогчийн багт төлөвлөлтийн офицерыг тус тус томилон үүрэг гүйцэтгүүлж байна.

2011 оноос “Аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх олон улсын хүчин”-ний ажиллагааны хойд бүсийн командлалд штабын офицеруудыг оролцуулж байна.



Энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний оролцоо

ЭМЭГТЭЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН ОРОЛЦОО



“Хааны Эрэлд” Энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургууль



Цаашид Монголын Зэвсэгт хүчний 23 жилийн энхийг сахиулах ажиллагааны туршлагадаа тулгуурлан цаашид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд хөнгөн маневрлаг, чадварлаг жижиг нэгжүүдийг оролцуулах; гадаадын улс орнуудад энхийг сахиулах ажиллагааны сургалт явуулах Сургалтын хөдөлгөөнт бүлгийг ажиллуулан Дэлхийн шилдэг энхийг сахиулагчдыг сургаж бэлтгэх хувь нэмрээ оруулах; эмэгтэй энхийг сахиулагчдыг оролцоог нэмэгдүүлж 15 хүртэл хувьд хүргэх зорилтуудыг тавин ажиллаж байна.

Монгол цэрэг НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд оролцох нь мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулахын зэрэгцээ Монгол Улсад улс төр, нийгэм, эдийн засгийн олон талын ач холбогдолтой байсаар байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин дэлхийн улс орнуудын энх тайван, аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт тууштай оролцон, Нэгдсэн Үндэстний байгууллагын Энхийг сахиулах ажиллагаанд цэрэг илгээж буй орнуудын дунд 2025 оны 05 дугаар сарын байдлаар нийт 892 цэргийн алба хаагч /үүнээс 117 эмэгтэй/-ийг 7 ажиллагаанд илгээн оролцуулж, 19 дүгээр байранд жагсаж байгаа нь Монгол Улсын энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн, бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, улс орноо батлан хамгаалах боломж, чадавхыг нэмэгдүүлэх зорилтоо ханган ажиллаж байна.

2.3 ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХЭД БАТЛАН ХАМГААЛАХ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагааны урт хугацааны үр дүн нь зөвхөн цэргийн мэдлэг боловсрол, ур чадвар нэмэгдсэнээр хязгаарлагдахгүй бөгөөд гадаадын түншүүдтэй хамтын ажиллагааг тогтвортой хадгалснаар харилцаа илүү бэхжих бөгөөд ингэснээр цэргийн итгэлцэл, харилцан ойлголцлыг нэмэгдэнэ.

Энэ нь улс орны аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдлыг улс төр, дипломатын аргаар хангахад чухал нөлөө үзүүлээд зогсохгүй цаашилбал Монгол Улсын хувьд улс орон бүртэй харилцаагаа шат ахиулан гүнзгийрүүлэхэд улс төрийн хувь нэмрээ оруулж буй ач холбогдолтой үйл ажиллагаа юм.

Тийм ч учраас Батлан хамгаалах гадаад харилцаа нь Монгол Улсын "гадаад аюулгүй байдлын баталгаа" болж, хоёр хөрш хийгээд бүс нутгийн хүчний тэнцвэрт байдлыг хадгалахад санаачилга гарган ажиллаж байна.

Батлан хамгаалах бодлогын хүрээнд улс төр-дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах явдлыг урьтал болгож, хөрш орнуудтай хамтын ажиллагаа, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, бүс нутгийн тогтвортой байдлыг дэмжихийг чухалчилдаг.

Батлан хамгаалах гадаад харилцаа нь үндэсний аюулгүй байдлыг хангахад тулд гадаад орчны зүгээс учирч болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх, хөрш болон түншлэгч орнуудтай хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, цар хүрээгээ өргөжүүлсээр байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангахад Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагаа дараах хэд хэдэн чиглэлээр нөлөө үзүүлж байна. Үүнд:

Бүс нутаг, олон улсын байгууллагын үйл ажиллагааны оролцоо

Манай улс бүс нутгийн болон олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох нь үндэсний аюулгүй байдлаа баталгаажуулах, олон талт хамтын ажиллагаагаар цэргийн итгэлцлийг бэхжүүлэх нэг чухал хүчин зүйл болдог.

Сүүлийн жилүүдэд батлан хамгаалах салбарын төлөөлөл НҮБ, түүний салбар байгууллагууд, мөн Зүүн Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны нийгэмлэг (АСЕАН), ШХАБ зэрэг бүс нутаг болон олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцож олон улсын индэрт дуу хоолойгоо хүргэж, улсынхаа гадаад нээлттэй бодлого хийгээд газар зүйн байршлын онцлогтой Зэвсэгт хүчний чадамж, энхийг дэмжих ажиллагааны үүрэг гүйцэтгэх нөөц боломжийн талаар таниулах нь батлан хамгаалах хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд тэдгээр орнуудын дэмжлэгийг авахад нөлөөлөх гадаад том орон зай гэж харж болох юм.

Монгол Улс олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцож байгаа нь өөрөө НҮБ-ын Дүрэм, олон улсын эрх зүйн хэм хэмжээний зарчмуудыг дээдлэн хэрэгжүүлж, НҮБ төвтэй олон талт тогтолцоог хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж буйн томоохон илэрхийлэл бөгөөд цаад утгаараа тусгаар тогтнолоо олон улсаар баталгаажуулан дархлаажуулах улс төрийн арга хэрэгсэл бөгөөд энэ нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.2-ын "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа байна. Энэ хүрээнд олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс

орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.” гэсэн заалтыг хэрэгжилтийг хангах нөлөөллийн хүчин зүйлс болж байна.

Монгол улс бүс нутаг болон олон улсын байгууллагын үйл ажиллагаанд дахь идэвхтэй оролцоо нь цэргийн итгэлцлийг бэхжүүлэхээс гадна дэлхийн нийтийн үнэн зөв мэдээлэл дээр түшиглэн гадаад орчны аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж хамгаалах ач холбогдолтой.

Батлан хамгаалах хоёр талт хамтын ажиллагааны хөгжил

Монгол Улс нь геополитикийн хувьд хоёр том хөрштэй: Дэлхийд батлан хамгаалах жилийн төсөв, цэрэг армийн хүчин чадлаараа тэргүүлэгч ОХУ, БНХАУ-тай хил залгаа оршдог манай улс тэдгээр орнуудтай стратегийн түншлэлийн харилцаатай байснаараа үндэсний аюулгүй байдлыг бататгах, тогтвортой байдлыг хангахад хэд хэдэн чухал нөлөөг үзүүлж байна.

- Батлан хамгаалах салбарын хоёр талт харилцааг хөгжүүлэх нь улс төр, дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах стратегийн чухал хэрэгсэл юм.

- Хоёр талт хамтын ажиллагааг уламжлалт харилцаанд түшиглэж улс төр-дипломатын уян хатан, тэнцвэртэй бодлого явуулах нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.4. дэх хэсгийн “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ” гэсэн заалттай хууль эрх зүйн талаас нийцэж байна, гэж үзнэ.

- Монгол Улс хоёр хөрштэйгөө стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлснээр бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад хувь нэмрээ оруулж буй улс төрийн том нөлөөл юм.

- "Гуравдагч хөрш"-ийн орнуудтай хоёр талт хамтын ажиллагааг хөгжүүлснээр бүс нутаг болон олон улсад Монгол Улсын батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаа, Зэвсэгт хүчний нөхцөл байдал танигдахын хэрээр манай улстай цэргийн салбарт хамтрах орнуудын нэмэгдэх ба үр дүнд нь гадаад орчинд өөрийн орон зай, нэр хүндээ өсгөх нөлөөллийг бэхжүүлэх суурь тавигдсан. Энэ нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.5-ын "Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.”, 3.1.1.6-ын “Хөрш хоёр орон, АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Европын Холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.” гэх заалтуудтай тус тус нийцэж байгаа нь эрх зүйн хэрэгжилт хангагдаж буйн илрэл гэж үзэж болно.

Олон улсын болон аюулгүй байдал, гадаад харилцааны эрдэм шинжилгээний хурал

Гадаад, дотоодод зохион байгуулдаг олон улсын эрдэм шинжилгээний хурлууд Үндэсний аюулгүй байдлыг хангах, өөрийн улс орны бодлогыг сурталчлан таниулах ач холбогдолтой байдаг.

- Олон улсын эрдэм шинжилгээний хурлууд нь эрдэмтэн, судлаачид шинэ туршлага солилцох платформ болон хэвшиж байна. Энэ нь Монголын батлан хамгаалах бодлогыг олон улсын стандартад нийцүүлэх, шинжлэх ухаан, өндөр технологи, стратегийн чиглэлээр шинэ санаа авах боломж олгох үр нөлөөтэй.

- Хурлуудаас гарах зөвлөмж, судалгааны үр дүн нь батлан хамгаалах бодлого, стратегид шууд нөлөөлөх боломжтой.

- Эрдэм шинжилгээний хурлын үр дүн нь арга зүйн шинэ мэдлэг хуримтлуулах, ирээдүйд эрдэмтэн судлаачдад судалгаа шинжилгээний ажил хийх урам зориг төрүүлэх, батлан хамгаалах салбарт судалгааны чиглэлээр тууштай ажиллах боломж, орон зай, орчныг бүрдүүлж байна.

- Түүнчлэн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлүүдийг эргэлтэд оруулснаар үндэсний батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох, аюулгүй байдлын чиглэлээр мэдээлэл, санал боловсруулахад чухал нөлөө үзүүлдэг.

- Эдгээр арга хэмжээний үед Монгол-Орос, Монгол-Хятад, цаашилбал “гуравдагч хөрш”-ийн харилцаа өргөжиж, бүс нутгийн орнуудын харилцаанд зөөлөн уур амьсгал улам нэмэгдэх ба энэ нь тогтвортой байдалд эергээр нөлөөлж, хамтын ажиллагаа эрчимждэг.

- Олон улсын хурал, эрдэм шинжилгээний хуралд тогтмол оролцсоноор цэргийн дипломат харилцаа тэлэх чухал хөшүүрэг болохын зэрэгцээ олон улсын тавцанд Монгол Улсын Зэвсэгт хүчний байр суурь дээшлэхэд сайн талтай.

- Улс орны үндэсний хэмжээний шийдвэрийг нарийн судалгаан дээр үндэслэж баталдаг тул дээрх арга хэмжээнүүдэд батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлийн судалгааны байгууллагуудын оролцоо маш чухал.

Батлан хамгаалахын сайд нар аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаарх олон улсын хурал симпозиумд оролцсоноор

Батлан хамгаалахын сайд нар олон улсын хурал, симпозиумд оролцсоноор улс орнуудын аюулгүй байдлын салбар хүрээний хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, бүс нутаг болон дэлхий нийтийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулдаг.

- Дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын сорилтуудыг хамтран шийдвэрлэх, технологийн шинэчлэл, өнөө цагт өсөн нэмэгдэж буй кибер аюул заналтай тэмцэхэд Монголын батлан хамгаалах салбарын оролцоо сайжирч байна.

- Монгол Улсын Батлан хамгаалахын сайд нар олон улсын аюулгүй байдлын олон форум, бага хурал, симпозиумд бүс нутгийн хамтын ажиллагаа, цэргийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд томоохон үүрэгтэй оролцдог бөгөөд энэ нь Үндэсний аюулгүй байдлын баталгааг хангах болон салбарын бодлогын шийдвэр

гаргах түвшинд нөлөөлөх ач холбогдолтой. Тухайлбал;

- “Сөүлийн Батлан хамгаалахын яриа хэлэлцээ” олон улсын аюулгүй байдлын форум

- Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын Батлан хамгаалахын сайд нарын “Шангри Ла-гийн яриа хэлэлцээ” олон улсын аюулгүй байдлын форум.

- БНХАУ-д зохиогддог Батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудлаарх “Шяншань”-ийн олон улсын форум.

Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний дээд удирдлагын түвшинд Зүүн хойд Азийн бүс нутаг болон Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлыг нээлттэй хэлэлцдэг хамгийн өргөн цар хүрээтэй олон улсын аюулгүй байдлын эдгээр форумд Монгол Улсын Батлан хамгаалахын сайд оролцож, бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангахад өөрийн улсын байр суурийг илэрхийлсэн дуу хоолойгоо хүргэснээр манай улсын хувьд батлан хамгаалах гадаад харилцаа өргөжихөөс гадна гадаадын орнуудын цэргийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжиж байгаа өөрийн улсад тохирох шинэ санааг шинжлэх ухааны туршилт судалгаан дээр суурилан нэвтрүүлэх боломжтой нөлөөллийн арга хэмжээ гэж үзнэ.

Иймээс энэ нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.8 дах хэсгийн “Ази, Номхон далайн бүс нутаг Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгоход чиглэсэн бүс нутгийн орнуудын бодлого, үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж оролцоно.” гэх заалттай бүрэн нийцэж байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангахад батлан хамгаалах чиглэлээр байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийн нөлөө

Монгол Улс газар зүйн байршил, хөрш орнуудтай харилцах харилцаа, эдийн засаг, нийгмийн байдал зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор чиглэл тус бүрээр батлан хамгаалах хамтын ажиллагаатай улс орнуудтай гэрээ, хэлэлцээр байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

- ОХУ, БНХАУ, АНУ, НАТО, Европын холбоо, Зүүн хойд Ази, Зүүн өмнөд Азийн бүс нутгийн орнуудтай хоёр болон олон талын батлан хамгаалах, аюулгүй байдлын чиглэлээр гэрээ, хэлэлцээр байгуулснаар улс төр, аюулгүй байдал, цэргийн чиглэлд хамтын ажиллагаагаа тогтвортой хөгжих үндэс болох төдийгүй улмаар Монголын тусгаар тогтнолыг баталгаажуулахад чухал нөлөө үзүүлдэг. Үүнд;

- Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахад улс төрийн өндөр ач холбогдолтой.

- Бүс нутаг болон олон улсад цэргийн итгэлцлийг бэхжүүлээд зогсохгүй болзошгүй цэргийн аюул занал, аливаа эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэхэд эрх зүйн талаас нөлөөлөх хамгаалалт болдог.

- Зэвсэгт хүчний чадавхыг сайжруулах, зэвсэг техникийн шинэчлэлийг урагшлуулахад эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд нөлөөлдөг.

- Батлан хамгаалах чиглэлээр байгуулсан хэлэлцээрүүд нь бүс нутагт дахь аливаа маргаантай асуудал болон зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхэд эрх зүйн

баримт бичигт суурилах нь Үндэсний аюулгүй байдлыг улс-төр, дипломатын аргаар хангаж буй хэрэгсэл үзэж болно.

Цэргийн хамтарсан хээрийн сургууль, дадлагад оролцсоноор

- Манай улсын энхийг эрхэмлэсэн гадаад бодлогод олон улсын цэргийн хамтарсан сургуулиуд томоохон байр суурийг эзэлдэг бөгөөд найрсаг харилцаа, дипломат аргаар энх тайвныг сахин хамгаалах дуу хоолойгоо дэлхий дахинд хүргэх боломжтойн зэрэгцээ бусад орны цэргийн алба хаагчидтай мэдлэг, туршлага солилцож, байлдааны шинэ тактикт суралцсанаар сургалт бэлтгэлийн чанарт ахиц гарах, цэргийн мэргэжлийн ур чадвар нэмэгдэх, байлдааны үүрэг гүйцэтгэх бэлэн байдлын түвшин дээшлэх зэрэг өндөр ач холбогдолтой арга хэмжээ.

- Цэргийн хамтарсан хээрийн сургуулиуд нь цэргийн харилцан итгэлцлийг бэхжүүлж, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалахад дэмжлэгийн чухал нөлөө үзүүлдэг.

- Батлан хамгаалах хамтын ажиллагааг өргөжүүлэх, стратегийн түншлэлийг гүнзгийрүүлэхэд чухал нөлөөтэй.

- Цэргийн хамтарсан хээрийн сургуулиуд нь бүс нутгийн тогтвортой байдалд сөргөөр болзошгүй аливаа үйл ажиллагаатай тэмцэх, хариу арга хэмжээ авахад хамтран ажиллах байлдааны бэлэн байдлын шалгуур болдог.

Гадаадын цэргийн их дээд сургууль, дамжаанд цэргийн алба хаагчдаа сургаснаар

Гадаадын цэргийн их, дээд сургууль, академи, дамжаанд офицер, ахлагч нараа сургаснаар Үндэсний аюулгүй байдалд олон эерэг нөлөө үзүүлж байна.

- Цэргийн алба хаагчид гадаадын цэргийн сургууль, дамжаанд суралцах явцад хэлний мэдлэгээс гадна, тухайн орны соёл, зан заншил, батлан хамгаалах тогтолцооны онцлог зэргээс давхар суралцаж байгаа нь хоёр талын хамтын ажиллагааны уур амьсгалыг зөөлрүүлэхэд эергээр нөлөөлдөг.

- Цэргийн алба хаагчдын гадаад хэлний ур чадвар дээшлэхийн хэрээр тухайн хэл дээрх цэргийн хэргийн мэдлэгт ахиц гарсан сайн.

- Орчин үеийн цэргийн стратеги, тактикийн мэдлэг, өндөр технологи, инновацын талаарх шинэ мэдлэгт суралцахад дөхөмтэй болсон.

- Сүүлийн жилүүдэд манай Зэвсэгт хүчний алба хаагчид ОХУ, БНХАУ, мөн АНУ зэрэг “гуравдагч хөршийн” орнуудтай явуулдаг хоёр талын болон олон улсын цэргийн хамтарсан хээрийн сургуульд оролцох оролцоо өссөний зэрэгцээ сургуулийн үеийн ажиллагааны шийдвэр гаргалт, үүрэг гүйцэтгэлтийн шуурхай байдал нь тэдний гадаад хэлний өндөр мэдлэг олон улсын шалгуурт нийцэж буйн маш том илэрхийлэл болж байна.

Цэрэг-техникийн хамтын ажиллагааны нөлөө

Гадаадын улсуудтай цэрэг-техникийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх нь Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг орчин үеийн шаардлагад

нийцүүлэн сэргээн сайжруулах, засварлах, шаардлагатай сэлбэг хэрэгсэл нийлүүлэх чиглэлээр ашигтай, оновчтой, хямд хувилбарыг сонгож хэрэгжүүлэх, Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагааг ижил төстэй загвар стандартын зэвсэг, техник үйлдвэрлэдэг улсуудтай өргөжүүлэн хөгжүүлэх, түүнчлэн цэрэг-техникийн хамтын ажиллагаатай түншүүдийн тоог нэмэгдүүлснээр салбарын алба хаагчдын үүрэг гүйцэтгэх мэргэжлийн ур чадвар дээшлэхэд бодит хувь нэмэр оруулж байна.

Мөн гадаадын улсуудтай цэрэг-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг ханган бэхжүүлэхэд олон талын нөлөөллийн ач холбогдолтой. Энэ нь дараах чиглэлүүдэд хэрэгжиж байна. Үүнд:

- ОХУ, БНХАУ, АНУ болон бусад улс орнуудтай байгуулсан цэрэг-техникийн хэлэлцээрүүдийн үр дүнд цэргийн алба хаагчид зээл, буцалтгүй тусламжаар нийлүүлэгдсэн орчин үеийн шинэ зэвсэг техник, төхөөрөмжтэй танилцаж, тэдгээрийг эзэмшсэнээр байлдааны бэлэн байдал дээшлэх боломж хангагдан, үүрэг гүйцэтгэх чадвар сайжирсан. Тухайлбал:

- Агаарын цэргийн харьяа анги салбаруудад аэродром, газрын үйлчилгээний техник, төхөөрөмжийн бэлэн байдал хангагдсанаар нисгэгч нар цаг агаарын ямар ч нөхцөлд үүрэг гүйцэтгэх аюулгүй орчин бүрдсэн.

- Нисэх онгоцны буудал, нисдэг тэрэг, онгоц, автомашины багтаамж, байлдааны техникүүдийг шинэчлэх, зориулалтын бэхлэлт байгуулах зэрэг нь Зэвсэгт хүчний үйл ажиллагааны бэлэн байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

- Гадаад хамтын ажиллагаатай орнуудаас монголын Зэвсэгт хүчний НҮБ-ын “UNMISS” энхийг дэмжих ажиллагаанд БНӨСҮ-д үүрэг гүйцэтгэх цэргийн багт үзүүлж байсан буцалтгүй тусламж (барилга-инженерийн машин механизм, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл(хантааз, дуулга г.м), эмнэлгийн анхны тусламжийн багц) нь энхийг сахиулагчдын үүрэг гүйцэтгэх чадвар дээшилж, аюулгүй байдал хангагдахад сайнаар нөлөөлж байна.

Цэргийн өндөр албан тушаалтнуудын харилцан айлчлал

Монгол Улсын цэргийн дээд албан тушаалтнуудын харилцан айлчлал нь үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломат, бүр стратегийн түвшинд бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

- Цэргийн өндөр албан тушаалтнуудын айлчлал нь гадаад харилцааг өргөжүүлэх, хөрш орнууд болон гуравдагч хөрштэй итгэлцлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааны хамрах хүрээг өргөжүүлэх боломжийг олгохоос гадна Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах үндсэн суурь болж байна.

- Цэргийн өндөр албан тушаалтнуудын айлчлалууд нь зөвхөн талуудын харилцааг хөгжүүлж, гэрээ хэлэлцээр байгуулах асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд стратегийн итгэлцлийг бэхжүүлж, бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизмыг сайжруулахад эергээр нөлөөлж байна.

- Цэргийн өндөр албан тушаалтнуудын харилцан айлчлал нь дипломат харилцааны нэг хэсэг болохын хувьд Гадаад бодлогын үзэл баримтлалд нийцүүлж зохион байгуулагддаг тул энэ нь Үндэсний аюулгүй байдлыг хангахад улс төрийн том нөлөө үзүүлснээр Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын

3.1.1.2-ын “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа байна. Энэ хүрээнд олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагуудтай идэвхтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.” гэсэн заалттай нийцэж байн.

- Батлан хамгаалах хамтын ажиллагаатай ОХУ, БНХАУ, АНУ зэрэг дэлхийд цэрэг армийн хүчин чадлаараа тэргүүлэгч улс орнуудтай хийж буй цэргийн өндөр албан тушаалтнуудын харилцан айлчлал нь батлан хамгаалах гадаад харилцааг илүү гүнзгийрүүлэх, олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэх боломжийг олгож байна. Энэ нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.4-ийн “ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ.”; 3.1.1.5-ын “”Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.” гэсэн заалтуудын хэрэгжилтийг хангаж байна.

Гадаад орнуудад болон манай улсад суугаа батлан хамгаалахын атташегийн хамтын ажиллагааны Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд үзүүлсэн нөлөө

Гадаад оронд болон Монгол Улсад суугаа цэргийн атташегийн хамтын ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг.

- Атташегийн алба нь хоёр улсын батлан хамгаалах харилцааны хөгжлийг холбосон “гүүр” болсоор байна.

Манай улсын болон гадаад улсуудад суугаа батлан хамгаалах атташегийн оролцоотойгоор офицер, ахлагч нар бүс нутаг, олон улсын хэмжээний сургалт, дадлагад хамрагдаж, туршлага хуримтлуулж байна.

Энэ нь Зэвсэгт хүчний чадавхыг сайжруулах, орчин үеийн цэргийн стратеги, тактикийн мэдлэгээ нэмэгдүүлэхэд дам үр өгөөжөө харуулсаар байна.

- Атташегийн зуучлалаар зохион байгуулагддаг уулзалт, гэрээ хэлэлцээ, төсөл хөтөлбөрүүд урт хугацаанд хэрэгжих боломжтой бөгөөд хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлэх бат бөх суурь болдог ба үүгээрээ Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд улс-төр, дипломатын аргаар нөлөөллийн оролцоотой байдаг. Энэ нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.1.8 дах хэсгийн “Ази, Номхон далайн бүс нутаг Зүүн Ази, түүний дотор Зүүн хойд Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгоход чиглэсэн бүс нутгийн орнуудын бодлого, үйл ажиллагааг идэвхтэй дэмжиж оролцоно.” гэсэн заалттай нийцэж байна.

Дашрамд дурдахад, батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаанд оруулсан үүрэг, оролцоо, хувь нэмрийг үнэлэх зорилгоор “Найрамдал” медалийг бий болгосон нь бусад улс орнуудын атташегийн үйл ажиллагааг урамшуулах, хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд ихээхэн үр нөлөөтэй бодлогын чанартай үйл ажиллагаа гэж үзэж байна.

Олон улсын энхийг сахиулах ажиллагаа

Монгол Улсын Зэвсэгт хүчин болон Төрийн цэргийн байгууллагуудын алба хаагчид дэлхийн халуун цэгүүдэд хариуцлагатай, нэр төртэй амжилттай гүйцэтгэж байгааг НҮБ, Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс өндрөөр үнэлсээр байна.

Иймд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангахад Монголын энхийг сахиулагчдын үзүүлсэн нөлөөлөл үлэмж их бөгөөд ил тод харагддаг. Тухайлбал:

- Энхийг сахиулагчдын цэргийн мэргэжлийн ур чадвар дээшилсний сацуу ажиллагааны газар орон дээр үүрэг гүйцэтгэх хугацаанд хуримтлуулсан мэдлэг туршлагаа өөрсдийн харьяа анги байгууллагадаа хэрэгжүүлж байна;

- Энхийг сахиулагчид Африк тивийн халуун дулаан уур амьсгалтай бүсчлэлийн +40-ээс дээш хэмийн халуун орчинд болон цагийн байдлын тааварлашгүй хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг тул тэдний мэргэжлийн ур чадвар нь дээшлэхээс гадна тэдний цаг агаарын ямар ч нөхцөлд дасан зохицох байдал, сэтгэл зүйн тэсвэр хатуужилд суралцаж чадсан. цэргийн алба хаагчдын байлдааны үүрэг гүйцэтгэх болон сөрөн тэсвэрлэх энэхүү чадвар нь бүс нутаг хийгээд манай улсад үүсэж болзошгүй аливаа цагийн байдалд төрийн ба цэргийн дээд удирдлагын шийдвэр гаргалтад шуурхай, хугацаа хэмнэх давуу талтай болохыг илэрхийлж байна.

- НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагааны удирдах албан тушаал (хүчний командлагч, секторын командлагч, секторын штабын дарга, хүчний штабт хэлтсийн дарга) болон бусад томилгоот албан тушаалууд(хүчний штабын офицер, ажиглагч, холбогч, секторын ахлагч)-ад манай улсын цэргийн алба хаагчид сонгогдон албаа хариуцлагатай, нэр төртэй хашиж буй гүйцэтгэлийн чанарын өндөр үзүүлэлтээрээ бусад орны энхийг сахиулагчдад үлгэр дуурайлал болж байдаг нь Монголын энхийг сахиулагчид дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөний баталгаа гэж хэлж болно.

- Зөрчил, мөргөлдөөн, иргэний дайнтай улс оронд болон цагийн байдлын хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгээд ирсэн Монголын энхийг сахиулагчдын үндэсний болон эх оронч үзэл илүү нэмэгддэг тэдний сэтгэгдлээс тодорхой мэдрэгдсээр байдаг.

- Олон улсын энхийг сахиулах ажиллагаа дахь Монголын Зэвсэгт хүчний нэр хүнд улам өссөөр байгаа нь нэгт, дотооддоо иргэн-цэргийн харилцаа, нийгмийн сэтгэл зүйд эерэг мессеж түгээгээд зогсохгүй масс иргэдийн эх оронч үзлийг дархлаажуулахад давхар сайнаар нөлөөлнө; хоёрт, олон улсад энхийг сахиулах идэвхтэй ажиллагааны үр дүнд бусад улстай харилцах цэргийн итгэлцлийг бэхжүүлж, энэ нь батлан хамгаалах хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд бодитоор нөлөөлөх боломжтойг харуулж байна.

- Энхийг сахиулагчдын даян дэлхийн амар амгалангийн төлөө байгуулсан үйл хэрэг нь монголын өсвөр үе буюу “Genz”-ийн үеийг ирээдүйд эх оронч үзлээр төлөвшүүлэхэд том хувь нэмэр оруулж байгаа бөгөөд цаашлаад энэ нь батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаагаар дамжуулан Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд оруулж буй хувь нэмэр гэж үзэж байна.

- Энхийг сахиулах ажиллагаанд оролцсоноор олон улсын тавцанд манай улсын нэр хүнд өсөж, “зөөлөн хүч”-ний нөлөөг улам бэхжүүлсээр байна.

ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Батлан хамгаалах шинэчлэлийн хугацаанд манай улсад болон гадаад улсад зохион байгуулагдсан БХЯ-дын сайд нар болон цэргийн дээд албан тушаалтнуудын харилцан айлчлал, зөвлөлдөх уулзалт, олон улсын хурал, семинар зэрэг арга хэмжээнүүдийн тоо, цар хүрээ нэмэгдсэн нь Монгол Улсын Зэвсэгт хүчнийг гадаад оронд таниулах, гадаад улсын батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний хөгжил шинэчлэл, өндөр технологид суурилсан шинэ зэвсэглэл, техникийн талаар мэдээлэл солилцох, туршлага судлахад үр өгөөжөө өгсөөр байгааг харуулж байна.

Дэлхийд тэргүүлэгч их гүрэн хоёр хөрш ОХУ, БНХАУ-тай батлан хамгаалах салбарт харилцаагаа тасралтгүй хөгжүүлснээр тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал баталгаажихын зэрэгцээ цэргийн итгэлцэл, улс төрийн харилцан ойлголцол дээшилж ба үүний үр дүнд сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа цэргийн буцалтгүй тусламж нь Зэвсэгт хүчний шинэчлэлийг гүнзгийрүүлж улс орны бүтээн байгуулалтад чухал хувь нэмэр оруулж байна.

ОХУ-тай хөгжүүлж буй цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааны дүнд манай улсын батлан хамгаалах салбарт зэвсэг-техникийн шинэчлэл хийгдэж, цэргийн боловсон хүчнээ бэлтгэснээр хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадвар бүхий орчин цагийн Зэвсэгт хүчин болон өргөжиж байна.

Түүхэн хугацаанд завсардсан харилцаа дахин сэргэснээс хойш Монгол-Хятадын цэргийн хамтын ажиллагаа тасралтгүй хөгжиж байгаа нь хоёр улсын стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн ахиулахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаагаар дамжуулж түншлэгч орнуудаас зэвсэглэл техникийн тусламж дэмжлэг авах; сургалт, дадлага; шинэ технологи зэрэгт түшиглэсэн хамтын ажиллагаа нь Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлж байгаагаас гадна терроризм, кибер аюул, хил дамнасан гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн аюулд хамтын хариу арга хэмжээ авах боломжийг олгодог.

Гэхдээ уг харилцааг нэг тал руу чиглүүлснээр хоёр хөршийн хавсарсан шахалтад орох, эсвэл хэт муудах нь аль нэгийг сонгож, эргээд нэг гүрний шууд нөлөөнд орох эрсдэл дагуулж болзошгүй хувилбарыг тооцож түүнээс сэргийлэх “тоглолт”-ын арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна.

НҮБ-ын болон олон улсын энхийг дэмжих ажиллагаанд цэргээ оролцуулан, энх тайванч үүргээ биелүүлэх, энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургууль, арга хэмжээг зохион байгуулах, түүнд оролцох замаар Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд өсгөж, байр суурийг бэхжүүлэх, энхийг эрхэмлэсэн бодлого, үйл ажиллагааг сурталчлан таниулах нь улс орныхоо аюулгүй байдлыг хангах үр дүнтэй арга хэрэгсэл болохыг өнгөрсөн жилүүдийн туршлага харууллаа.

Монгол цэрэг НҮБ-ын болон Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх чадвараараа НҮБ-д өндрөөр үнэлэгдсээр ирсэн нь дэлхийн улс орнуудын Монгол Улстай харилцах хамтын ажиллагаа, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд оруулж буй томоохон нэмэр гэж үзэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

БАТЛАН ХАМГААЛАХ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙН ТАЛААРХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

3.1. ОЛОН УЛСЫН БОЛОН БҮС НУТГИЙН БАТЛАН ХАМГААЛАХ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВ

Өнөөгийн нөхцөлд холбоотон улсууд урьдын адил хатуу үзэл сурталд суурилсан бус, харин илүү уян хатан, олон талт, асуудал тус бүрд анхаарлаа хандуулах болсон.

Европт НАТО-гийн үндсэн зорилго нь Оросын 2014 онд Крымийг нэгтгэсэн үйлдлээс хойш, ялангуяа 2022 онд Украинд бүрэн хэмжээний дайн эхлүүлснээс хойш дахин сэргэж, хамтын батлан хамгаалах гол байгууллага хэвээр үлдсэн. Энэ үйл явдал НАТО-г нэгтгэж, төвийг сахигч Финланд (2023), Швед (2024) улсуудыг эгнээндээ нэгдэхэд хүргэсэн.

Ази тивд АНУ-ын хоёр талын болон гурван талт холбоотон улсууд байгаа ч улам олон талт хэлбэрт шилжиж байна. АНУ-Япон-Солонгосын гурван талт түншлэл сүүлийн жилүүдэд улам батжин, пуужингийн хамгаалалт, тагнуулын мэдээлэл солилцох, хамтарсан сургуулилтаар бэхжиж байна. Мөн QUAD (АНУ, Япон, Энэтхэг, Австрали) 2000-аад оны дунд үед бий болж, сүүлийн жилүүдэд идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж, далайн аюулгүй байдал, Хятадын нөлөөг тэнцвэржүүлэхэд төвлөрч байна. Түүнчлэн 2021 онд AUKUS (Австрали, Их Британи, АНУ) түншлэл байгуулагдаж, цөмийн хөдөлгүүртэй шумбагч онгоц, кибер, хиймэл оюун зэрэг өндөр технологи солилцоход чиглэсэн. Эдгээр холбоо нь АНУ болон түүний холбоотнуудын ашиг сонирхолд үйлчилдэг. Өнөөгийн чиг хандлага нь Ази, Номхон далайн бүс нутагт олон талт цэргийн блок байгуулах гэсэн улс орнуудын хүсэл эрмэлзэл бөгөөд үүнийг хоёр талт холбоотнууд, AUKUS цэргийн блок, QUAD зэрэг дөрвөн талт аюулгүй байдлын яриа хэлэлцээний сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлэх боломжтой юм.

Нөгөө талаас Хятад, Орос хоёрын харилцаа улам ойртож, АНУ-ын нөлөөнд сөргөөр нөлөөлөхийг эрмэлзэх болсон. Цэргийн хамтын ажиллагаа, хамтарсан сургуулилт, зэвсэг, техник, технологийн солилцоогоор харилцаагаа бататгасаар ирсэн.

Бүс нутгийн стратегийн орчин

Зүүн хойд Ази нь түүхэн газар нутгийн маргаан, их гүрнүүдийн ашиг сонирхол огтлолцсон, дэлхийн хамгийн эмзэг, стратегийн чухал бүс нутгийн нэг хэвээр байна. Энэ бүс нутгийн аюулгүй байдлын орчин нь АНУ, БНХАУ, ОХУ, Япон, хоёр Солонгосын харилцаа, өргөн хүрээгээр Энэтхэг-Номхон далайн нөхцөл байдлаар тодорхойлогддог. Батлан хамгаалах хамтын ажиллагааны чиг хандлага нь аль аль талаараа - гүнзгийрч буй холбоотнуудын уялдаа холбоо болон тогтолцооны хязгаарлалтаар илэрч байна. НАТО-той адил цогц аюулгүй байдлын байгууллага байхгүй ч сүүлийн жилүүдэд хоёр талын болон олон талт (minilateral) батлан хамгаалах түншлэлүүд олширч, ялангуяа БНАСАУ-ын цөмийн хөтөлбөр, БНХАУ-ын

цэргийн хүчирхэгжилт, АНУ-ын бүс нутаг дахь байр сууриа хадгалах стратегит хөтлөгдөж байна.

Зүүн Хойд Азийн бүс нутагт тулгарч буй аюул нь тухайн бүс нутгийн орнуудын батлан хамгаалах салбарт оруулах хөрөнгө оруулалтаа эрчимтэй нэмэгдүүлж, өндөр технологийн ашиглан зэвсэглэлийн чадавхыг өсгөх, хамтын ажиллагаатай улс орнуудтай цэргийн хамтарсан сургуулилалт идэвхтэй явуулах эхэлсэнтэй холбоотой юм.

Бүс нутгийн орнуудын зэвсэгт хүчин гайхалтай тоогоор нэмэгдэж байгааг тэмдэглэх нь зүйтэй: Хятадад 2,7 сая, Хойд Солонгос 852,500, БНСУ 540,100, Японд 247,100, Орос (Алс Дорнод) 110,000 цэргийн албан хаагчтай. (Монгол Улс 11,700 албан хаагчтай.) АНУ Номхон далайн хойд болон төв хэсэгт тэнгисийн цэргийн томоохон оролцоотой, мөн АНУ-аас гадна цэргийн баазууддаа хамгийн том цэргийн нэгдэл байдаг. Тухайлбал, Японд нийт 47 мянга гаруй алба хаагчтай Америкийн цэргийн баазууд, БНСУ-д 28,900 гаруй алба хаагчтай цэргийн бааз байрладаг.

АНУ-ын тэргүүлсэн холбоотны тогтолцоо

АНУ-БНСУ-ын батлан хамгаалах түншлэл өргөжин тэлж, цөмийн аюулаас сэргийлэх, хамтарсан цэргийн сургуулилт, Энэтхэг-Номхон далайн аюулгүй байдлын асуудлаарх бодлогын уялдаа холбоонд илүү ихээр төвлөрөх болсон. Сүүлийн жилүүдэд хийгдэж буй хамгийн чухал өөрчлөлт бол АНУ, Япон, БНСУ-ын гурван талт хамтын ажиллагааны хүчтэй өсөлт юм. 2023 оны Кэмп Дэвидийн дээд хэмжээний уулзалтаар³⁵ институцжүүлсэн энэ гурвалсан хамтын ажиллагаа одоо практик алхмуудаар бэхжиж, пуужингийн сэрэмжлүүлэх мэдээллийг бодит цаг хугацаанд солилцох, хамтарсан сургуулилт хийх, гарч буй аюулд нэгдсэн стратегийн хариу өгөх боломжийг бүрдүүлж байна.

АНУ ба БНСУ (Өмнөд Солонгос) хоорондын цэргийн харилцаа нь Зүүн Азийн хамгийн бат бөх, стратегийн хувьд ач холбогдолтой холбоодын нэг юм. Солонгосын дайны үед бүрэлдэн бий болсон энэхүү эвсэл нь АНУ-ын давамгайлсан аюулгүй байдлын зохицуулалтаас илүү тэнцвэртэй түншлэл болж хөгжсөн.

Солонгосын хойг нь Дэлхийн II дайнаас хойших хуваагдал болон 1950-1953 оны Солонгосын дайнтай холбоотойгоор олон улсын стратегийн өрсөлдөөний төв цэг байсаар ирсэн. 1953 онд байгуулсан Харилцан хамгаалах гэрээ³⁶ нь АНУ ба БНСУ-ын цэргийн эвслийн үндсийг тавьсан бөгөөд энэ нь 70 гаруй жилийн турш оршин тогтнож байна. Гэрээний дагуу АНУ нь Өмнөд Солонгосыг гадаадын түрэмгийллээс хамгаалахаа амлаж, хойг дээр байнгын цэргийн оролцоог хадгалсан.³⁷ АНУ-ын Солонгос дахь цэргийн хүчний командлал (USFK)-ыг байгуулснаар энэ амлалтыг баталгаажуулсан. Дайны үед АНУ-ын цэргийн тоо 326,000 хүрч байсан бол сүүлийн жилүүдэд ойролцоогоор 28,500 орчим болж тогтворжсон.³⁸ Уг гэрээ анх Умард Солонгосын түрэмгийллээс сэргийлэх зорилготой байсан бол өнөөдөр уг холбоо өргөжин тэлж, бүс нутгийн болон дэлхийн

³⁵ <https://www.csis.org/analysis/camp-david-us-japan-korea-trilateral-summit-exchange-among-csis-japan-and-korea-chairs>

³⁶ Mutual Defense Treaty Between the United States and the Republic of Korea, October 1, 1953

³⁷ Oberdorfer, D., & Carlin, R. (2014). The Two Koreas: A Contemporary History (3rd ed.). Basic Books.

³⁸ U.S. Department of War, 2022; <https://www.war.gov/>

аюулгүй байдлын хамтын ажиллагааг хамарч байна. Одоогоор АНУ-БНСУ-ын цэргийн харилцаа нь Умард Солонгосын өсөн нэмэгдэж буй цөмийн болон пуужингийн хүчин чадлыг саармагжуулахад чухал ач холбогдолтой хэвээр байхын зэрэгцээ Хятадын өсөлт, АНУ-ын гадаад бодлогын чиглэлийн өөрчлөлтөд дасан зохицож байна.

Хүйтэн дайны дараах 1991 онд Зөвлөлт Холбоот Улс нуран унаснаар АНУ-БНСУ-ын холбоо шинэ сорилттой тулгарсан. Шууд коммунист аюул багассан ч Умард Солонгосын цөмийн зэвсгийн хөтөлбөр гол сорилт болж хувирсан. 1994 оны Хэлэлцээрт хүрсэн баримт бичиг нь түр хугацаанд Умард Солонгосын цөмийн хөтөлбөрийг царцаасан ч сүүлдээ нуран унасан нь уг холбооны ач холбогдлыг улам бүр баталгаажуулсан.³⁹ АНУ ба БНСУ зөвхөн хойгийн хамгаалалтад чиглэсэн байр сууриас өргөн хүрээтэй аюулгүй байдлын хамтын ажиллагаа руу шилжиж, энхийг сахиулах ажиллагаа, терроризмын эсрэг хамтын ажиллагаа, Ирак, Афганистанд явагдсан эвслийн цэргийн ажиллагаанд хамтран оролцох болсон. Мөн БНСУ өөрийн батлан хамгаалах зардлаа өсгөж, хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг нэмэгдүүлж, АНУ-аас Өмнөд Солонгост дайны үеийн ажиллагааны удирдлагыг (OPCON) шилжүүлэх талаар хэлэлцээ явуулсан нь өнөөдөр ч үргэлжилж байна.⁴⁰

Өнөө үед АНУ-БНСУ-ын цэргийн харилцаа Умард Солонгосын цөмийн ба пуужингийн аюулыг саармагжуулах зорилтыг улам тодотгосон. 2017 онд ТНААД пуужингийн хамгаалах системийг Өмнөд Солонгост байршуулсан нь хамтын ажиллагааг гүнзгийрүүлсэн боловч Хятадын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан.⁴¹

Тус харилцаа Зүүн Азийн энх тайван, тогтвортой байдлын төвд хэвээр орших ба Умард Солонгосын цөмийн хүчин чадал өсөн нэмэгдэж, Хятад бүс нутгийн хүчирхэг гүрэн болж буй энэ үед уг харилцаа цаашид өөрчлөгдөж, зөвхөн цэргийн хүрээнд бус дипломат болон өргөн хамтын ажиллагааны шинэ хэлбэрүүдийг багтаасаар байх болно.

АНУ - Японы цэргийн харилцаа

АНУ төвтэй холбоотны нийгэмлэг бүс нутгийн аюулгүй байдлын тулгуур хэвээр байна. АНУ-Японы холбоо уламжлалт газар нутгийн хамгаалалтаас давж, сансар огторгуй, кибер орон зай, пуужингийн довтолгооноос хамгаалах болон БНХАУ, БНАСАУ-ыг сөрөх хамтарсан сэргийлэлт зэрэг шинэ чиглэлүүдийг хамарч байна.

АНУ-Японы аюулгүй байдлын холбоо нь Энэтхэг-Номхон далайн бүс нутагт хамгийн чухал бөгөөд урт хугацааны цэргийн түншлэлүүдийн нэг юм. Энэ хоёр орны түншлэл нь Дэлхийн II дайны дараагаас хойш Зүүн Азид Америкийн стратегийн тулгуур багана байсаар ирсэн. Дэлхийн II дайнд Япон ялагдсаны дараа АНУ 1945-1952 онд Японыг эзэлж, Үндсэн хууль болон институтын шинэчлэлүүдийг хийсэн. Үүнд дайныг үгүйсгэж, давших арми байгуулахыг хориглосныг Японы Үндсэн хуулийн 9-р зүйлд тусгасан байна.⁴² Гэвч Хүйтэн дайны хурцадмал байдал Вашингтоны бодлогыг өөрчилж, Японыг бүс нутгийн аюулгүй байдлын

³⁹ Cha, V. D., & Kang, D. C. (2003). *Nuclear North Korea: A Debate on Engagement Strategies*. Columbia University Press.

⁴⁰ Bando, D. (2020). *Time for South Korea to take over its own defense*. Cato Institute Policy Analysis.

⁴¹ Revere, E. J. R. (2017). *THAAD and the future of the U.S.-ROK alliance*. Brookings Institution.

⁴² Dower, J. W. (1999). *Embracing Defeat: Japan in the Wake of World War II*. W.W. Norton & Company.

тогтолцоондоо нэгтгэх шаардлага бий болсон. Хүйтэн дайны үед Япон нь АНУ-ын Зүүн Азийн цэргийн ажиллагааны чухал бааз болж, АНУ-ын цэргүүд Солонгосын дайн (1950-1953), Вьетнамын дайн болон ЗХУ, Хятадыг тогтоон барих бүс нутгийн стратегид оролцсон.⁴³

Анх 1951 онд АНУ-Японы хооронд байгуулсан Аюулгүй байдлын гэрээ болон 1960 онд шинэчлэгдсэн хувилбараар бий болсон уг түншлэл нь АНУ-Японд цэргийн бааз байрлуулах эрх олгож, Японы батлан хамгаалах үүрэгт тодорхой хязгаар тогтоосон.⁴⁴ Гэсэн ч цаг хугацааны явцад уг хоёр талт түншлэл нь Хүйтэн дайн, Хойд Солонгосын цөмийн хөтөлбөр, Хятадын цэргийн хүчирхэгжилт зэрэг бүс нутгийн сорилтуудын нөлөөгөөр гүнзгийрч, өнөөдөр зөвхөн бүс нутгийн бүс дэлхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны платформ болжээ.

Хүйтэн дайн дууссаны дараа шинэ сорилтууд гарч ирсэн. 1991 оны Персийн булангийн дайнд Япон нь байлдааны хүч илгээхээс татгалзаж, зөвхөн санхүүгийн тусламж үзүүлсэн нь "чекний дипломат" гэх шүүмжлэл дагуулсан.⁴⁵ Энэ нь Японы олон улсын аюулгүй байдлын үүргийн талаарх дотоодын маргааныг идэвхжүүлсэн.

1997 онд АНУ ба Япон хамтарсан батлан хамгаалах удирдамжийг шинэчлэн, үүнд зөвхөн Японы нутаг дэвсгэрийн хамгаалалтаар хязгаарлагдахгүйгээр бүс нутгийн хямралд хамтран ажиллах боломжийг нээсэн.⁴⁶ Мөн Япон энхийг сахиулах ажиллагаа, далайн дээрэмтэй тэмцэх болон АНУ-ын Афганистан, Ирак дахь ажиллагаанд логиستيкийн дэмжлэг үзүүлсэн.

Өнөөдрийн байдлаар Хойд Солонгосын цөмийн болон пуужингийн заналхийллийн эсрэг Япон улс АНУ-ын удирдсан сөрөг үйл ажиллагаанд нэгдэж, "SIAS-J" систем зэрэг пуужингийн хамгаалалтаа сайжруулж, АНУ-тай хамтран сөнөөгч пуужин бүтээх ажиллагааг эхлүүлсэн.⁴⁷ Хятадын цэргийн хүчний хүчирхэгжилтийн эсрэг ба бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар Зүүн болон Өмнөд Хятадын тэнгис дэх маргаан, ялангуяа Сенкаку/Дяоюү арлуудын асуудалд АНУ-Японы цэргийн түншлэл улам чухал болсон. АНУ-ын эдгээр арлуудын хамгаалалт нь гэрээний 5-р зүйлд хамаарна гэдгээ баталсан.⁴⁸ Түншлэлийн шинэчлэлийг 2015 оны Японы аюулгүй байдлын хуулинд зааснаар Японы өөрийгөө хамтран хамгаалах эрхийг өргөтгөж, АНУ болон холбоотнуудаа дэмжих боломжийг олгосон.⁴⁹ Японд байрлаж буй АНУ-ын цэргүүд, ялангуяа Окинава дахь бааз нь дотоодын маргаан дагуулсаар байна. Гэсэн ч энэ нь түншлэлийн бат бөх байдалд томоохон сөрөг нөлөө үзүүлээгүй.⁵⁰ АНУ ба Япон нь улам бүр өргөжин буй Энэтхэг-Номхон далайн чөлөөт, нээлттэй үзэл санаа (FOIP)-ны хүрээнд Австрали, Энэтхэг зэрэг түншүүдтэй хамтран "QUAD"-ыг ашиглаж, Хятадын нөлөөг тэнцвэржүүлж

⁴³ Green, M. J. (2001). *Japan's Reluctant Realism: Foreign Policy Challenges in an Era of Uncertain Power*. Palgrave Macmillan.

⁴⁴ Samuels, R. J. (2007). *Securing Japan: Tokyo's Grand Strategy and the Future of East Asia*. Cornell University Press.

⁴⁵ Funabashi, Y. (1991). *Japan and the New World Order*. Council on Foreign Relations Press.

⁴⁶ Hughes, C. W. (2009). *Japan's Remilitarisation*. Routledge.

⁴⁷ Smith, S. A. (2015). "Missile Defense Cooperation Between the United States and Japan." *Asian Security Studies Journal*.

⁴⁸ Schoff, J. (2021). "U.S.-Japan Security Alliance in the Indo-Pacific Era." *Carnegie Endowment for International Peace*.

⁴⁹ Hughes, C. W. (2017). *Japan's Foreign and Security Policy Under the 'Abe Doctrine'*. Palgrave Macmillan.

⁵⁰ Smith, S. A. (2019). *Intimate Rivals: Japanese Domestic Politics and a Rising China*. Columbia University Press.

байна.⁵¹ Цаашид Япон өөрийн батлан хамгаалах үүргээ өргөжүүлж, АНУ дэлхийн шинэ сорилтуудад дасан зохицохын хэрээр уг хоёр орны түншлэл Энэтхэг-Номхон далайн аюулгүй байдлын архитектурын төв бүрэлдэхүүн хэсэг болсоор байх магадлал өндөр байна.

БНХАУ-ын цэргийн хүчний өсөлт ба цэргийн дипломат ажиллагаа

БНХАУ сүүлийн хэдэн арван жилд эдийн засгийн өсөлт болон геополитикийн байр сууриа даган батлан хамгаалах салбарт хөрш орнуудтайгаа хамтын ажиллагааг өргөжүүлж ирсэн. Хятад нь хөрш орнуудаараа дамжин Еврази, Зүүн болон Өмнөд Хятадын тэнгис, Төв Ази, Зүүн Өмнөд Азийн аюулгүй байдлын орчинд нөлөөгөө нэмэгдүүлэхийн тулд стратегийн гэрээ, хамтарсан сургуулилалт, зэвсэг нийлүүлэлт, аюулгүй байдлын диалогуудыг ашиглаж ирсэн. Эдгээр үйл явц нь бүс нутгийн тогтвортой байдлыг хангах, АНУ болон түүний холбоотнуудаас үүсэх стратегийн дарамтыг тэнцвэржүүлэх, “Бүс ба Зам” санаачилгыг хамгаалах, мөн эдийн засаг, эрчим хүч, тээврийн коридоруудын аюулгүй байдлыг хангах зорилттой уялддаг.

БНХАУ-ын батлан хамгаалах стратеги нь Зүүн хойд Ази дахь цэргийн хурдтай шинэчлэл, батлан хамгаалах түншлэлийг гүнзгийрүүлэх үйл явцын хослол юм. Бээжин Москва-тай хязгаарлагдмал хэмжээнд, Пьехнянтай батлан хамгаалах харилцаагаа өргөтгөхийн зэрэгцээ Шанхайн хамтын ажиллагааны байгууллага зэрэг бүс нутгийн олон улсын механизмд оролцож байна. Ардын Чөлөөлөх Армийн шинэчлэл нь тэдний байлдах чадавхыг нэмэгдүүлсэн бөгөөд ялангуяа Тайвань, Зүүн Хятадын тэнгис, Өмнөд Хятадын тэнгис орчмын тэнгисийн болон агаарын цэргийн үйл ажиллагааг нэмэгдүүлсэн нь Япон болон АНУ-ын холбоотнуудтай хурцадмал байдлыг бий болгож байна. Бүс нутгийн гадна талд “Бүс ба Зам” санаачилга нь аюулгүй байдлын далд хэмжээс агуулж, дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийснээр цэргийн нэвтрэлт, нөлөөллөө тэлэхтэй холбогдож эхэлжээ. Гэсэн ч БНХАУ нь албан ёсны батлан хамгаалах түншлэл байгуулахаас зайлсхийж, илүү уян хатан түншлэлийг илүүд үзэж байна.

Хятад-Оросын харилцаа бол хамгийн гүнзгий түвшинд хүрсэн стратегийн хамтын ажиллагааны жишээ юм. Хоёр улс 2001 онд байгуулсан, 2021 онд сунгагдсан “Сайн хөршийн найрсаг хамтын ажиллагааны гэрээ”⁵² -гээр хилийн маргаанаа шийдвэрлэж, хамтарсан цэргийн сургуулилтыг тогтмолжуулсан. Түүнчлэн, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)-ын хүрээнд терроризм, салан тусгаарлалт, хэт даврагч үзэлтэй тэмцэх нэрийн дор цэргийн хамтын ажиллагааг өргөжүүлсэн нь Хятадын Төв Азид үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэв. Төв Азийн улсуудтай байгуулсан гэрээ, хамтын ажиллагаа нь хил хамгаалалт, терроризмын эсрэг чиглэсэн бөгөөд Тажикистанд байрлах Хятадын цэргийн анги нь Афганистанаас үүсэж болзошгүй аюулын эсрэг чиглэгдсэн гэж дүгнэдэг. Мөн Хятад

⁵¹ Green, M. J. (2022). Line of Advantage: Japan's Grand Strategy in the Era of Abe Shinzō. Columbia University Press.

⁵² Treaty of Good-Neighborliness and Friendly Cooperation Between the People's Republic of China and the Russian Federation. https://www.mfa.gov.cn/eng/zy/gb/202405/t20240531_11367098.html

эдгээр улсуудын зэвсгийн гол нийлүүлэгч болж, эдийн засгийн хамаарлыг аюулгүй байдлын салбартай холбон уялдуулжээ.

Хятад-Оросын түншлэл нь цэргийн-техникийн хамтын ажиллагаагаар өргөжиж, шумбагч онгоц, пуужингийн систем, эрт сэрэмжлүүлэх хамгаалалтын сүлжээний хамтарсан бүтээн байгуулалтыг хамардаг.⁵³ Восток 2022, Запад/Interaction 2021 зэрэг цэргийн хамтарсан сургуулилт болон Япон, Номхон далайн орчмын агаарын болон тэнгисийн хамтарсан эргүүл нь үйл ажиллагааны уялдааг тод харуулдаг.⁵⁴ БНХАУ-ын дарга Ши Жиньпин “Аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтийн ашиг сонирхлыг хамгаалах” талаар онцлон тэмдэглэсэн нь стратегийн эв нэгдлийг дахин баталгаажуулсан хэрэг.⁵⁵

Хятад, Умард Солонгосын хоорондын 1961 оны Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах гэрээ нь аль нэг улсад гаднаас халдлага гарвал нөгөө тал нь хамгаалах үүрэгтэйг хуульчилсан.⁵⁶ Орчин үеийн Хятадын аюулгүй байдлын бодлогод төв байр суурь эзлэхээ больсон ч, энэхүү гэрээ нь Хүйтэн дайны үеийн холбоотны харилцааны бэлгэдэл хэвээр байна.

ОХУ-ын батлан хамгаалахын гадаад харилцаа

ОХУ-ын Зүүн хойд Азид үзүүлэх нөлөө, батлан хамгаалахын гадаад харилцаа төвөгтэй ч улам бүр уялдаа холбоогоо нэмэгдүүлсээр байна. Москва-Бээжингийн стратегийн түншлэл сүүлийн жилүүдэд эрс гүнзгийрч, Япон, БНСУ орчмын хамтарсан агаарын болон тэнгисийн сургуулилтудаар илэрхий харагдаж байна. Украины дайны нөлөөгөөр ОХУ илүүтэйгээр Ази руу чиглэж, БНХАУ болон БНАСАУ-тай батлан хамгаалах хамтын ажиллагаагаа эрчимжүүлэв. Москва, Пхеньян хоёрын хооронд зэвсгийн наймаа болон цэрэг-техникийн солилцоо өрнөж, БНАСАУ сум галт хэрэглэл, цэргийн хүчний дэмжлэгийн хариуд дэвшилтэт технологи, дипломат дэмжлэг авах болсон нь шинэ сорилтыг бий болгож байна. Баруунаас тусгаарлагдаж, улам бүр уламжлалт цэргийн чадавх нь буурч буй ОХУ нь харилцан адилгүй хамтын ажиллагаанд түшиглэх боловч цөмийн зэвсгийн нөөц болон газар зүйн байрлалынхаа онцлогоор бүс нутгийн аюулгүй байдалд нөлөөтэй хэвээр байна.

ОХУ - БНХАУ-ын батлан хамгаалах харилцаа

Орос, Хятадын цэрэг-техникийн түншлэл улам бүр өргөжиж, дэлхийн аюулгүй байдлын төлөвийг тодорхойлох чухал хүчин зүйл болж байна. Энэ нь ялангуяа Оросын Украинд хийж буй өргөн цар хүрээтэй дайны нөхцөлд илүү ихээр мэдрэгдэж байна. 2022 оны хоёрдугаар сараас хойш Хятад улс Оросын дайны хүчин чармайлтыг шууд бус байдлаар дэмжигч гол орнуудын нэг болж, ялангуяа батлан хамгаалах үйлдвэрлэлийн салбарт чухал үүрэг гүйцэтгэж эхэлсэн. Гэвч энэ

⁵³ Trends Research. (2024). Russian-Chinese collaboration in defense technology: Prospects and limits. <https://trendsresearch.org/insight/russian-chinese-collaboration-in-defense-technology-prospects-and-limits/>

⁵⁴ AP News. (2025, August 26). China and Russia to hold joint naval exercise near Japan next month.

CEIAS. (2024). The Sino-Russian military nexus: New strategic shifts.

⁵⁵ Reuters. (2025, August 26). China, Russia should safeguard security, development interests, says Xi.

⁵⁶ Reddit. (2022). China-North Korea Mutual Aid and Cooperation Treaty (1961).

өөрчлөлтийг бүрэн ойлгохын тулд Бээжин, Москва хоёрын цэргийн харилцааны өмнөх үеийг судлах хэрэгтэй. Учир нь өнөөгийн хамтын ажиллагааны олон зүйл нь 2022 оноос өмнө тавигдсан суурин дээр үндэслэгдсэн байдаг.

Зөвлөлт Холбоот Улсын задралын дараахан ОХУ болон БНХАУ-ын хоорондын цэргийн хамтын ажиллагаа нь 1990-ээд оноос хойш зэвсгийн худалдаанд төвлөрсөн энгийн харилцаанаас эхэлж, улмаар стратегийн өндөр түвшний түншлэл болон өргөжиж хөгжсөн. Энэ түүхэн нөхцөл байдалд Хятад улс өөрийн зэвсэгт хүчний хүчин чадлыг нэмэгдүүлэх, түүнийг орчин үеийн түвшинд хүргэн шинэчлэх зорилгоор Оросоос зэвсэг, цэргийн техник хэрэгсэл нийлүүлэхийг зайлшгүй шаардсан бол Оросын талд Зөвлөлтийн үеэс өвлөгдөн үлдсэн өргөн цар хүрээтэй батлан хамгаалах аж үйлдвэрийн цогцыг хадгалан авч үлдэхийн тулд шинэ экспортын зах зээл нэн чухал ач холбогдолтой байсан.

Үүнээс гадна, Зөвлөлтийн үеийн үлэмж хэмжээний зэвсгийн нөөц Оросын БНХАУ-д технологийн хувьд хоцрогдсон хэдий боловч асар их хэмжээний зэвсэг нийлүүлэх боломжийг олгосон нь хоёр талын хамтын ажиллагааны эхний үе шатыг онцлог болгосон юм. Ялангуяа Хятад улс агаарын цэргийн хүчин, агаарын довтолгооноос хамгаалах систем, мөн тэнгисийн цэргийн хүчиндээ Оросын дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, түүнчлэн орчин үеийн түвшинд шинэчлэх шаардлага зайлшгүй байсан нь тус хамтын ажиллагааны цар хүрээг улам гүнзгийрүүлсэн билээ.

Стокгольмын Олон Улсын Энх тайвны Судалгааны Хүрээлэнгийн (SIPRI) нийтэлсэн баримтад дурдсанаар, 1992-2014 оны хооронд ОХУ БНХАУ-д 100 гаруй байлдааны нисэх онгоц, түүний дотор Су-27 болон Су-30 загварын сөнөөгч оноцуудыг нийлүүлжээ. Үүнээс гадна, оросын мэргэжилтнүүд Хятадын J-10, JF-17, L-15 сургалтын нисэх онгоцны хөгжүүлэлтэд тодорхой хувь нэмэр оруулсан бөгөөд 1998 оноос эхлэн Шэньян хотод J-11 сөнөөгчийг Су-27СК загварын зураг төслийн үндсэн дээр лицензийн дагуу үйлдвэрлэх боломж бүрджээ. Энэ мэдлэг, туршлагад тулгуурлан Хятад улс дараа нь Орос болон Украйны нисэхийн технологийг хослуулан J-15 зэрэг нисэх онгоц тээгчид суурилсан сөнөөгчийг өөрийн хүчээр хөгжүүлэх боломжтой болсон байна.

Мөн энэ хугацаанд Орос улс Хятадад 300 гаруй Ми-17 загварын тээврийн нисдэг тэрэг, дор хаяж 12 ширхэг С-300 агаарын довтолгооноос хамгаалах систем, 35-аас доошгүй Тор-М1 систем, мөн Су-27 сөнөөгчдийг хангах зориулалттай хэдэн зуун агаар-агаарын пуужинг нийлүүлсэн нь БНХАУ-ын агаарын цэргийн хүчин чадлыг өргөжүүлж, хөгжүүлэхэд чухал дэмжлэг үзүүлжээ.

Тэнгисийн цэргийн хүчин чадлын хувьд, Орос улс нийтдээ 12 дизель хөдөлгүүртэй шумбагч онгоц (үүнд 10 ширхэг 636Е “Варшавянка” ангиллын болон хоёр ширхэг 877Е “Лада” ангиллын шумбагч багтсан), хэдэн зуун торпедо болон Х-59 хөлөг онгоцны эсрэг пуужин, мөн шинээр баригдсан устгагчдад зориулж ойролцоогоор 120 ширхэг АК-176 төрлийн тэнгисийн буу болон агаарын довтолгооноос хамгаалах пуужин нийлүүлсэн байна. Үүнээс гадна, Хятад улс Зөвлөлтийн ашиглалтаас гарсан хоёр нисэх онгоц тээгч (Минск болон Варяг)-ийг худалдан авч, өөрийн нисэх онгоц тээгчийн хөтөлбөрийг хөгжүүлэх боломжтой болсон. Хэдийгээр Варягийг Украйнаас худалдан авсан боловч энэхүү шилжүүлэг

нь Оросын дор хаяж чимээгүй зөвшөөрөлгүйгээр хийгдэх боломжгүй байсан гэж үзэх үндэслэлтэй.

Ийнхүү 2014 оноос өмнөх хугацаанд хоёр талын хамтын ажиллагаа харилцан адилгүй боловч бие биеэ нөхөх шинжтэй байсан бөгөөд Хятад улс Оросын цэргийн-технологийн ноу-хауд түшиглэж байсан бол Оросын батлан хамгаалах үйлдвэрлэлийн салбар Хятадад зэвсэг нийлүүлэх сонирхолтой байсан нь уг харилцааны гол суурь болсон юм.

БНХАУ-ын хувьд Оросын технологийг худалдан авах нь хоёр талын зорилгоор үйлчилж ирсэн. Нэгдүгээрт, энэ нь Бээжингийн цэргийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг бол нөгөө талаар тухайн технологийн суурин дээр үндэсний зэвсгийн системийг өөрийн оронд хөгжүүлэх боломжийг олгодог. Ийм үйл явцыг цэргийн-аж үйлдвэрийн “каннибализм” хэмээн тодорхойлж болох бөгөөд Хятад улс түүхэн туршид Оросын технологийг урвуу инженерчлэлийн аргаар хуулбарлан нутагшуулж, улмаар өөрийн хэрэгцээнд нийцүүлэн сайжруулж ирсэн байдаг. Энэ байдал нь Кремлийг олон удаа бухимдуулж, хоёр талын харилцаанд тодорхой хэмжээний зөрчил, саад тотгорыг бий болгосон билээ.

Иймээс 2014-2022 оны хооронд ОХУ, БНХАУ-ын цэргийн хамтын ажиллагаа эрчимтэй өргөжиж, хэд хэдэн гол салбарт огцом ахиц дэвшил гарсан бөгөөд энэ үед Хятад улс Оросын хувьд технологийн импортын цорын ганц үлдсэн эх үүсвэр болж хувирсан. Тухайн үе нь цэргийн-техникийн хамтын ажиллагааны институцлал улам гүнзгийрсэн, хамтарсан сургуулилтүүд болон цэргийн дипломатын өргөжилтөөр тодорхойлогдож байсан бөгөөд эдгээр хүчин зүйлс нь 2025 онд ажиглагдаж буй хоёр улсын хүчирхэг боловч нарийн төвөгтэй харилцааны суурийг тавьсан юм.⁵⁷

2014-2022 оны сүүлчээр Орос-Хятадын цэргийн хамтын ажиллагааны чиг хандлагад тодорхой өөрчлөлт гарсан юм. Хятадын батлан хамгаалах технологийн хувьд өсөн нэмэгдэж буй бие даасан байдал, мөн Оросын эсрэг өрнөдийн хориг арга хэмжээтэй хослон, зэвсгийн худалдаа саарч, тогтсон түвшинд хүрсэн. Гэсэн хэдий ч дэвшилтэт радарын систем, нисдэг тэрэгний хөгжүүлэлт зэрэг хамтарсан технологийн төслүүд нь хоёр талын цэргийн хамтын ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг хэвээр үлдсэн.

Үүнтэй зэрэгцэн хамтарсан цэргийн сургуулилтүүд болон ажиллагаанууд эрс идэвхэжсэн юм. 2010 оны дунд үеэс эхлэн Орос, Хятад хоёр хамтарсан цэргийн үйл ажиллагааны давтамж, хүрээг өргөжүүлж, энгийн сургалтын хэлбэрээс илүү нарийн төвөгтэй, ажиллагааны уялдааг нэмэгдүүлэхэд чиглэсэн маневрүүд рүү шилжсэн. Эдгээр хамтарсан сургуулилтүүд нь Москва, Бээжин хоёрын зэвсэгт хүчний уялдаа, харилцан ажиллах чадварыг дээшлүүлэх хүсэл эрмэлзлийг илэрхийлэхийн зэрэгцээ олон улсад тэдний хамтын ажиллагааны өсөн нэмэгдэж буй цар хүрээг харуулах зорилготой байв. Ардын Чөлөөлөх Арми нь Оросын цэргийн туршлагаас суралцан өөрийн ажиллагааны чадавхыг сайжруулах зорилгоор хамтарсан сургуулилтүүдэд түлхүү ач холбогдол өгч байсан бол харин Оросын арми зарим салбартаа илүү

⁵⁷ Green, Mark A. “China and Russia: Quietly Going Steady?” Wilson Center, 2024.
<https://www.wilsoncenter.org/blog-post/china-and-russia-quietly-going-steady>

дэвшилттэй тул Хятадын харьцангуй туршлага багатай зэвсэгт хүчнээс суралцах боломж харьцангуй бага байлаа.⁵⁸

Гэсэн хэдий ч бодит байдал дээр хамтарсан сургуулилтууд нь хамтран байлдах чадвараа дээшлүүлэхээс илүүтэйгээр бэлгэдлийн шинж чанартай байсан гэдгийг онцлон тэмдэглэх шаардлагатай. Хятад улс өөрийн цэргүүдийг Оросын армийн хамтаар бодит ажиллагаанд оролцуулж байсан удаагүй бөгөөд үүнд Хойд Кавказ дахь терроризмын эсрэг ажиллагаа, Украинд өрнөсөн өндөр эрчимжсэн байлдааны ажиллагаа ч хамааралтай. Тиймээс байлдааны ажиллагаанд хамтран оролцох хоёр талын сургуулилтыг явуулахаас цааш хэтрэхгүй, бодит тулалдаанд хамтран оролцох түвшинд хэзээ ч хүрч чадаагүй нь тодорхой харагдаж байна.

2022 оны хоёрдугаар сарын Украин руу дайрсан дайралт нь 2014 оноос хойш ажиглагдаж ирсэн чиг хандлагуудыг эрчимжүүлснээр Орос-Хятадын цэргийн хамтын ажиллагааны динамикийг мэдэгдэхүйц өөрчилсөн. Дайралтаас бараг гурван долоо хоногийн өмнө, 2022 оны хоёрдугаар сарын 4-нд Оросын Ерөнхийлөгч Владимир Путин Бээжинд айлчилж, Хятадын дарга Ши Жиньпинтэй уулзан, хоёр орны хооронд “хязгааргүй түншлэлийн” харилцаа байгуулагдаж буйг зарласан юм.⁵⁹

Орос-Хятадын цэргийн хамтын ажиллагааны хамгийн тод харагдахуйц нэг тал нь хамтарсан цэргийн сургуулилтын давтамж, цар хүрээ өсөн нэмэгдэж буй явдал юм. Ийм сургуулилтууд нь олон талын зорилготой: Москвагийн хувьд тэдгээр нь Барууны Оросыг тусгаарлах оролдлого бүтэлгүйдсэнийг харуулах ач холбогдолтой бол Бээжингийн хувьд гол цэргийн түнштэйгээ хүчтэй холбоо тогтоосон гэдгээ баталгаажуулах хэрэгсэл болдог. Жил бүр зохион байгуулагддаг Vostok, Zapad болон Joint Sea зэрэг сургуулилтууд нь Орос, Хятадын цэргийн хүчний уялдаа, ялангуяа нарийн төвөгтэй тэнгисийн болон агаарын ажиллагааг зохицуулах чадвар өсөн нэмэгдэж буйг тод харуулдаг.

Орос, Хятадын цэргийн түншлэл нь хоёр талд аль алинд нь ашигтай хэвээр байна. Оросын хувьд Хятад руу зэвсэг экспортлох нь, ялангуяа Барууны хориг арга хэмжээний нөхцөлд, батлан хамгаалах үйлдвэрлэлийн салбарт зайлшгүй шаардлагатай орлогын эх үүсвэр болж байна. Энэ хамтын ажиллагаа нь Москвагийн батлан хамгаалах аж үйлдвэрийн цогцолборт тогтвортой хөрөнгө оруулалт хийгдэх нөхцөлийг бүрдүүлж, зэвсгийн үйлдвэрлэлийг нь тасралтгүй хадгалахад хувь нэмэр оруулж байна.

Оросын технологи болон Хятадын үйлдвэрлэлийн чадамжийн нэгдэл нь Бээжингийн цэргийн шинэчлэлийг хурдасгаж, стратегийн чухал бүсүүдэд хүчний тэнцвэрийг өөрчлөх боломжийг бий болгож байна. Үүний тод жишээ нь Хятадад үйлдвэрлэсэн давхар зориулалттай тээврийн хэрэгсэл, дроныг Оросын цэрэг дайнд ашиглаж буй явдал юм.

Орос, Хятадын цэргийн хамтын ажиллагаа нь стратегийн ашиг сонирхлоор удирдуулж, дунд болон урт хугацаанд үргэлжлэх хандлагатай байна. Украины эсрэг Оросын түрэмгийлэл үргэлжилж буй нөхцөлд Москва эдийн засаг, цэрэг-

⁵⁸ Cozad, Mark, Cortez A. Cooper III, Alexis A. Blanc, David Woodworth, Anthony Adler, Kotryna Juknevičiute, Mark Hvizda, and Sale Lilly. “Future Scenarios for Sino-Russian Military Cooperation: Possibilities, Limitations, and Consequences.” RAND, 2024. https://www.rand.org/pubs/research_reports/RRA2061-5.html.

⁵⁹ President of Russia. “Joint Statement of the Russian Federation and the People’s Republic of China on the International Relations Entering a New Era and the Global Sustainable Development.” President of Russia, 2022. <http://en.kremlin.ru/supplement/5770>

технологийн дэмжлэгийн хувьд Бээжингээс хамааралтай хэвээр байх болно. Харин Хятад улс пуужин, шумбагч онгоц, цахим дайн зэрэг тодорхой салбарт Оросыг дэвшилтэт цэрэг-технологийн эх үүсвэр болгон ашиглах шаардлагатай хэвээр байгаа ч удахгүй эдгээр чиглэлд Оросыг даван гарах төлөвтэй байна. Ийм технологийн хамаарлыг Оросын дайны туршлагаас суралцах ашиг сонирхол улам бататгаж байна. Гэсэн хэдий ч Хятадын шинжээчид хоёр улсын хоорондын технологийн зөрүү хурдацтай багасаж буйг анзаарч байгаа бөгөөд хиймэл оюун, квант тооцоолол, дрон ашигласан дайн зэрэг зарим салбарт Хятад улс аль хэдийн Оросоос давж эхэлсэн байна. Мөн цэргийн сургуулилтууд янз бүрийн шатлалын командлалын түвшинд цаашид ч үргэлжлэх өндөр магадлалтай бөгөөд Ардын чөлөөлөх арми нь Украин болон бусад сүүлийн үеийн тулалдаанд Оросын хуримтлуулсан байлдааны туршлагаас суралцахыг эрмэлзэж байна.

ОХУ - БНАСАУ-ын батлан хамгаалахын гадаад харилцаа

ОХУ болон Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (БНАСАУ, эсвэл Хойд Солонгос) хоёр талын харилцаагаа албан ёсоор 2022 оноос хойш бэхжүүлэх алхам хийж эхэлсэн. ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин, БНАСАУ-ын удирдагч Ким Жон Ун нар 2023 оны есдүгээр сард Оросын Алс Дорнодод, 2024 оны зургаадугаар сард Пхеньянд дээд хэмжээний уулзалт хийсэн. Пхеньянд болсон уулзалтын үеэр Путин, Ким нар харилцан цэргийн туслалцаа үзүүлэх заалтыг багтаасан “*Бүрэн стратегийн түншлэлийн гэрээ*”-нд гарын үсэг зурсан байна. Хойд Солонгос Оросын Украины эсрэг явуулж буй цэргийн ажиллагааг дэмжиж, мянга мянган тээврийн контейнерээр сум хэрэгсэл нийлүүлж, баллистик пуужин өгч, мөн 10,000 ба түүнээс олон цэргийг Оросын Курскийн бүс нутагт байршуулан, Украины хүчнийг тэндээс шахан гаргахад тусалжээ. Судлаачдын үзэж байгаагаар, ОХУ БНАСАУ-д цэргийн дэвшилтэт технологи шилжүүлсэн эсвэл цаашид шилжүүлж болзошгүй бөгөөд энэ нь Хойд Солонгосын АНУ болон түүний холбоотнуудад учруулах аюулыг нэмэгдүүлэх магадлалтай. Түүнчлэн Оросын Засгийн газар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хойд Солонгосын эсрэг хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явцыг сулруулах алхмуудыг хийж байна.⁶⁰

ОХУ-БНАСАУ-ын шинэ шатны харилцаа нь АНУ-ын конгрессийн анхаарлын төвд байгаа хэд хэдэн асуудалд нөлөөлж байна. Үүнд: Украины дайны нөхцөл байдал, ОХУ болон Хойд Солонгосын эсрэг хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байдал, мөн БНАСАУ-ын цэргийн чадавхын өсөлт багтана. Жишээлбэл, Оросоос ирэх технологийн хагас дамжуулах төхөөрөмж нь Хойд Солонгосын пуужингийн АНУ-ын эх газрыг төдийгүй Зүүн Азийн холбоотон улсуудыг онох чадварыг нэмэгдүүлж болзошгүй юм.

БНАСАУ-ын цэргийн хамтын ажиллагаа

БНАСАУ нь Зүүн хойд Азийн батлан хамгаалах хамтын ажиллагааны гол хөдөлгөгч хүчин хэвээр байна. Умард Солонгос цөмийн болон дэвшилтэт баллистик

⁶⁰ <https://www.congress.gov/crs-product/IF12760>

пуужингийн хөтөлбөрөө тууштай хөгжүүлж, тив алслагдсан байг онилох чадвартай зэвсгийг хүртэл туршиж байгаа нь бүс нутгийн аюулгүй байдлын түгшүүрийг улам нэмэгдүүлж байна. Цэргийн байр сууриа Пхеньян гадаад аюул заналаас сэргийлэх хүчин зүйл төдийгүй дипломат хөзөр болгон ашигладаг. Сүүлийн жилүүдэд БНАСАУ нь ОХУ, БНХАУ-тай улам ойртож, эдийн засгийн тусламж, технологи, улс төрийн дэмжлэг хайж байна. Олон улсын хориг арга хэмжээний улмаас батлан хамгаалах хамтын ажиллагаа нь хязгаарлагдмал ч Москва, Бээжинтэй харилцаа нь бүс нутгийн аюулгүй байдлын шинэ төвөгтэй байдлыг бий болгож байна. БНАСАУ-ын цөмийн замнал тодорхой бус байгаа нь бүс нутгийн батлан хамгаалах хамтын ажиллагааг улам чангатгах түлхэц болсоор байна.

Япон - БНСУ-ын батлан хамгаалахын гадаад харилцаа

Япон, БНСУ хоёулаа бүс нутгийн батлан хамгаалахын орчин дахь үүргээ дахин тодорхойлж байна. Япон нь сүүлийн жилүүдэд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж, шинэ батлан хамгаалах стратеги боловсруулан зөвхөн өөрийгөө хамгаалахаас гадна дайсны эсрэг довтолгоо явуулах чадавхтай болж, бүс нутгийн аюулгүй байдлын идэвхтэй оролцогч болон хувирч байна. Токио батлан хамгаалах төсвөө нэмэгдүүлж, АНУ, Австрали, Энэтхэг зэрэг түншүүдтэй хамтын ажиллагаагаа өргөтгөсөн. Харин БНСУ нь өөрийгөө батлан хамгаалах түнш байхаас гадна дэлхийд хүчтэй батлан хамгаалах бүтээгдэхүүн экспортлогч орон болон гарч ирж, Европ, Ойрхи Дорнод, Зүүн өмнөд Ази руу дэвшилтэт зэвсэг нийлүүлж байна. Үүний зэрэгцээ Сөүл Вашингтонтой холбоогоо бэхжүүлж, БНХАУ-тай төвөгтэй харилцаагаа болгоомжтой тэнцвэржүүлж байна. Энэ бүхэн нь Япон, БНСУ-ыг АНУ-ын удирдлагад бүрэн найдах бус, өөрсдөө бүс нутгийн батлан хамгаалах чиг хандлагад нөлөөлөх чадвартай болгож байна.

Олон талт болон бүс нутгийн хамтын ажиллагаа

Геополитикийн хувьд Монгол Улс Орос, Хятад гэсэн хоёр их гүрний дунд байрладаг нь стратегийн хувьд эмзэг мөн чухал байр суурь эзэлдэг. Энэ нөхцөл нь Монгол Улсыг аль нэг талд татагдахгүй, тэнцвэртэй гадаад бодлого явуулах шаардлагатай болгож байна.

Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс⁶¹-ийн 3.1. дүгээр зүйлд Монгол Улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгон улс төр, дипломатын аргыг урьтал болгох гэж заасны дагуу хоёр болон олон улсын батлан хамгаалах хамтын ажиллагааг хөгжүүлж улс орныхоо аюулгүй байдлыг хангаж байна. Мөн тус бүлгийн 3.2.4. дүгээр зүйлд зааснаар Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд цэргийн аюул, заналхийлэл учирсан буюу учрах нь бодитой болсноос бусад тохиолдолд цэргийн аливаа эвсэл холбоонд нэгдэхгүй гэж заасны үндсэн дээр олон улсын болон бүс нутгийн цэргийн эвсэл холбоонд нэгдэх


⁶¹ Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоол

үндэслэлгүй ба уг бодлогын 3.2.1. дүгээр зүйлд зааснаар хөрш орнуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх гэж дурдсаны дагуу бусад улстай цэргийн харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна. Мөн тус бодлогын 3.2.3. дугаар зүйлд заасны дагуу энхийг дэмжих ажиллагаанд зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдыг оролцуулах гэж зааснаар уг ажлыг идэвхтэй явуулж байна.

Монгол Улс нь бүс нутгийн болоод дэлхийн энх тайвны үйл хэрэгт нөлөө, хувь нэмрээ улам бүр тэлж буй төдийгүй өөрийн өвөрмөц онцлог бүхий орон. Тухайлбал, олон талт яриа хэлэлцээг тууштай дэмждэг, энхийг сахиулах ажиллагаанд тогтмол оролцдог. Монгол Улс нь зарчимч, идэвх санаачилгатай түншийн жишээ болж олон улсын хамтын нийгэмлэгт тодорхой байр суурь эзэлж байна.

Монгол Улсын энхийг сахиулагчдын мэргэжлийн ур чадвар, сахилга бат, зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэлт нь олон улсын тавцанд өндрөөр үнэлэгдэж, бусад улсын алба хаагчдад үлгэр дуурайлал үзүүлж байгааг НҮБ-ын үе, үеийн удирдлагууд болон оролцогч улс орнууд онцлон сайшааж, Монгол Улсыг энхийг сахиулах ажиллагаанд амжилттай оролцож буй, туршлагатай, онцлог арга барилтай талаар онцолсоор ирсэн билээ. Сүүлийн үеийн тоон мэдээллээр, манай улс жилд дунджаар 900 орчим алба хаагч НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд илгээж буй нь цэрэг, цагдаа хандивлагч 120 гаруй улсаас 18 дугаарт бичигдэж байна. Бүс нутгийн хэмжээнд авч үзвэл, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцдог Ази тивийн 20 гаруй улсаас 5 дугаарт эрэмбэлэгдэж байна. Хүн амын тоо бага хэдий ч Монгол Улс энхийн үйл хэрэгт бодитой, идэвхтэй хувь нэмэр оруулж буйг энэхүү үзүүлэлт харуулж байна.


Зүүн Хойд Ази болон Ази-Номхон далайн бүс нутаг нь дэлхийн геополитикийн хувьд хамгийн эмзэг, хурцадмал бүс нутгийн нэг юм. Энд томоохон их гүрнүүдийн ашиг сонирхол огтлолцож, олон улсын худалдаа, эрчим хүчний урсгалын гол хэсэг дамждаг тул аюулгүй байдлын асуудал олон улсын анхаарлын төвд байдаг. Энэ бүс нутагт ихэвчлэн уламжлалт бус аюул зонхилж байгаа ба үүнд цөмийн зэвсгийн аюул, далай тэнгисийн маргаан, терроризм, кибер аюул, уур амьсгалын өөрчлөлт зэрэг олон талын сорилтууд тулгардаг. Үүнийг зөвхөн нэг улс дангаараа шийдвэрлэх боломжгүй. Иймээс олон улсын болон бүс нутгийн байгууллагууд хамтын ажиллагааны замаар энх тайван, тогтвортой байдлыг хангахыг эрмэлзсээр ирсэн.



Зураг 1. Монгол Улсын дэлхийн аюулгүй байдлын олон улсын байгууллагуудын гишүүнчлэл

Зүүн Ази болон Ази-Номхон далайн аюулгүй байдлын орчин олон улсын аюулгүй байдлыг хангах байгууллагуудын оролцоогүйгээр хангагдах боломжгүй. НҮБ, АСЕАН, ШХАБ, CSTO, НАТО, OSCE, QUAD, AUKUS зэрэг аюулгүй байдлын байгууллагууд болон түнш улсуудын нэгдэл өөр өөрийн өвөрмөц хэлбэрээр бүс нутгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулж байна. Цаашид бүс нутгийн аюулгүй байдлын сорилт улам олон талт, нягт холбогдсон шинжтэй болох тул хамтын ажиллагааны механизмын ач холбогдол улам нэмэгдэх хандлагатай. Дээр дурдсан олон улсын аюулгүй байдлыг хангах байгууллагуудын хамтын ажиллагааны талаар дурдвал.

Нэгдмэл хамтын аюулгүй байдлын үзэл баримтлал ба Нэгдсэн Үндэстний Байгууллага нь олон улсын зэвсэгт мөргөлдөөний талаарх үзэл хандлагыг өөрчилж, хүн төрөлхтнийг энхийн шинэ эрин үе рүү хөтөлсөн юм. Гэсэн хэдий ч бүс нутгийн хамтын ажиллагаа нь дэлхий даяар үр ашигтай аюулгүй байдлын нийгэмлэгүүдийг байгуулах, хөрш улсуудын хоорондох зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэхэд туйлын чухал ач холбогдолтой байна.



Зураг 2. Бүс нутгийн аюулгүй байдлыг хангаж буй олон улсын байгууллагууд⁶²

Хамтын ажиллагаанд суурилсан аюулгүй байдлын сайн жишээнүүдийн нэг нь OSCE болон АСЕАН юм. OSCE нь энх тайвныг эрхэмлэх, ардчиллын хөгжлийг дэмжих, улс төрийн шинэ хуваагдлаас сэргийлэх, аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх зорилготой. АСЕАН нь Зүүн Өмнөд Азид, либерал ардчилал байхгүй, нийтлэг таних тэмдэг эсвэл байгууллагагүй нөхцөлд байгуулагдсан. OSCE-ийн тохиолдлын адил, үндсэн зорилго нь ирээдүйн зэвсэгт мөргөлдөөнөөс сэргийлэн харилцан итгэлцлийг бий болгох байсан. Гэвч байгууллагын бүтэц, институцийн хөгжил нь тодорхой түвшний нийтлэг таних тэмдэг шаарддаг бөгөөд өнөө үед бид “АСЕАН зам” (хууль, процесс, институт) болон энхийн хэлэлцээр нь зөрчилдөөн удирдах гол арга болсон гэж дүгнэх боломжтой.

62

https://en.wikipedia.org/wiki/List_of_intergovernmental_organizations#/media/File:Alliances_expansive_Map.png

Хамтын ажиллагаанд суурилсан аюулгүй байдал нь олон хүчин зүйлсийг хамтад нь ажиллуулахыг шаарддаг. Ялангуяа ирээдүйн хүлээлтэд нийтлэг хандлага шаардлагатай бөгөөд гишүүн орнууд эхний ээлжид бие биеэ өрсөлдөгч биш, түнш гэж үзэх ёстой. XXI зуунд улс орнуудын харилцан хамаарал нь Европт глобал, бүс нутгийн, орон нутгийн асуудлуудыг (терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, байгалийн гамшиг) хамтарсан шийдлээр шийдвэрлэх хүрээ бий болгоход ихээхэн хувь нэмэр оруулсан.

Гэсэн хэдий ч хамтын ажиллагаанд суурилсан аюулгүй байдлын институтүүдийг том гүрнүүдийн өрсөлдөөн хэрхэн өөрчилж буйг анзаарахгүй өнгөрч болохгүй. Зарим байгууллага (жишээ нь OSCE)-ийн үйл ажиллагаа бууралттай байгаа бол бусад нь (ШХАБ, АСЕАН) төсөөлөөгүй боломжийг харуулж байна. Дэлхий нийтийн түвшинд Хятад-АНУ-ын өрсөлдөөн шинэ Хүйтэн дайныг үүсгэж, Европын орнууд, түүн дотор Орос, Турк болон бусад орнууд аль нэг талд нэгдэх сонголт хийхэд хүргэж байна. Энэ сонголт нь тухайн орнуудын аюулгүй байдлын хандлагаас хамаарах бөгөөд OSCE-ийн 57 гишүүн улс тус бүрийн үзэл бодолд зөрөө гарна. Бүс нутгийн түвшинд, Оросын Украинд хийсэн түрэмгийлэлд (2014, 2022) нь эргэлтийн цэг болж, өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан институтүүдийг, тухайлбал INF гэрээ, Open Sky гэрээ болон Европын аюулгүй байдлын архитектурын бусад үндсэн элементүүдийг устгасан. Мэдээж, OSCE нь НАТО-Оросын Зөвлөлийн үйл ажиллагаа зогссоны дараа бусад сувгууд ажиллахгүй үед Барууны тал Оростой хэлэлцээр хийх гол платформ хэвээр байгаа ч, энэ нь OSCE-ийн түүхэн ололтуудаас ухралт юм.

Аюулгүй байдлын байгууллагууд (жишээлбэл, НАТО, ШХАБ, Хамтын Аюулгүй байдлын Гэрээний Байгууллага (CSTO), Европын Аюулгүй байдал, Хамтын ажиллагааны Байгууллага (OSCE) гэх мэт) нь олон улсын харилцааны салбарт чухал үйл ажиллагаа явуулагч этгээдүүд юм. Тэд дэлхийн улс төрийг үндсээр нь өөрчилдөг боловч тэдний үйл ажиллагааг онолын үүднээс тайлбарлах арга барил цаг хугацааны явцад өөрчлөгдөж байдаг.

Бүс нутгийн (аюулгүй байдлын) хамтын ажиллагааны гол зорилго нь тогтмол харилцааг дэмжих дипломат сувгуудыг бий болгож, итгэлцлийг нэмэгдүүлэн, аливаа буруу ойлголт үүсэх магадлалыг бууруулахад оршдог. Учир нь буруу ойлголт нь ихэнх зөрчилдөөн, маргааны анхны шалтгаан болдог.

Олон улсын хамтын ажиллагааны үндсэн зорилго нь талуудын хооронд харилцах сувгийг бий болгож, харилцан үл итгэх байдлыг бууруулахад оршдог. Итгэлцэл бий болгох нь зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх анхны алхам юм. Нийтлэг дүрмийг гишүүн бүр хүндэтгэдэг, учир нь тэд ирээдүйн ашгаа алдахаас эмээдэг бөгөөд тогтолцоог ашиглах нь тэдэнд илүү зардал багатай байдаг. Хэрэв олон талт сувгууд үр дүнтэй ажиллаж чадвал олон хоёр талт сувгийг хадгалах шаардлагагүй болдог.

Олон улс болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангаж буй анхны олон улсын хамтын байгууллага бол НҮБ юм. НҮБ-ийн гишүүн 193 орнууд аюулгүй байдлыг хангахаас гадна мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлж, энх тайван байдлыг тогтоох зорилгыг агуулдаг. НҮБ-аас тогтоосон энх тайван байдлын дүрэм журам, хууль зүйн хэм хэмжээ, тогтоолуудыг гишүүн орон бүр дагаж мөрддөг. Хамтын үнэт зүйлсийг хууль эрх зүйн баримт бичгээр тогтоодог бөгөөд энэ нь 193 гишүүн улсын хамгийн том нийтлэг суурийг агуулдаг. Хамтын аюулгүй байдлын сонгодог жишээнд Үндэстнүүдийн Лиг болон Нэгдсэн Үндэстний Байгууллага ордог. НҮБ-ын хоёр гол байгууллага болох НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл болон Ерөнхий Ассамблей нь тодорхой нөхцөл байдалд хүч хэрэглэх шийдвэр гаргах эрхтэй. Хамтын ажиллагааны энэхүү тогтолцоо нь либерал институционалист олон улсын харилцааны онолчдын үзэж байгаачлан, өөрсдийгөө их гүрнүүдийн түрэмгийллээс дангаар хамгаалах боломжгүй жижиг улсуудад тун ашигтай механизм болдог.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 39 дүгээр зүйлд зааснаар: “Аюулгүйн Зөвлөл нь энх тайванд заналхийлэл, энх тайвныг зөрчих үйлдэл, эсвэл түрэмгий үйл ажиллагаа байгаа эсэхийг тогтоож, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хадгалах буюу сэргээхийн тулд 41 ба 42 дугаар зүйлд заасан арга хэмжээг авах эсэх талаар зөвлөмж гаргах буюу шийдвэр гаргана.”

НҮБ-ын хүч чадал болон ач холбогдол нь гишүүн орнуудын хүсэл зоригоос үргэлж хамаарч ирсэн. Хэрэв тэд өөрийн үндэсний ашиг сонирхлоос шалтгаалан, эсвэл түүнээс үл хамааран НҮБ-ын зорилгод үйлчлэхэд бэлэн байвал, тус байгууллага нь хүчирхэг хэрэгсэл хэмээн тооцогддог. Гэвч ихэнх тохиолдолд НҮБ илүүтэйгээр тархай бутархай “багажийн цүнх” мэт харагддаг бөгөөд гишүүн орнууд өөрийн бүрэн эрхт байдал, хүч чадлаа ямар нэгэн хэлбэрийн түрэмгийллээс хамгаалахын тулд өөр өөрийн арга зам хайдаг.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл энх тайван ба аюулгүй байдлын асуудлаар шийдвэр гаргах үүрэг хүлээдэг. Түүнээс хойш НҮБ-ын энхийг сахиулагчдыг шаардсан ихэнх зэвсэгт мөргөлдөөн улс орны дотоодын шинж чанартай байсан (иргэний дайн болон улсын дотоодын зэвсэгт мөргөлдөөнүүд). Олон судлаачид хамтын аюулгүй байдлын үзэл баримтлалыг олон улсын харилцааны онолын реалист болон либерал чиглэлүүдийн үүднээс шүүмжилж ирсэн.

НҮБ нь олон улсын хууль тогтоомжийн хүрээнд чиглэл өгөх, улс орнуудын хооронд энхийн хэлэлцээг зуучлах, шаардлагатай тохиолдолд энхийг сахиулах бүх арга хэрэгслийг ашиглах эрхтэй байдгаараа олон улсын аюулгүй байдалтай хамгийн нягт холбоотой, хамгийн чухал байгууллага юм.

Засгийн газар хоорондын бүс нутгийн байгууллагууд дэлхийн бүс нутгуудыг бүхэлд нь хамардаг — Номхон далайгаас (АСЕАН, ШХАБ, Номхон далайн холбоо), Евро-Атлантын бүс нутгаас (НАТО) эхлээд Ойрхи Дорнод, Африк (Арабын Лиг, Африкийн Холбоо, Өмнөд Африкийн Хөгжлийн Нийгэмлэг/SADC) хүртэл. Эдгээрийн зарим нь, тухайлбал НАТО болон ШХАБ нь голчлон батлан хамгаалахын холбоо

⁶³ United Nations - The Conceptual Issue of Collective Security and the Practical Problems of Its Implementation, Dora Molnar;

бол, бусад нь (жишээлбэл, Африкийн Холбоо болон Европын Холбоо) энхийг сахиулах хүчин илгээх байдлаар олон улсын аюулгүй байдалд хувь нэмэр оруулдаг.

НҮБ-ын хамтын аюулгүй байдлын тогтолцооны үүрэг нь системийн доторх энх тайвныг хадгалахад оршдог бөгөөд гишүүн орнуудыг гаднаас ирэх аюул заналхийллээс хамгаалахад чиглэдэггүй. Энэ утгаараа, гишүүн орнуудын хоорондын харилцааг зохицуулах замаар систем нь дотоод чиглэлтэй гэж хэлж болно. Энэхүү тогтолцооны зорилго нь аль болох олон улсыг системд хамруулах зорилготой бөгөөд ингэснээр аюулгүй байдлын янз бүрийн хүрээнд бий болох албан ёсны болон албан бус харилцаа нь аюулгүй байдлыг баталгаажуулах, нэмэгдүүлэх зохистой үндэс суурь болдог.

НҮБ-ын үйл ажиллагаанд гишүүн орнуудын улс төрийн хүсэл зориг, ашиг сонирхол шууд нөлөөлдөг. Том гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчил нь Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр гаргах үйл явцыг удаашруулж, заримдаа сааруулдаг. Үүнээс шалтгаалан НҮБ нь илүү уян хатан бүс нутгийн хамтын ажиллагаанд тулгуурласан арга хэлбэрүүдийг хэрэглэх болжээ. Ерөнхий Ассамблей, бүс нутгийн байгууллагууд, болон тусгай агентлагуудын үүрэг улам нэмэгдэж байна.

Ирээдүйд НҮБ-ын улс төрийн нөлөө харьцангуй буурах хандлагатай ч энхийг сахиулах, хүмүүнлэгийн болон гамшгаас урьдчилан сэргийлэх ажиллагаа улам чухал болох төлөвтэй. Цаг уурын өөрчлөлт, кибер аюул, бүс нутгийн тогтворгүй байдал зэрэг шинэ сорилтууд НҮБ-ын ажиллагаанд шинэ чиглэл, шинэ чадамж шаардана.

Жижиг улсууд, тэр дундаа Монгол Улсын хувьд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцох, бүс нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах, кибер болон гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхаа нэмэгдүүлэх нь олон улсын тавцанд байр сууриа бэхжүүлэх үр дүнтэй алхам байх болно.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагад (НҮБ) 1961 оны 10 дугаар сарын 27-нд албан ёсоор элссэн. Энэ нь Монгол Улсын гадаад бодлогод шинэ үеийг нээж, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн болж, олон улсын тавцанд идэвхтэй оролцох үндэс суурийг тавьсан үйл явдал байв.

Монгол Улсын Байнгын төлөөлөгчийн газар нь НҮБ-ын төв байр Нью-Йорк хотод байгуулагдсан бөгөөд Монгол Улсын анхны байнгын төлөөлөгчөөр дипломатч Д.Цэвэгмид томилогдож ажилласан. Үүнээс хойш Монгол Улс НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, олон улсын энх тайван, аюулгүй байдал, хөгжлийн асуудлуудад хувь нэмрээ оруулсаар ирсэн.

Монгол Улс урьдчилан сэргийлэх дипломат ажиллагааг нэн тэргүүнд авч үздэг бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) энхийг сахиулах ажиллагааг тууштай дэмжиж ирсэн юм. 1996 онд Монгол Улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзлээ илэрхийлсэн нь дэлхийн аюулгүй байдлын салбарт олон улсын хамтын нийгэмлэгтэй идэвхтэй хамтран ажиллах чухал алхам болсон юм. Үүний дараа, 1999 онд Монгол Улс болон НҮБ хооронд “Нэгдсэн Үндэстний Байгууллагын бэлэн байдлын зохицуулалтад хувь нэмэр оруулах тухай харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулснаар Монгол Улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцох эрх зүйн болон институтийн үндэс суурь тавигдсан билээ.

2002 онд Монгол Улсын Их Хурал “Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон бусад олон улсын ажиллагаанд цэргийн болон цагдаагийн алба хаагчдыг оролцуулах тухай хууль”-ийг баталснаар НҮБ-ын мандатын хүрээнд Монгол Улсын цэргийн болон цагдаагийн алба хаагчдыг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах дотоод эрх зүйн зохицуулалт бий болсон юм. Монгол Улсын цэргийн алба хаагчид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2002 оноос оролцож эхэлсэн. Анх Монголын Зэвсэгт хүчний хоёр цэргийн алба хаагч БНАКУ дахь MONUC энхийг сахиулах ажиллагаанд ажиглагчаар оролцсон бол дараа нь Ирак, Исламын Бүгд Найрамдах Афганистан, Судан, Өмнөд Судан, Чад, Конго, Мали зэрэг улсуудад олон улсын энхийг сахиулах болон тогтворжуулах ажиллагаанд өргөн хүрээтэй оролцож ирсэн. Энэхүү оролцоог үр дүнтэй зохион байгуулах, НҮБ-ын төв байгууллагуудтай шууд харилцаа холбоо тогтоох шаардлагын үүднээс Монгол Улс 2006 оноос эхлэн НҮБ-ын дэргэдэх Байнгын төлөөлөгчийн газартаа цэргийн зөвлөх томилох болсон нь институтийн хувьд чухал алхам байсан.

Цэргийн зөвлөхийн гол үүрэг нь Монгол Улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб болон НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газар, Цэргийн штаб хоорондын уялдаа холбоог хангах, Монгол Улсын энхийг сахиулагчдын үйл ажиллагааг төлөвлөн зохицуулах, тэдний эрх ашгийг хамгаалах, мөн НҮБ-ын энхийг сахиулах бодлого, чиг хандлагад Монголын байр суурийг тусгах зэрэгт чиглэдэг. Үүнээс гадна цэргийн зөвлөх нь Монгол Улсын энхийг сахиулах хүчин олон улсын стандарт, сургалт, ажиллагаанд нийцэж ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Одоогийн байдлаар бригадын генерал Г.Болор НҮБ-ын дэргэдэх Байнгын төлөөлөгчийн газрын Цэргийн зөвлөхөөр 2023 оноос томилогдон ажиллаж байна. Түүний үүрэг нь Монгол Улсын энхийг сахиулах оролцоог олон улсын түвшинд төлөөлөх, НҮБ-ын байгууллагуудтай цэргийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, мөн Монголын энхийг сахиулагчдын мэргэжлийн чадавх, нэр хүндийг өсгөхөд чиглэж байна.

Умард Атлантын гэрээний байгууллага (НАТО)⁶⁴

Монгол Улс 2005 онд НАТО-гийн түншлэлийн хөтөлбөрт нэгдсэнээс хойш батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаагаа тасралтгүй хөгжүүлж, бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэхүү хамтын ажиллагаа нь Монгол Улсын гадаад бодлогын олон тулгуурт бодлоготой нийцэж, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулж байна.

Монгол Улс НАТО-гийн Батлан хамгаалах боловсролыг сайжруулах хөтөлбөр (Defence Education Enhancement Programme, DEEP)-т 2013 оноос хамрагдаж, Үндэсний Батлан хамгаалах их сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинэчилж, НАТО-гийн стандартад нийцүүлэн офицер, ахлагч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, бэлтгэлийг зохион байгуулж байна.

⁶⁴ NATO Collective Defence, Zoltan Szenes

НАТО-гийн тэргүүлсэн олон улсын энх тайван ажиллагаанд идэвхтэй оролцож, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулсаар ирсэн. Тухайлбал, 2005-2007 онд Косовогийн хүч (KFOR)-т 72 цэрэг, 2003-2014 онд Афганистаны "Тогтвортой эрх чөлөө" ажиллагаанд нийт 1,108 цэрэг, 351 сургагч багш оролцуулсан нь Монгол Улсын Зэвсэгт хүчний олон улсын хамтын ажиллагааны туршлагыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

Цаашид Монгол-НАТО-ийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэх, батлан хамгаалах салбарын чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын энх тайван ажиллагаанд идэвхтэй оролцох төлөвтэй байна. НАТО-гийн шинэ стратегийн концепцийн хүрээнд Ази-Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх зорилт тавигдсан бөгөөд Монгол Улс бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх боломжтой гэж үзэж байна.

Энэхүү хамтын ажиллагаа нь Монгол Улсын батлан хамгаалах салбарын чадавхыг бэхжүүлэхээс гадна олон улсын энх тайван, аюулгүй байдлыг дэмжих, үндэсний аюулгүй байдлын эрх ашгийг хамгаалах, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр стратегийн ач холбогдолтой үр дүнтэй оролцоо болж байна.

Монгол Улс 2005 онд НАТО-гийн түншлэлийн хөтөлбөрт нэгдсэнээс хойш батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаагаа тогтвортой хөгжүүлж, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна. 2013 онд Батлан хамгаалах боловсролыг сайжруулах хөтөлбөрт (DEEP) нэгдсэнээр Үндэсний Батлан хамгаалах их сургуулийн сургалтын хөтөлбөрийг НАТО-гийн стандартад нийцүүлэн шинэчилж, цэргийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чухал дэмжлэг болсон ч энэ шинэчлэлт бүрэн үр дүнгээ өгч чадаагүй. Монгол Улс Косово болон Афганистанд энхийг сахиулах ажиллагаанд оролцсон нь олон улсын тавцанд Монгол Улсын Зэвсэгт хүчний нэр хүндийг өсгөж, туршлага хуримтлуулах чухал алхам болсон. Цаашид Монгол-НАТО-ийн хамтын ажиллагаа кибер аюулгүй байдал, батлан хамгаалах инновац, стратегийн судалгаа зэрэг шинэ чиглэлд өргөжих төлөвтэй байна. НАТО-гийн шинэ стратегийн хүрээнд Ази-Номхон далайн бүсийн түншлэлийг гүнзгийрүүлэх зорилт тавигдаж байгаа нь Монгол Улсад бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангахад идэвхтэй хувь нэмэр оруулах өргөн боломжийг олгож байна.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ)⁶⁵

Монгол Улс 2004 оноос хойш Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын (ШХАБ) ажиглагчийн статустай байсан бөгөөд 2025 оны 9-р сард тус байгууллагын бүтэц өөрчлөгдсөнөөр Монгол Улс шинэ "ШХАБ-ын түнш" статусыг хүлээн авахаас татгалзаж, гурван талт хамтын ажиллагааг Хятад, Орос улстай илүү гүнзгийрүүлэх стратегийн чиглэл баримталж байна. Монголын тал бүс нутгийн аюулгүй байдал, хил орчмын хамтын ажиллагаа, харилцан итгэлийг бэхжүүлэхэд ашиглагдаж ирэв. Ажиглагчийн статустай оролцоо нь Монгол Улсад тус байгууллагын хурал, салбарын уулзалтуудад оролцох, мэдээлэл солилцох, зарим практик хамтын

⁶⁵ Security Organisations of East Asia: The Association of Southeast Asian Nations and the Shanghai Cooperation Organisation, Andras Bartok - Virag Varro;

ажиллагаанд (хамтарсан дадлага, терроризм-той тэмцэх хэрэгсэл, хил хамгаалал) оролцох боломжийг олгодог.

ШХАБ-ын хүрээнд зохион байгуулагддаг цэргийн хамтарсан сургалт, тактик-стратегийн зөвлөлдөх уулзалтууд, хил хамгаалал, терроризм-тэй тэмцэх, хүний аюулгүй байдалтай холбоотой дадлага, мэдээлэл солилцох механизм зэрэг нь Монголын батлан хамгаалах салбарт техникийн болон практик-ур чадвар олгож байна.

ШХАБ-ын салбар уулзалт, хоёр талын харилцаан дахь уулзалтууд (ШХАБ-ын гишүүн, ажиглагч орнуудын Батлан хамгаалах сайд нарын уулзалт) нь Монголын Батлан хамгаалах сайдад бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар стратегийн харилцаа тогтоох, хил орчмын хамтын ажиллагааг бэхжүүлэх, мэдээлэл солилцох цэг болдог. Эдгээр уулзалтууд нь ихэвчлэн бүс нутгийн орнуудын аюулгүй байдлын асуудлыг хамтын журмаар шийдвэрлэх, итгэлцлийг бэхжүүлэхэд чиглэсэн дипломат ба техникийн хэлэлцээнүүдийг багтааж байна.

Монгол Улс ШХАБ-ын хүрээнд батлан хамгаалах чиглэлээр идэвхтэй оролцож байсан бөгөөд 2025 оны 9-р сард Хятад, Орос улстай хамтран "Хил хамгаалалтын хамтын ажиллагаа-2025" хэмээх анхны гурван талт цэргийн сургуулилтыг зохион байгуулсан.

Цаашид Монгол Улс ШХАБ-ын хүрээнд идэвхтэй ажиглагчийн байр сууриа хадгалж, бүс нутгийн итгэлцэл, аюулгүй байдлын механизмыг дэмжихийн зэрэгцээ Хятад, Орос улстай стратегийн түвшний хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар үндэсний болон бүс нутгийн ашиг сонирхлыг уялдуулах бодлого хэрэгжүүлэх төлөвтэй байна.

Зүүн Өмнөд Азийн улс орнуудын нийгэмлэг (АСЕАН)⁶⁶

Монгол Улс 2005 онд Treaty of Amity and Cooperation (TAC)-т нэгдсэнээр АСЕАН-тай холбоо тогтоосон бөгөөд энэ нь Монгол-АСЕАН харилцааг өргөжүүлэх, бүс нутгийн эдийн засаг, дипломат багцад нэвтрэх суваг болсон. Нээлттэй эх сурвалжууд Монгол Улсын TAC-д нэгдсэн түүх болон 2020-аад он гарснаас хойш дээд, дунд түвшний харилцаа идэвхэжсэн баримтуудыг тэмдэглэж байна; 2025 онд Гадаад хэргийн сайд/элчин сайдын түвшинд АСЕАН-тай харилцааг илүү гүнзгийрүүлэх зорилгоор албан мэдэгдэл, санал солилцсон. Монголын хувьд АСЕАН-тай албан ёсны "диалог түнш" болох хүсэл (dialogue partner) байнга илэрхийлэгдэж ирсэн ба АСЕАН талтай харилцан ашигтай, тухайн бүсийн механизмд оролцох сонирхол их байна.

Зүүн хойд Азид өргөн хүрээний бүс нутгийн аюулгүй байдлын байгууллагын хүчин чармайлт хязгаарлагдмал хэвээр байна. Зүүн өмнөд Азийн холбооны (АСЕАН) удирдсан механизм, тухайлбал АСЕАН Батлан хамгаалахын сайд нарын өргөтгөсөн уулзалт (ADMM-Plus), Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт зэрэг нь яриа хэлэлцээний индэр болж байгаа ч бодит үр дүн нь хязгаарлагдмал. Үүний оронд бүс нутагт гурван талт болон жижиг бүлгийн (minilateral) механизм нэмэгдэж байна.

⁶⁶ Security Organisations of East Asia:

The Association of Southeast Asian Nations and the Shanghai Cooperation Organisation, Andras Bartok-Virag Varro

АНУ-Япон-БНСУ-ын гурвалсан механизм болон Япон-Австрали-АНУ-ын түншлэл нь илүү практик уялдаа холбоо бий болгож байна. Мөн өргөн хүрээний Энэтхэг-Номхон далайн хамтын ажиллагааны механизм болох QUAD, AUKUS нь шууд бус ч нөлөө үзүүлж байна. Япон нь QUAD-ын идэвхтэй гишүүн бөгөөд БНСУ AUKUS-ын түнш орнуудтай, ялангуяа технологи болон батлан хамгаалах салбарт ойртохыг эрмэлзэж байна. Иймэрхүү жижиг бүлгийн механизм нь Зүүн хойд Азид цогц байгууллага дутмаг байгааг нөхөж, бодит хамтын ажиллагааны гол хөшүүрэг болж байна.

Үүнээс гадна Зүүн Азийн дээд хэмжээний уулзалт (East Asia Summit, EAS) нь аюулгүй байдал, стратегийн асуудлаар өндөр түвшний хэлэлцүүлэг явуулдаг бол Five Power Defence Arrangements (FPDA) нь Их Британи, Австрали, Шинэ Зеланд, Малайз, Сингапурын батлан хамгаалахын хамтын ажиллагааг илэрхийлдэг. Харин Pacific Islands Forum (PIF) нь Номхон далайн арлуудын улс орнуудын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд чиглэж, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой аюулгүй байдлыг чухалчлан ажилладаг.

Зүүн Азийн бүс нутагт өргөн хүрээний аюулгүй байдлын байгууллага дутмаг байгаа нь гурван талт болон жижиг бүлгийн (minilateral) хамтын ажиллагааг нэмэгдүүлж, бодит үр нөлөөтэй хамтын ажиллагааг бий болгож байна. Монгол Улсын хувьд АСЕАН болон Зүүн Азийн хамтын ажиллагаанд оролцох нь бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн уялдаа холбоонд хувь нэмэр оруулах, гадаад бодлогын олон тулгуурт байдлыг хангах, бүс нутгийн яриа хэлэлцээнд дуу хоолойгоо хүргэх, стратегийн байр сууриа бэхжүүлэх чухал ач холбогдолтой юм.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)⁶⁷

Европ, Хойд Америк, Ази тивийн 57 гишүүн улсыг хамарсан Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE) нь нутаг дэвсгэр дээрээ нэг тэрбумаас дээш хүн амтай, дэлхийн хамгийн том бүс нутгийн байгууллага юм. Үүнийг Хойд Америкийн бүс нутгийн цогцолбор болон Европын супер цогцолборын хослолоос бүрдсэн ерөнхий цогц бүтэц гэж үзэж болно. Түүнчлэн зарим талаараа дэд цогц бүтцээр тодорхойлогдож болох юм.

Бүс нутгийн аюулгүй байдлын цогцолборууд нь хамтын аюулгүй байдлын тогтолцооны нэг хэсэг юм. Хамтын аюулгүй байдал гэдэг нь тусгаар улс орнуудын ашигладаг институтууд болон механизмын тогтолцоо бөгөөд энэ нь төрийн болон төрийн бус оролцогчдоос үүдэлтэй аюул заналыг арилгах зорилготой юм.

Монгол Улс нь 2012 онд OSCE-ийн бүрэн эрхт гишүүн болсон бөгөөд энэхүү гишүүнчлэл нь Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, хүний эрх, ардчилал, хууль дээдлэх ёс зэрэг чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг олгож байна.

OSCE-ийн хүрээнд Монгол Улс нь бүс нутгийн аюулгүй байдал, зэвсэг хураах, хүний эрх, ардчилал, хууль дээдлэх ёс зэрэг асуудлаар хамтын ажиллагаа явуулж байна. Монгол Улс нь OSCE-ийн олон талт механизмд идэвхтэй оролцож, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулж байна.

Дэлхийн хэмжээнд батлан хамгаалах хамтын ажиллагаа нь уламжлалт цэргийн холбоодоор дамжин бэхжиж байгаа бөгөөд НАТО, АСЕАН-ийн Батлан

⁶⁷ The Organization for Security and Co-operation in Europe - Co-operative Security, Eva Jakusne Harnos-Eva Remek;

хамгаалахын сайд нарын өргөтгөсөн уулзалт (ADMM-Plus), Европын Холбооны Аюулгүй байдал ба Батлан хамгаалах бодлогын хүрээ зэрэг платформууд нь хамтарсан сургалт, технологийн солилцоо, энхийг дэмжих ажиллагаа, хохирол багатай хүч ашиглах чадварыг нэмэгдүүлэх чиглэлд чухал үүрэг гүйцэтгэж байна. Олон улсын болон бүс нутгийн улс орнуудын батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаа нь цаашид зэвсэглэл, техник, технологийн хөгжлийг дагаж энэ чиглэлээр хөөцөлдөх нь илт болж ирсэн. Бүс нутгийн улс орнууд эдийн засгийн хувьд өөр хоорондоо уялдаа холбоотой болсон нь нэг нь нөгөөгөөсөө хамаарах хамаарлыг улам ихэсгэж байна. Иймд улс орнуудын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны төлөв улс орнуудын аюулгүй байдлын бодлогын хувьд улам бүр харилцан хамааралтай болж цаашлаад хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, стратегийн итгэлцлийг нэмэгдүүлэх, шинэ төрлийн аюул (өндөр технологи, кибер аюул, хиймэл оюун, сансрын төлөөх өрсөлдөөн)-аас өөрийгөө хамгаалах, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд зөөлөн хүчний нөлөөг нэмэгдүүлэх, нэгдмэл хамтын ажиллагааг хөгжүүлж, хамтарсан хариу арга хэмжээ авах чиглэл рүү хөтөлж байна.

3.2. БАТЛАН ХАМГААЛАХЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД

Монгол Улсын батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагаа нь улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, бүс нутгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах, Зэвсэгт хүчний чадавхыг сайжруулах зорилготой ч, үүнтэй зэрэгцэн олон сорилт тулгарч байдаг.

Батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагаа нь өнөөгийн олон улсын харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг болж байгаа бөгөөд улс орнууд аюулгүй байдлаа бэхжүүлэх, өндөр технологи эзэмших, цэргийн уялдаа холбоогоо сайжруулахыг зорьдог.⁶⁸ Гэсэн хэдий ч ийм хамтын ажиллагааны боломжит ашиг тусыг үл харгалзан, хоёр болон олон талт батлан хамгаалах санаачилгын цар хүрээ, үр нөлөөг тодорхойлдог олон төрлийн сорилтууд байсаар байна. Эдгээр сорилт нь техникийн шинж чанартайгаас гадна улс төр, эдийн засаг, соёлын хүчин зүйлтэй нягт уялдаа холбоотой бөгөөд улс орнууд аюулгүй байдлынхаа эрх ашгийг эрэлхийлэхдээ тулгардаг төвөгтэй орчныг илтгэн харуулдаг.

Монгол Улсын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа нь газарзүйн байршил, эдийн засгийн нөөц, бүс нутгийн нөхцөл байдал, олон улсын харилцааны шинэ сорилт, хөрш зэргэлдээх их гүрнүүд болон "гуравдагч хөршүүд"⁶⁹ -тэйгээ харилцаагаа тэнцвэржүүлэх шаардлага зэргээс шалтгаалан томоохон сорилтуудтай тулгардаг. Иймд энэхүү судалгаанд Монгол Улсын батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагаанд тулгарч буй гол сорилтуудыг шинжилж үзнэ.

Батлан хамгаалахын хамтын ажиллагаа нь үндэсний болон хамтын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд ихээхэн ач тустай боловч олон талын сорилттой тулгарч байна. Улс төрийн дотоод тогтворгүй байдал, их гүрнүүдийн дунд орших газарзүйн онцлог, технологийн тэгш бус байдал, эдийн засгийн хязгаарлагдмал байдал, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл зэрэг хүчин зүйлс нь цэргийн хамтын ажиллагааны хүрч болох хязгаарыг тодорхойлдог. Эдгээр сорилтыг таньж, шийдвэрлэх нь улам бүр төвөгтэй болж буй олон улсын аюулгүй байдлын орчинд тогтвортой, харилцан ашигтай батлан хамгаалахын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох нь чухал юм.

Олон улсын хэмжээнд зэвсэгт мөргөлдөөн нэмэгдэж, улсууд цэргийн хүч, зэвсгээ зузаатгаж, батлан хамгаалах төсвөө нэмсээр буй өнөө үед зарим орон тогтвортой байдлаа хадгалж, иргэддээ аюулгүй, тайван орчныг бүрдүүлсээр байна.

Манай улсын батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагаанд тулгарч буй сорилтуудыг дараах байдлаар дурдвал.

Гадаад бодлогын тэнцвэр ба геополитикийн сорилт

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс төр, аюулгүй байдлын орчин эрс өөрчлөгдөж, цэргийн итгэлцэл сулран, их гүрнүүдийн зөрчил хурцдаж байна. Монгол Улс хоёр том гүрний дунд байрладаг онцлогийн хувьд гадаад бодлогын тэнцвэрийг хадгалах нь улам төвөгтэй болж байна. 2025 оны байдлаар Монгол Улс 39 оронтой батлан хамгаалахын салбарын харилцаа тогтоосон.

⁶⁸ Smith, A. (2021). Defense cooperation in the 21st century: Opportunities and challenges. *Security Studies Review*, 15(2), 99-120.

⁶⁹ Монгол Улсын Гадаад харилцааны яам. 2022. Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого;

“Гуравдагч хөршийн бодлого”-ын хэрэгжилт хангалтгүй, зарим тохиолдолд бодлого тодорхой боловч гүйцэтгэл доголдож байна. Энэ нь Монголын гадаад харилцаанд итгэлцлийн дутагдал, эргэлзээ төрүүлж, олон улсын түншүүдтэй хамтын ажиллагааны үр дүнг бууруулж байна. Иймд гадаад бодлогын тэнцвэрийг хадгалах, хөрш орнууд болон гуравдагч түншүүдтэй харилцах стратегийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Олон улсын нөхцөл байдал хурцдаж, их гүрнүүдийн өрсөлдөөн нэмэгдсэн нь Монголын гадаад хамтын ажиллагаанд дарамт учруулж байна. Тухайлбал, АНУ-БНХАУ-ын өрсөлдөөн, ОХУ-ын эсрэг хоригийн бодлого нь Монголын гадаад түншлэлд тодорхой хэмжээнд нөлөөлж байна.

Хүний нөөц ба мэргэжлийн бэлтгэгдсэн боловсон хүчний дутагдал

Монгол Улсын батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааны гол тулгуур нь мэргэжлийн чадвартай, цэргийн дипломат, олон улсын харилцааны чиглэлээр мэргэшсэн офицерууд юм. Манай улсаас одоогийн байдлаар /ОХУ, БНХАУ, АНУ, Бельгийн вант улс, ХБНГУ, БНСУ, БНТУ, БНЭУ, Япон, БНСВУ, Польш/ зэрэг 11 улсад Батлан хамгаалахын атташе, атташегийн алба, НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчийн газарт цэргийн зөвлөх ажиллаж байна. Гэвч эдгээр бүрэлдэхүүн болон цаашид ажиллах боловсон хүчнийг цэргийн дипломат харилцааны чиглэлээр системтэйгээр бэлтгэх хөтөлбөр төлөвлөгөө боловсруулагдаагүй, боловсон хүчний хангалтгүй байна. Цэргийн атташегийн алба, гадаад харилцааны нэгжид ажиллах офицеруудыг тусгай сургалт, ур чадварыг эзэмшүүлэх мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх тогтолцоог хэрэгжүүлдэггүй нь бодлого хэрэгжүүлэх чадварыг сулруулж байна.

Зэвсэгт хүчний алба хаагчдын 10 орчим хувь нь гадаадад цэргийн хэргийн мэргэжлээр суралцаж төгсдөг ба эдгээр боловсон хүчнийг нутагшуулах, сурсан мэдлэг, туршлагыг Монголын хөрсөнд буулгах, байгууллагын түвшинд үр ашигтай ашиглах механизм дутмаг байна. Гадаадад төгсөгчид өөрийн мэргэжлийн чиглэлээр ажиллах боломж хязгаарлагдмал, томилгооны ил тод байдал сул байгаа нь урам зоригийг бууруулж, байгууллагын тогтвортой байдлыг алдагдуулж байна.

Байгууллага хоорондын уялдаа, зохицуулалт сул

Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам болон Элчин сайдын яамд хоорондын мэдээлэл солилцоо, уялдаа холбоо хангалтгүй байна. Судалгаагаар гадаад хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан гэрээ хэлэлцээрийн 15-20 хувь нь хэрэгжилтийн шатанд сааталтай. Энэ нь хариуцлага, хяналт, мэдээлэл солилцох механизм бүрдээгүйг харуулж байна.

Атташегийн албаны эрх хэмжээ тодорхой бус, зарим тохиолдолд Элчин сайд нар тэднийг үндсэн чиг үүргээс гадуур ажилд дайчилдаг байна. Энэ нь батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааны бодлогын хэрэгжилтэд сөрөн нөлөө үзүүлж, цэргийн дипломат албаны нэр хүндийг бууруулж байна.

Мөн хоёр байгууллагын хооронд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилт дээр үл ойлголцол, давхардал үүсдэг. Хууль, эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгаагаас үүдэн атташегийн байр суурь хариуцлага, тайлагналын тогтолцоо сул байна. Үүнийг сайжруулахын тулд хоёр яам хоорондын хамтарсан зөвлөл, хяналт-шинжилгээний систем байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

Санхүү, эдийн засгийн хязгаарлагдмал байдал

Батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд төсөв санхүүгийн хүрэлцээ хамгийн том бэрхшээл болж байна. Төрийн бодлого тодорхой боловч хэрэгжилтийг хангах санхүүжилт дутмаг байгаа тул олон улсын хамтын ажиллагааны гэрээ, хөтөлбөрүүд бодит биелэлт муутай байна. 2021-2024 оны хооронд гадаад хамтын ажиллагааны хүрээнд 384 тэрбум төгрөгийн зээл, тусламж авсан ч энэ дүнгийн дийлэнх нь тоног төхөөрөмж, сургалтын зориулалттай байсан. Батлан хамгаалахын нийт төсвийн 3-5 хувь нь л гадаад хамтын ажиллагаанд зориулагддаг бол дэлхийн дундаж үзүүлэлт 10-15 хувьтай байна. Энэ зөрүү нь хамтын ажиллагааны өргөжилт, сургалт, технологийн шинэчлэлд сөргөөр нөлөөлж байна.

Мөн гадаадын тусламж, зээлд хэт найдах хандлага бий. Гаднаас авсан тусламж бүр улс төр, геополитикийн тодорхой сонирхол дагуулдаг бөгөөд энэ нь Монгол Улсын бие даасан бодлогод эрсдэл үүсгэж болзошгүй гэж оролцогчид анхааруулсан. Иймээс батлан хамгаалахын эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх, дотоод эх үүсвэрт тулгуурлах менежментийг хөгжүүлэх шаардлагатай гэж үзжээ.

Технологи ба зэвсэг техникийн хамаарал

Монгол Улсад батлан хамгаалах зориулалттай зэвсэг, техник, тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэх чадвар сул байгаа нь гадаад нийлүүлэлтэд хэт хамааралтай болгож байна. Монгол Улс одоогоор 7 улстай зэвсэг техникийн хамтын ажиллагаа тогтоосон боловч дотооддоо үйлдвэрлэл хөгжөөгүйгээс хамаарал өндөр хэвээр байна. Судалгаагаар Монголын зэвсэг, техник, тоног төхөөрөмжийн 80 орчим хувь нь Орос улсаас хамааралтай. ОХУ, Хятад зэрэг хөрш орнуудаас хамаарал өндөр байх нь улс орны геополитикийн нөхцөлд эмзэг байдлыг нэмэгдүүлдэг.

Олон улсын цэргийн технологи, инновацын хөгжил хурдацтай өөрчлөгдөж байгаа боловч Монголын батлан хамгаалах салбар үүнд төдийлөн дасан зохицож чадахгүй байна. Дотоодын судалгаа, шинжлэх ухааны байгууллагуудын оролцоо сул, шинэ технологи нутагшуулах төсөл хомс байна. Тиймээс зэвсэг техникийн шинэчлэлийг зөвхөн гадаад худалдан авалтад бус, дотоодын инновацид тулгуурлан хөгжүүлэх шаардлагатай юм. Мөн олон улсын болон бүс нутгийн хамтын нийгэмлэгүүдээр дамжуулан иргэний байгууллагын үйлдвэрлэлийг дэмжих байдлаар цэргийн зэвсэг техникийн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт татах байдлаар хөгжүүлэх боломжтой.

Хамтын ажиллагааны менежмент

Батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааны бодлого тодорхой боловч хэрэгжилт, үнэлгээ, хяналтын тогтолцоо сул байгаа нь нийтлэг асуудал болохыг дурдсан. Хамтын ажиллагааны төсөл, гэрээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад үр дүнг системтэйгээр хэмжих, дүгнэх механизм бүрдээгүйгээс алдаа, давталт, хариуцлагын асуудал үүсдэг. Гадаад хамтын ажиллагааны төслүүдийн 30 орчим

хувь нь хугацаандаа хэрэгждэггүй, үр өгөөжийн үнэлгээ сул байна. Үр дүнг хэмжих, хяналт-шинжилгээ хийх тогтолцоо байхгүйгээс бодлогын хэрэгжилт биелэгдэхгүй байна.

Мөн гадаад сургалт, хамтарсан сургуулиудын оролцогчдыг сонгох, төлөвлөх, бэлтгэх ажиллагаанд ил тод байдал сул, заримдаа мэргэжлийн бус хүмүүс оролцдог нь хамтын ажиллагааны чанарыг бууруулдаг гэж үзсэн. Үүнийг засахын тулд хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулах, үр дүнг хэмжих шалгуур нэвтрүүлэх шаардлагатай байна.

Байгууллагын чадавхи ба бодлогын хэрэгжилтийн асуудал

Батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааны бодлого тодорхой боловч түүнийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын чадавх сул, бүтэц, орон тоо, төсөв хүрэлцэхгүй байгаа нь гадаад хамтын ажиллагааны гүйцэтгэлд саад болж байна.

Удирдлагын түвшинд гаргасан шийдвэр, хөтөлбөрүүдийг доод шатны байгууллагууд хангалттай дэмжиж, хэрэгжүүлэх чадвар сул байдаг. Мөн гадаад харилцаанд ажиллаж буй мэргэжилтнүүдийн ачаалал их, боловсон хүчний тогтворгүй байдал нэмэгдэж байгаа нь урт хугацааны төлөвлөлтөд сөргөөр нөлөөлж байна. Судалгаагаар Батлан хамгаалахын гадаад харилцааны газарт ажиллаж буй мэргэжилтний 50 гаруй хувь нь давхар үүргийг гүйцэтгэдэг тул ажлын ачаалал их өндөр, ингэснээр анхаарал төвлөрөл буурдаг, алдаа гаргах магадлал өссөөр байна.

3.3. БАТЛАН ХАМГААЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ БОЛОМЖ, САНАЛ, ЗӨВЛӨМЖҮҮД

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ийн 3.1.6 дугаар хэсэгт “Хөрш хоёр орон, АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Европын Холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно” гэж заасныг үндэслэн гадаадын улс орнууд болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудтай харилцаагаа гүнзгийрүүлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломж бүрдсэн байна.

Монгол Улсын гадаад харилцааг зохицуулах хууль, тогтоол, бодлогын чиглэл тодорхойлогдсон, дипломат харилцаанд түшиглэн үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсын Гадаад харилцааны бодлогод Монгол Улс “энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулна” гэсэн суурь зарчмыг тууштай баримталж, хоёр хөрш болон гуравдагч хөрш улсуудад өөрийн улсыг таниулах, харилцааны тэнцвэртэй байр сууриа хадгалан, гадаад бодлогын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг ханган, олон улсад Монгол Улсын нэр хүнд, эзлэх байр суурь, нөлөөг нэмэгдүүлэх замаар хөгжлийн гадаад таатай орчинг бүрдүүлсэн. Үүний өчүүхэн нэг хэсэг бол Батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагааны үзүүлэх нөлөөлөл юм. НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд цэргээ оролцуулж эхэлснээс хойш Монгол Улс 54 улстай шинээр дипломат харилцаа тогтоосон.

БХЯ-ны гадаад хамтын ажиллагаа салбарыг хөгжүүлэх чиглэлээр гадаад хамтын ажиллагааны бодлого гаргаж түүний дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 1990 оноос хойш өнөөдрийг хүртэл 39 улстай батлан хамгаалах салбарт харилцаа хамтын ажиллагаа тогтоосон. Үүнээс 16 улстай идэвхтэй хамтын ажиллагаатай ба 7 улс (ОХУ, БНХАУ, АНУ, БНТУ, Украин, Беларусь, Япон)-тай цэрэг-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн байна. Манай улсын хувьд газарзүйн онцлогоос шалтгаалан гуравдагч хөрштэй цэрэг-техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ихээхэн асуудал тулгардаг. Иймд хоёр хөршийн тэнцвэрт байдлыг хадгалах, мөн хоёр хөршийн сайн харилцаатай цэрэг-техникийн хамтын ажиллагаатай улс орнуудтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй юм.

Монгол Улс олон улсын энхийг дэмжих ажиллагаанд идэвхтэй оролцдог ба түүгээр дамжуулан цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадвар, мэргэжлийн туршлагыг сайжруулах боломжийг бүрдүүлж ирсэн. Энэхүү оролцоо нь Монгол Улсын нэр хүндийг олон улсын түвшинд нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааны итгэлцлийг бэхжүүлэх ач холбогдолтой байсаар байна. Гэвч НҮБ-ын санхүүжилт олон улсын сайн дурын хандивын тусламжаар бүтдэг болохоор ихэнх хувийг бүрдүүлдэг АНУ-ын хандив тусламж багассанаар энхийг сахиулах ажиллагаа хумигдах шинж байдал ажиглагдаж ирсэн.

Иймд манай улсаас /ОХУ, БНХАУ, АНУ, Бельгийн вант улс, ХБНГУ, БНСУ, БНТУ, БНЭУ, Япон, БНСВУ, Польш/ зэрэг 11 улсад Батлан хамгаалахын атташе, атташегийн алба, НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчийн газарт цэргийн зөвлөх ажиллаж байна. Эдгээр атташегийн албаар дамжуулан хоёр улсын болон олон

улсын хамтарсан цэргийн сургууль, дадлагад оролцох оролцоог нэмэгдүүлснээр манай улсын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадвар нэмэгдэх боломж бүрдэх юм. Цаашлаад манай улс стратегийн түнш орнуудтай батлан хамгаалах салбарт техник технологи, мэдлэг солилцох чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлснээр орчин үеийн дэвшилтэт техник, технологид суурилсан цэргийг удирдах ур чадварыг хөгжүүлэх, стратегийн шинэ боломжуудыг нэвтрүүлэх, батлан хамгаалах салбарын үйл ажиллагааг шинэчлэх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой юм.

Батлан хамгаалахын сайд 2024-2025 онд ОХУ, БНХАУ, АНУ, БНСУ, БНТУ, БНСВУ, ХБНГУ, Канад улсад албан ёсны айлчлал хийсэн байна. Олон улсын болон бүс нутгийн орнуудын Батлан хамгаалах сайд нарын уулзалтад тогтмол оролцсоноор, батлан хамгаалахын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр санал солилцох. Өөрийн улсын Батлан хамгаалах бодлогын талаар бусад улс оронд таниулах, харилцан хамтран ажиллах боломжуудыг эрэлхийлэх боломжтой. Үүний үр дүнд Монгол Улс олон улсын батлан хамгаалах байгууллагуудтай тогтмол харилцаа холбоо тогтоох, бүс нутгийн аюулгүй байдал, энх тайвныг хангах олон талт төсөл, хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцох боломжтой юм. Энэ нь улс орны дипломат болон батлан хамгаалах байр суурийг олон улсын түвшинд бэхжүүлэх, хамтын ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх ач холбогдолтой. Мөн олон улсын батлан хамгаалах байгууллагуудтай тогтмол хамтран ажилласнаар Монгол Улсын батлан хамгаалах стратегийн тогтвортой байдал баталгаажна.

Эдгээр олон талт боломжууд нь Монгол Улсын Батлан хамгаалах салбарын олон улсын хамтын ажиллагааны стратегийн суурь, чиглэлүүдийг тодорхойлж, цаашид түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг бүрдүүлдэг. Түүнчлэн, энэхүү хамтын ажиллагаа нь цэргийн чадавхыг сайжруулах, бүс нутгийн аюулгүй байдалд хувь нэмэр оруулах, олон улсын түвшинд нэр хүндээ нэмэгдүүлэх стратегийн ач холбогдолтой.

Нэг. Монгол Улсын цэргийн дипломат албыг мэргэшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гадаад хэлний өндөр түвшний мэдлэг олгох сургалт, дипломат харилцааны чадвар, олон улсын эрх зүйн мэдлэг олгох, мэргэшүүлэх богино болон дунд хугацааны шаталсан түвшний сургалтын хөтөлбөрийг боловсруулж мэргэжилтэн бэлтгэх. Ингэснээр атташегийн 50%-ийг мэргэшүүлж, урьдчилан бэлтгэх нь гадаад гэрээний хэрэгжилт, институт хоорондын ойлголт, хүний нөөцийн тогтвортой байдлыг шууд сайжруулах боломжтой ба ингэснээр урт хугацаанд гадаад хамтын ажиллагааны үр ашгийг 10-20% нэмэгдүүлэх боломжтой юм;

Хоёр. Батлан хамгаалах, ГХЯ, Элчин сайдын яамд хоорондын харилцааг сайжруулах, гэрээ төслийн нэгдсэн цахим платформ бий болгосноор гэрээний хэрэгжилтийн саатал (олон эх сурвалжид 15-30% гэж тэмдэглэгдсэн) буурч, хяналт сайжрах тул төсөв, логистик, гадаад сургалт зэрэг үйл ажиллагаануудын үр ашгийг хэлбэржүүлэхэд 30-40% хүртэл үр дүнтэй болох боломжтой;

Гурав. Бүс нутгийн энхийг сахиулах ажиллагаа болон аюулгүй байдлын хамтын ажиллагаанд тэргүүлэх оролцоотой манай улс нь бүс нутгийн хэмжээнд “Энхийг сахиулах ажиллагааны тэргүүлэх судлалын төв”-ийг байгуулж “Хааны Эрэлд” энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургуульд тулгуурлан Монголын энхийг сахиулах ажиллагааны мэргэжил (удирдлага, ар тал хангалт, цэргийн инженер,

эмнэлэг, штаб, ажиглагч офицер)-г системтэйгээр бэлтгэх бодлогыг цогцоор нь авч хэрэгжүүлэх. Монголоос НҮБ-д үүрэг гүйцэтгэсэн олон жилийн туршлага дээр тулгуурлан одоо байгаа сургалтын төвд суурилан НҮБ-ын стандартыг хангасан сертификат олгодог олон улсын сургалт явуулах, санхүүжилт татах, орлогын нэмэгдүүлэх боломжтой юм;

Дөрөв. Монгол Улсын зэвсэгт хүчин нь зэвсэг, техникийн хамтын ажиллагаатай улс орнуудаас зэвсэгт, техникүүдийг худалдан авах болон буцалтгүй тусламжийн хүрээнд авдаг. Энэ нь зэвсэг техникийн хараат байдлыг нэмэгдүүлдэг ба түүнийг бууруулахад технологи дамжуулах (technology transfer) ба хамтран бүтээх (co-production / offset) загварыг хуульчлан нэвтрүүлэх, инновац ба технологийн хамтын ажиллагааны төв байгуулах нь дотоодын үйлдвэрлэл, шинжлэх ухаан, судалгаа хөгжүүлэлтийг идэвхжүүлнэ. Жишээлбэл хамтын ажиллагаатай түншүүдтэй жижиг түвшний хамтын үйлдвэрлэл (жишээ: сумны үйлдвэр) эхлүүлэх замаар импортыг хэсэгчлэн орлуулах боломжтой бөгөөд эхний үе шатанд жижиг үйлдвэр, инкубатор, шинжлэх ухаан, судалгаа хөгжүүлэлтийн төслүүдэд нийлж болох хөрөнгө оруулалтын хүрээнд байж болох юм. Мөн орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлтэй хамтран ажиллах замаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлд нийлүүлэх боломжтой. Энэ үйлдэл нь хөрш орнуудын гадаад бодлогод таарамжгүй үйлдэл үүсгэж болох тул гэрээний ил тод байдал, олон талын хөрөнгө оруулалт, стандартчилал шаардлагатай;

Тав. Гадаад бодлогын тэнцвэрийг бэхжүүлэх үүднээс гуравдагч-хөрш стратеги-г (чадавхыг нэмэгдүүлэх, ар тал хангалт, энхийг сахиулах ажиллагаа, кибер аюулгүй байдал) гэсэн тодорхой хөтөлбөр болгон хэрэгжүүлэх нь хоёр хөрштэйгөө тэнцвэрт байдлыг хадгалж, олон талт итгэлцлийг бэхжүүлэх бөгөөд 3 жилд 4-6 том төсөл амжилттай хэрэгжүүлснээр гадаад санхүүжилт, техник тусламцааг 20-40% нэмэгдүүлэх боломжтой;

Зургаа. Кибер ба мэдээллийн аюулгүй байдлын Dual-use (цэрэг-иргэний) чадавх-ийг нэмэгдүүлэх нь мэдээллийн дайн, пропагандын эрсдэлийг бууруулж, хамгаалах чадварыг сайжруулах бөгөөд 18-24 сарын дотор үндэсний курс, батлан хамгаалахын CERT буюу Компьютерийн ослын яаралтай тусламжийг багийг олон улсын түлшинд бэлтгэснээр хүний нөөцийн кибер чадварыг богино хугацаанд нэмэгдүүлэх боломжтой; эхний шатны сургалт, платформын хөрөнгө оруулалт ихээхэн хэмжээний хөрөнгө шаардлагатай боловч одоо байгаа иргэний байгууллагуудын хөгжүүлэлт болон бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж аюулгүй байдлын чадавхыг нэмэгдүүлэх. Мэдээллийн орчин түргэн өөрчлөгдөж байгаа тул улс төрийн эрсдэлт нөхцөлд ил тод удирдлага, эрх зүйн зохицуулалт шаардлагатай;

Долоо. Олон улсад явагдаж буй зэвсэгт мөргөлдөөний шинж чанар, шинээр үүсэж буй уламжлалт ба уламжлалт бус аюул (терроризм, экстремизм, кибер гэмт хэрэг, дрон, өндөр технологи, хиймэл оюун, байгалийн гамшиг)-аас өөрийгөө хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж бүс нутгийн болон хоёр талын хамтарсан цэргийн сургуулилалт, сургалтад цэргийн алба хаагчдыг оролцуулах, зохион байгуулах. Ингэснээр зэвсэгт хүчний алба хаагчдын ур чадвар сайжирч, хоёр улсын цэргийн итгэлцэл нэмэгдэх боломжтой;

Найм. Хамтын ажиллагааны хяналт ба дүн шинжилгээ M&E (Monitoring & Evaluation)-ний институтийг бэхжүүлж, төслийн эхэн→дунд→төгсгөлийн хэрэгжилтийг үнэлж, жил бүрийн “Өөрчлөлтийн тайлан”-г нийтлэх нь төсөлд хөрөнгө оруулалтын үр ашгийг тодорхой болгох ба 2-3 жилд төслийн хугацаа таслах, үр дүнгүй зарцуулалтын хувийг 30%-аас доош бууруулах боломжтой;

Ес. Логистик, дэд бүтэц (жишээ: Налайх зэрэг олон талт ашиглалтад тохирсон нисэх буудал)-ыг иргэн-цэргийн хамтын ажиллагааны загвараар олон талт гэрээгээр зохицуулах нь дэд бүтцийн ашиглах хугацаа, зардлыг бууруулж, стратегийн уян хатан байдлыг нэмэгдүүлэх. Анги байгууллагуудын дэд бүтцийг сайжруулах, байгаль орчинд ээлтэйгээр боловч хөрш орнуудын аюулгүй байдлын асуудал үүсгэж болзошгүй тул олон улсын стандарт, олон талын гэрээний ил тод байдлыг бүрдүүлэх хэрэгтэй.

Монгол Улсын Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагаа өргөжин тэлж байгаа хэдий ч хоёр болон олон талт гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагаанд илүү идэвхтэй, стратегийн тодорхой, зоримог байр суурьтай оролцох шаардлагатайг судалгааны үр дүн харуулж байна.

ГУРАВДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Монгол Улсын батлан хамгаалах салбарын олон улс дахь оролцоо нь энх тайвныг сахин хамгаалах, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд стратегийн чухал ач холбогдолтой. НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд идэвхтэй оролцох, байнгын төлөөлөгчийн газрын цэргийн зөвлөх томилох, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг бодит алхмууд нь Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд өргөж, дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдалд бодитой хувь нэмэр оруулж буйг харуулдаг.

Монгол Улсын энхийг сахиулагчид олон улсын стандартад нийцсэн сургалт, дадлага, хамтарсан сургалтуудад оролцсоноор мэргэжлийн ур чадвараа дээшлүүлж, цэргийн соёл, сахилга бат, хамтын ажиллагааны туршлагаа нэмэгдүүлсэн билээ. Түүнчлэн энхийг сахиулах ажиллагаанд оролцох нь Монгол Улсын Зэвсэгт хүчний бэлэн байдлын бэлтгэлжилтийн түвшинг олон улсын жишигт нийцүүлэхэд дэмжлэг үзүүлж, цаашлаад бүс нутгийн аюулгүй байдалд чухал хувь нэмэр оруулсаар байна. Мөн түүнчлэн энхийг сахиулах ажиллагаан дахь Монгол Улсын оролцоо нь зөвхөн олон улсын өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэхээс гадна, дэлхий дахины энх тайван, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн бодлогын хэрэгжилтийн тод илэрхийлэл болж байна.

Монгол Улс нь олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна. НАТО-гийн хамтын ажиллагаа нь батлан хамгаалах салбарын чадавхыг бэхжүүлэх, олон улсын энх тайван ажиллагаанд оролцох, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой үр дүнтэй оролцоо болж байна. ШХАБ болон OSCE-ийн хүрээнд Монгол Улс нь бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, хууль дээдлэх ёс зэрэг асуудлаар хамтын ажиллагааг бэхжүүлж байна.

Монгол Улсын батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагаа нь тус улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Сүүлийн жилүүдэд Монгол Улс 30 гаруй улстай батлан хамгаалах салбарын харилцаа тогтоож, 40 гаруй хамтын ажиллагааны гэрээ, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа нь энэхүү чиглэлд тодорхой ахиц гарсныг харуулдаг. Гэвч гадаад хамтын ажиллагааны бодлого хэрэгжилтийн явцад бүтэц, хүний нөөц, санхүү, технологи, геополитикийн хүрээнд олон талын сорилт тулгарсаар байна.

Нэгдүгээрт, батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагаанд ажиллах цэргийн дипломат болон олон улсын харилцааны чиглэлээр мэргэшсэн хүний нөөц хангалтгүй байна. Судалгаагаар нийт атташегийн 60 орчим хувь нь тус чиглэлээр мэргэжлийн бэлтгэлгүй бөгөөд гадаад сургалт, дадлагад хамрагдаж буй офицеруудын тоо Зэвсэгт хүчний нийт албан хаагчдын 10 орчим хувийг л эзэлдэг нь чадавхын хувьд сул байгааг илтгэнэ.

Хоёрдугаарт, институт хоорондын уялдаа сул, эрх хэмжээний тодорхойгүй байдал нь бодлого хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам болон Элчин сайдын яамд хоорондын хамтын ажиллагаа системтэй биш, мэдээлэл солилцоо, хяналт, тайлагналын тогтолцоо бүрдээгүйгээс гэрээ, хөтөлбөрүүдийн 15-20 хувь нь хэрэгжилтийн шатанд сааталтай байна.

Гуравдугаарт, санхүүгийн болон эдийн засгийн хязгаарлалт нь гадаад хамтын ажиллагааны бодит үр өгөөжийг хязгаарлаж байна. Батлан хамгаалахын нийт төсвийн 3-5 хувь нь л гадаад хамтын ажиллагаанд зориулагддаг нь дэлхийн дундажтай харьцуулахад хэт бага үзүүлэлт юм. Түүнчлэн гадаад тусламжид хэт найдах хандлага нь геополитикийн барьцаа бий болгох, бодлогын бие даасан байдлыг алдагдуулах эрсдэлтэй байна.

Дөрөвдүгээрт, технологи, зэвсэг техникийн хамаарал өндөр хэвээр байна. Монгол Улсын батлан хамгаалахын хэрэглэж буй зэвсэг, техник, тоног төхөөрөмжийн 80 орчим хувь нь гадаад улсаас импортлогддог бөгөөд энэ нь геополитикийн эмзэг байдал үүсгэдэг. Технологийн нутагшилт, дотоод судалгааны оролцоо хангалтгүй, инновацын бодлого дутмаг байна.

Тавдугаарт, хамтын ажиллагааны менежмент, хяналт-шинжилгээний тогтолцоо сул байна. Төслийн 30 орчим хувь нь хугацаандаа хэрэгждэггүй, үр дүнг хэмжих, үнэлэх систем бүрдээгүйгээс алдаа давтагдах, бодлогоос хазайх асуудал үүсдэг. Хяналтгүй байдлаас шалтгаалан гадаад хамтын ажиллагааны чанар, үр ашиг муу байна.

Зургаадугаарт, институтийн чадавх, бүтэц, орон тооны хүрэлцээний асуудал тодорхойгүй байна. Гадаад харилцааны чиглэлд ажиллаж буй мэргэжилтний 50 гаруй хувь нь давхар бусад чиг үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинд сөргөөр нөлөөлдөг мөн ирээдүйд нөхөн хангах мэргэжлийн түвшний мэргэшсэн алба хаагч байхгүй байна.

БАТЛАН ХАМГААЛАХЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ӨРГӨЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

Монгол Улс дэлхийн улс орнуудтай харилцан ашигтай гадаад харилцааг өргөжүүлж, үндэсний аюулгүй байдлаа бэхжүүлэхийн тулд батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааг оновчтой, тэнцвэртэй, олон тулгуурт бодлогын зарчмаар хөгжүүлэх шаардлагатай. Геополитикийн хувьд Монгол Улс хоёр их гүрний дунд орших тул батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааг хэрэгжүүлэхдээ тэнцвэртэй байдал, тусгаар тогтнол, дотоод эрх ашиг, урт хугацааны аюулгүй байдлын баталгааг нэн тэргүүнд тавих нь зүйтэй. Батлан хамгаалахын гадаад харилцаа нь зөвхөн цэргийн сургалт, боловсон хүчний солилцоо, харилцан айлчлал, техникийн туслалцаанд хязгаарлагдахаас илүүтэйгээр Монгол Улсын олон улсын нэр хүндийг өргөх, стратегийн түншлэлийг бэхжүүлэх, бүс нутгийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, энхийг дэмжих үйл ажиллагаанд оролцох, урьдчилан сэргийлэх, итгэлцлийг бэхжүүлэх, аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн хангах зэрэг өргөн хүрээг хамарч цогц байдлаар шийдвэрлэгдэх учиртай.

I. Өнөөгийн байдлын үнэлгээ

Монгол Улсын батлан хамгаалахын салбарын гадаад хамтын ажиллагаа дараах үндсэн чиглэлүүдийн хүрээнд явагдаж байна. Үүнд:

1. **Айлчлал, солилцоо** - Харилцаа, хамтын ажиллагаатай орнуудтай батлан хамгаалахын болон зэвсэгт хүчний удирдлагын харилцан айлчлал, солилцоо тогтворжсон, цэргийн мэргэжилтний айлчлал, солилцоо идэвхжиж байна.
2. **Зөвлөлдөх механизм** - Харилцаа, хамтын ажиллагаатай 39 орноос ОХУ, АНУ, БНСУ, БНЭУ, БНТУ, ХБНГУ, АХУ зэрэг оронтой БХЯ-д хоорондын зөвлөлдөх уулзалт тогтворжсон. Бусад орнуудтай зөвлөлдөх уулзалтын механизмыг эрчимжүүлэх, бий болгох шаардлагатай.
3. **Сургалт, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх хамтын ажиллагаа** - АНУ, ОХУ, БНХАУ, Солонгос, Япон, Энэтхэг, Турк зэрэг улстай хамтран офицер, удирдлагын шатны мэргэжилтнүүдийг сургаж, бэлтгэж байна.
4. **Энхийг дэмжих ажиллагааны оролцоо** - НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны өмнөх сургалтууд жигдэрсэн, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны удирдлагын түвшинд ажиллаж эхэлсэн, бүс нутгийн чадавхыг нэмэгдүүлэх хөдөлгөөнт сургалтын бүлэг илгээж эхэлсэн зэрэг НҮБ-ын мандаттай ажиллагаанд тогтмол хувь нэмэр оруулж, өөрийн орны болон олон улсын нэр хүндийг бэхжүүлж байна.
5. **Бүс нутгийн болон олон талт хамтын ажиллагаа** - Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, ARF, ASEAN+ форматтай уулзалтууд, НАТО, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.
6. **Цэрэг-техникийн хамтын ажиллагаа** - Харьцангуй хязгаарлагдмал, ОХУ, БНХАУ, Турк, Украин, Япон, Беларусь улс зэрэг улсуудтай цэрэг-техникийн

хамтын ажиллагаатай ч хуучин техник зэвсэглэл ашиглалт өндөр байгаа нь гадаад эх үүсвэрээр шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.

II. Геополитикийн болон аюулгүй байдлын орчны үнэлгээ

Нөлөөлөгч хүчин зүйл	Боломж	Эрсдэл
ОХУ, БНХАУ-тай хил залгаа байршил	Бүс нутгийн тэнцвэрт хамтын ажиллагааны боломж	Ашиг сонирхлын зөрчил, геостратегийн дарамт үүсэх эрсдэл
Олон тулгуурт гадаад бодлогын зарчим	Барууны болон Азийн дэвшилтэт орнуудтай түншлэл өргөжүүлэх боломж	Тэнцвэр алдагдах тохиолдолд дипломат сорилт нэмэгдэх
Энхийг дэмжих ажиллагаанд нэр хүндтэй оролцогч	Олон улсын харилцаанд илүү том үүрэг, санхүүжилт татах боломж	Хүний нөөцийн ачаалал, төсөвт дарамт үүсэх

III. Стратегийн зорилт

1. Батлан хамгаалахын олон талт гадаад хамтын ажиллагааны арга хэлбэрийг өргөжүүлэх
2. Зэвсэгт хүчний орчин үеийн техник технологи, дижитал шинэчлэлийг гадаад хамтын ажиллагаагаар дэмжих
3. Энхийг дэмжих ажиллагаанд манлайлагч орны байр суурийг хадгалж, оролцоогоо өргөжүүлэх
4. Бүс нутгийн аюулгүй байдлын бодлогын хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, Монгол Улсын гадаад бодлогыг сурталчилж, санаачилгатай, идэвхтэй ажиллах

IV. Бодлогын хэрэгжилтийн санал

1. Хоёр талт ба олон талт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх

- ОХУ ба БНХАУ-тай иж бүрэн стратегийн түвшний харилцан итгэлцлийг хадгалах, хөгжүүлэх шинэ санал санаачилга гаргах, ОХУ-тай хөгжүүлж буй харилцаа идэвхтэй, БНХАУ-тай хөгжүүлж буй харилцаа идэвхгүй байгаа нь хоёр хөрш оронтой тэнцвэртэй харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

- АНУ, Япон, Өмнөд Солонгос, Энэтхэг, Турк зэрэг түнш орнуудтай сургалт, судалгаа, цэргийн технологийн солилцоог нэмэгдүүлэх.

- Европын холбоо, НАТО-гийн “Түншийн хөтөлбөр”-т оролцоогоо өргөжүүлэх, идэвхжүүлэх, тэдний Зүүн хойд Ази болон Төв Азид харилцаа, хамтын

ажиллагаагаа хөгжүүлэх бодлогын зорилт, сонирхлыг ашиглан хамтарсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

- Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцааг илүү үр ашигтай болгож, нэгдсэн стратегийн баримт бичиг боловсруулах шаардлага нэмэгдэж байна.

- Олон улсын нөхцөл байдал, бус нутгийн аюулгүй байдлын өөрчлөлтөд үндэслэн жил бүр “Аюулгүй байдлын стратегийн үнэлгээ” гаргаж, хамтын ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэх.

- Түнш орнуудтай хамтарсан сургалт, дадлага, команд-штабын сургуулилтыг тогтмолжуулж, техник-тактикийн нэгдсэн стандарт бий болгох.

- Кибер аюулгүй байдал, хил хамгаалалт, энхийг сахиулах ажиллагаанд хэрэглэгдэх техник, программ хангамж, тагнуулын системийг хамтын ажиллагааны хүрээнд үе шаттай нэвтрүүлэх.

- Батлан хамгаалах дипломат үйл ажиллагаанд мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог шинэчлэх, гадаадын академи, институтэд суралцах боломжийг нэмэгдүүлэх.

- Мэдээллийн дүн шинжилгээний чадавхыг нэмэгдүүлэх, үүний тулд батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагааны чиглэлээр ажиллах офицеруудыг эртнээс судлан бэлтгэхдээ, эрдэм шинжилгээний хүрээлэн товоор дамжуулан бэлтгэдэг тогтолцоог бий болгох.

- Олон улсын харилцаа, дипломат ажиллагаа, хэлний мэдлэг, төсөл боловсруулах чиглэлээр ажилтнуудад тогтмол сургалт зохион байгуулах.

- Шинэ мэргэжилтнүүдийг татах, гадаад сургалт, дадлагын хөтөлбөрт хамруулах боломжийг нэмэгдүүлэх.

- Батлан хамгаалах яаманд гадаад хамтын ажиллагааны нэгдсэн зохицуулалт, мэдээллийн сан бүхий нэгжийг бэхжүүлэх.

- Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлогын судалгаа хийдэг төвийг гадаадын think tank-уудтай хамтран ажиллах хэлбэрээр хөгжүүлэх.

2. Энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын чадавхыг нэмэгдүүлэх

- Энхийг сахиулагч бэлтгэх төвийн хүчин чадал, хамрах хүрээг өргөтгөх

- Цэргийн эмч, инженер, холбоо, техник технологийн инженер, хиймэл оюуны мэргэжилтнүүдийг тусгайлан сургах

3. Батлан хамгаалахын технологи, зэвсэгт хүчний дижитал шилжилт

- Холимог санхүүжилтийн загвараар (PPP) техник шинэчлэлт хийх

- Зэвсэгт хүчний удирдлага, цэргийн сургалтанд симуляцийн систем нэвтрүүлэх

- Виртуал орчныг ашигласан сургалт, семинар, цэргийн хамтарсан дадлага, сургууль явуулж, нутагшуулах.

4. Бүс нутгийн аюулгүй байдлын диалогт оролцоогоо нэмэгдүүлэх

- “Улаанбаатарын яриа хэлэлцээ”-г жил бүрийн тогтмол форум болгож өргөжүүлэх

- Зүүн хойд Азийн аюулгүй байдлын механизм байгуулах санаачилгад манлайлан идэвх санаачилга гаргаж оролцох

V. Хэрэгжилтийн үе шат

Үе шат	Хугацаа	Гол үйл ажиллагаа
Богино хугацаа	1-2 жил	Хамтын ажиллагааны гэрээ, протокол шинэчлэл, сургалтын солилцоог нэмэгдүүлэх
Дунд хугацаа	3 -5 жил	Дижитал систем нэвтрүүлэх, Энхийг дэмжих хүчин чадлыг өргөтгөх
Урт хугацаа 5-аас дээш жил	5 аас дээш жил	Стратегийн түншлэлийг улам баталгаажуулж, бүс нутгийн аюулгүй байдлын диалогт санаачлан манлайлах байр суурьтай оролцох

Олон улсын туршлага, жишиг ба харьцуулсан дүн шинжилгээ

Финляндын загвар (Бага улс - Өндөр бэлэн байдал)

Финлянд нь геополитикийн өндөр дарамтын бүсэд оршдог ч цэрэг-иргэний нэгдсэн батлан хамгаалалтын бодлогоороо аюулгүй байдлаа бэхжүүлж ирсэн. Тус улс батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхдээ дараах зарчмыг баримталдаг:

- Олон улстай тэнцвэртэй харилцах, аль нэг талд хэт хандаж, давуу байдал олгохгүй байх.
- Хилийн хамгаалалтаа технологи, мэдээллийн нэгдсэн системээр дэмжих.
- Батлан хамгаалахад ард иргэдийн оролцоог үндэсний хэмжээнд зохион байгуулах.

Монгол Улс энэхүү туршлагаас **цэрэг-иргэний нэгдсэн батлан хамгаалах бэлэн байдлын сургалтын загварыг** нутагшуулах боломжтой.

Казахстаны загвар (Нөхцөл байдал ойролцоо улс)

Казахстан нь бүс нутгийн тэнцвэртэй бодлого, олон тулгуурт гадаад харилцааны зарчмыг илүү бодлогын шинжтэй хэрэгжүүлж, дараах чиглэлд анхаарсан:

- Зэвсэгт хүчний мэргэжлийн боловсон хүчний бэлтгэлийг тодорхой бодлоготойгоор гадаад сургалтын хөтөлбөртэй уялдуулах.
- Энхийг дэмжих ажиллагаанд тогтмол оролцох.
- Батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийн чиглэлийн зарим шугамыг гадаад түншлэлээр хөгжүүлэх.

Монгол Улс энэ туршлагаас **энхийг дэмжих ажиллагааны оролцоог ашиглан олон улсын нэр хүнд, боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх** боломжтой.

Өмнөд Солонгосын загвар (Дэвшилтэт технологийн түншлэл)

Солонгос улс батлан хамгаалахын салбарт дараах стратегийг амжилттай хэрэгжүүлсэн:

- Батлан хамгаалахын үйлдвэрлэл, технологийг хөгжүүлэх боломжийг судлах
- Хамтын ажиллагааг боловсрол, судалгаа, инновацын системтэй уялдуулах
- Цэргийн хүчийг зөвхөн тоо бус технологийн хүчин зүйлээр бэхжүүлэхэд анхаарах

Монгол Улс энэ туршлагаас **тагнуул, кибер аюулгүй байдал, шинэ үеийн холбоо мэдээллийн харилцааны системийн сургалтыг** авах боломжтой.

ТӨВ АЗИД ЭНХИЙГ САХИУЛАХ БОЛОН ЦЭРЭГ-ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ БОДЛОГЫН САНАЛ

1. Төв Азийн орнуудтай гурван талт болон олон талт зөвлөлдөх механизм байгуулах

- Монгол-Казахстан-Киргизстан болон Монгол-Узбекистан-Тажикстан гэсэн форматаар БХЯ хоорондын жил бүрийн стратегийн уулзалтыг тогтмолжуулах.
- Тухайн форматуудын хүрээнд сургалт, судалгаа, логистикийн чадавх хамтран сайжруулах.

2. Төв Азийн орнуудад энхийг сахиулах ажиллагааны сургалтын бүс нутгийн төв хамтран байгуулах

- "Хааны эрэлд сургууль"-ийн үйл ажиллагааг бүс нутгийн түвшинд өргөжүүлэн хөгжүүлж, сурталчлах
- НҮБ-ын энхийг сахиулах стандартын дагуу хамтарсан команд-штабын сургалт зохион байгуулах.

3. Цэрэг-техникийн хамтын ажиллагааг шаталсан түвшинд өргөжүүлэх

- Зэвсэглэл, тээвэр-логистикийн дэмжлэг, инженерийн тоног төхөөрөмжийн худалдан авалт, нийлүүлэлтийн тал дээр харилцан ашигтай гэрээ байгуулах.
- Засвар үйлчилгээ, техникийн сургалтыг хамтын хэлбэрт шилжүүлж, технологийн хараат байдлыг бууруулах.

4. Хилийн аюулгүй байдал, терроризмын эсрэг хамтарсан чадавхыг сайжруулах

- Мэдээлэл солилцоо, кибер аюулгүй байдлын хамтын бэлтгэлийг эрчимжүүлэх.
- Хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хууль бус зэвсгийн эргэлтийн эсрэг хамтарсан ажиллагааг тогтмолжуулах.

5. Цэрэг-иргэний интеграцийн туршлага, хямралын үеийн тэсвэртэй байдлыг хамтран хөгжүүлэх

- Байгалийн болон хүмүүнлэгийн гамшгийн үед хариу арга хэмжээ авах инженерийн болон зам тээврийн хамтарсан хүчин чадлыг бий болгох.
- Цэргийн нөөцийн сургалт, иргэний бэлэн байдлын системийн туршлагыг харилцан солилцох.

6. Залуу офицеруудын боловсрол, мэргэжлийн чадавхыг нэмэгдүүлэх

- Батлан хамгаалахын их сургуулиуд хооронд оюутан болон багш солилцох хөтөлбөр эхлүүлэх.
- ОХУ, Турк, Энэтхэгийн дам зуучлалгүйгээр шууд сургалтын хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.

7. Эдийн засаг-батлан хамгаалах хос чиглэлийн төслүүд хэрэгжүүлэх

- Цэргийн технологи хөнгөн үйлдвэрлэл, инженерийн байгууламж, барилга, зам засварын салбарт хамтран хөрөнгө оруулалт татах.
- Батлан хамгаалахад хэрэглэх тоног төхөөрөмжийн дотоод үйлдвэрлэлийн суурь чадавхыг Төв Азийн орны туршлагаар бэхжүүлэх.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын батлан хамгаалахын гадаад хамтын ажиллагаа нь улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулах, зэвсэгт хүчний шинэчлэлийг эрчимжүүлэх чухал хэрэгсэл юм. Геополитикийн орчин хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд Монгол Улс тэнцвэртэй, олон тулгуурт гадаад бодлогыг үргэлжлүүлэн баримтлахын зэрэгцээ хамтын ажиллагааны чанар, үр нөлөөний бодит чадавхыг бэхжүүлэх түвшинд хүргэх шаардлагатай байна. Иймд дараах бодлогын шийдвэрийн дараах саналуудыг дэвшүүлж байна.

Бодлогын Шийдвэрийн Зөвлөмжүүд

1. Батлан хамгаалахын чадавхыг олон улсын сургалт, хамтарсан дадлагаар системтэй нэмэгдүүлэх

Хил хамгаалалт, кибер аюулгүй байдал, энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр стратегийн түншлэлийн харилцаатай орнуудтай хамтарсан сургалт, судалгааны хөтөлбөр хэрэгжүүлэх.

2. Технологи, мэдээллийн аюулгүй байдалд төвлөрсөн хамтын ажиллагааг өргөжүүлэх

Орчин үеийн байлдааны удирдлагын систем, дрон, кибер хамгаалалтын программ хангамж, хиймэл оюуныг батлан хамгаалах хэрэглээнд нутагшуулах зорилгоор хамтарсан лаборатори байгуулах.

3. Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын оролцоог үе шаттай нэмэгдүүлэх

Цэргийг хямралт үеийн ажиллагаанд оролцох чадавхтай болгох, НҮБ-ын ажиллагаа дахь удирдлагын түвшний оролцоог нэмэгдүүлэх, мэргэжилтнүүдийн багийг томилгоожуулан ажиллуулах замаар Монгол Улсын нэр хүнд, дипломат нөлөөг өсгөх.

4. Монгол Улсаас санаачлан боловсруулсан хөтөлбөрийг үргэлжлүүлэх

Энхийг сахиулагчид, тэдний гэр бүлд дэмжлэг үзүүлэх жишиг хөтөлбөрийг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг илгээгч орнуудад сурталчлах, энэхүү

санаачилгын хэрэгжилтийг эрчимжүүлэхийн тулд Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчдийн газар, ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтэст тусгайлсан орон тоог бий болгох замаар дэмжиж, Монгол Улсын олон улсын нэр хүндийг өргөх, санаачилсан хөтөлбөр, төслөө олон улсад амжилттай хэрэгжүүлэхэд онцгой анхаарах.

5. Бүс нутгийн аюулгүй байдлын диалог, хамтын ажиллагаанд илүү идэвхтэй байр суурь эзлэх

ШХАБ, АСЕМ, АНУ-БНХАУ-ОХУ-ын гурван талт стратегийн ойлголцлын орон зайг нэмэгдүүлэхэд дипломат батлан хамгаалахын сувгийг ашиглах.

6. Батлан хамгаалахын салбарын хүний нөөцийг олон улсын боловсрол ба мэргэжлийн үнэлгээний тогтолцоонд нийцүүлэх

Цэргийн академи, дээд сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагыг НАТО, АСЕАН, ЕХ-ны сургалтын стандартад ойртуулах.

7. Олон улсын түншлэл бүхий батлан хамгаалахын санхүүжилтийн ил тод, тогтвортой механизмыг бүрдүүлэх

Зардлын үр ашигт суурилсан төсөвлөлт, олон улсын тусламж ба төсөл хөтөлбөрийн менежментийн нэгдсэн системийг боловсронгуй болгох.

8. Цэрэг-иргэний нэгдсэн хамгаалалтын бодлогыг бэхжүүлэх

Халдварт өвчин, кибер халдлага, гамшиг ослын үед иргэн-цэргийн уялдааг бэхжүүлэх чиглэлтэй сургалт, төлөвлөлтийн механизмыг сайжруулах.

9. Цэрэг-техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэх

Бүгд Найрамдах Беларусь Улстай тогтоосон цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд зэвсэгт хүчний хэрэгцээнд шаардлагатай хүн тээврийн автобус угсрах, үйлдвэрлэх чадавхыг бий болгох чиглэлээр хамтран ажиллах.

10. Батлан хамгаалахын атташегийн үйл ажиллагааг идэвхжүүлж, дэмжлэг үзүүлэх

Монгол Улсаас гадаад улс орнуудад суугаа Элчин сайдын яамдын батлан хамгаалахын атташе нарын батлан хамгаалах, зэвсэгт хүчний үйл ажиллагааг дэмжиж, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж болох арга хэмжээний зардлуудыг БХЯ-наас жил бүр төсөвт суулган дэмжлэг үзүүлэх.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Waldemar Kitler, "National Security Theory and Practice"
2. Stanford Encyclopedia of Philosophy — "Political Realism in International Relations"
3. Princeton.edu — "Liberalism and International Relations Theory" (A. Moravcsik)
4. InternationalRelations.org — "Constructivism in International Relations"
5. ScienceDirect — Sovereignty (олон улсын эрх зүйн болон улс төр- Суверенитет — улс орны гадаад эрх мэдэл болон өөрөө удирдах чөлөөт байдлын хэлбэр)
6. *The People-Centered Approach to Security* — UNDP-ийн баримт бичиг, хүн төвтэй аюулгүй байдлын хандлага
7. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал — "Үндэсний эв нэгдэл" нь үндэсний язгуур ашиг сонирхол
8. Balance of Power Theory — PolSci Institute (тэнцвэрийн) хүчний онолд үндэслэн, улс орнууд гадаад орчны хүчнүүдтэй харьцан тэнцвэрт байдал.
9. "Sustainability and National Security" — Drazen Smiljanić-гийн судалгаа санал болгож буй бичиглэл, тогтвортой хөгжил
10. <https://www.tandfonline.com/doi/full/10.1080/18335330.2014.940822>
11. <https://plato.stanford.edu/archives/fall2014/entries/realism-intl-relations/>
12. Robert O. Keohane & Joseph S. Nye — *Power and Interdependence* либералист (neo-liberal) Institutionalism-ийн гол суурь, олон улсын хамтын ажиллагаа, институт, харилцан хамаарлын онол.
13. https://www.researchgate.net/publication/239065011_A_Social_Theory_of_International_Politics
14. <https://competitionandappropriation.econ.ucla.edu/wp-content/uploads/sites/95/1970/01/Principles-of-Political-Economy-and-Taxation-1817.pdf>
15. <https://humanityontrial.com/bully-states-and-global-anarchy/four-perspectives-on-international-relations/institutionalism-in-international-relations/>
16. https://www.researchgate.net/publication/233093052_INFORMATION_INTERDEPENDENCE_Keohane_and_Nye%27s_complex_interdependence_in_the_information_age
17. <https://www.globalsecurity.org/military/library/report/1995/WWZ.htm>
18. <https://www.cambridge.org/core/journals/leiden-journal-of-international-law/article/abs/principle-of-nonintervention/7EE9EC769A3F2CEE10E3DEE1CB30E274>
19. <https://mongolia.un.org/mn/sdgs/13>
20. https://uk.sagepub.com/sites/default/files/upm-assets/120704_book_item_120704.pdf
21. <https://igovernment.mn/docs/418>
22. <https://www.gov.mn/mn/organization/mofa/service?documentId=3&serviceId=6347bceb-547e-4ff1-8264-48028e08eb50>
23. <https://igovernment.mn/docs/412>
24. <https://www.iss.gov.mn/wp-content/uploads/2023/03/toim-14-0228.pdf>
25. <https://www.gov.mn/mn/organization/mfa>

26. https://defmin.fi/documents/236553176/238659714/Finland_US_DCA_-_Finland_Prime_-_English.pdf/d4e48fb3-2807-1891-d805-08cdf11cec6/Finland_US_DCA_-_Finland_Prime_-_English.pdf?t=1745495798423
27. <https://www.government.se/contentassets/fa069c4f33504103ab4b5e635f947a34/a-greement-on-defense-cooperation-between-sweden-and-the-united-states-of-america.pdf>
28. https://www.mindef.gov.sg/news-and-events/latest-releases/24sep19_fs/
29. <https://www.mindef.gov.sg/defence-matters/defence-topics/total-defence/>
30. <https://www.mofa.go.jp/files/000241983.pdf>
31. <https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/18109.pdf>
32. <https://jamestown.org/kyrgyzstans-national-security-concept-legally-enshrines-strategic-balance/>
33. <https://eng.sectsco.org/20230922/-Joint-anti-terrorism-drill-of-the-SCO-and-CIS-Eurasia-Antiterror---2023-959008.html>
34. <https://www.ankasam.org/anka-analizler/current-developments-in-russia-kyrgyzstan-military-cooperation/>
35. Morgenthau, H. J. (1948). *Politics among nations: The struggle for power and peace*. New York: Alfred A. Knopf.
(Реализмын онолын эх сурвалц таны файлд ишлэгдсэн)
36. Waltz, K. (1979). *Theory of international politics*. McGraw-Hill.
(Неореализмын онолын тайлбаруудтай холбогдох үндсэн эх)
37. Keohane, R. O., & Nye, J. S. (1977). *Power and interdependence*. Little, Brown.
(Харилцан хамаарал, институционализмтай холбогдох хэсэг)
38. Government of Mongolia. (n.d.). *National Security Concept of Mongolia*. <https://legalinfo.mn> (Үндэсний аюулгүй байдлын тухай хэсэгт тулгуурласан)
39. Government of Mongolia. (n.d.). *Foreign Policy Concept of Mongolia*. <https://legalinfo.mn> (Гадаад бодлогын зорилтуудыг ашигласан) \НАТО болон Европын аюулгүй байдал
40. NATO. (n.d.). *Finland and NATO*. https://www.nato.int/cps/en/natohq/topics_193275.htm
(Файлд Финлянд НАТО-д элссэн, EVA-д оролцсон тухай)
41. NATO. (n.d.). *Enhanced Vigilance Activities (EVA)*. <https://www.nato.int> (EVA ажиллагааны тухай файлд бий)
42. NORDEFECO. (n.d.). *Nordic Defence Cooperation*. <https://www.nordefco.org> (NORDEFECO-гийн үйл ажиллагааг тодорхой дурдсан)
43. U.S. Department of Defense. (2023). *U.S. - Finland Defense Cooperation factsheet*. <https://www.defense.gov>
(Файлд АНУ-ын цэргүүд Финландын 15 бааз ашиглах эрхтэй болсон талаар)
44. Government of Finland. (2023). *Defense cooperation with the United States*. <https://www.defmin.fi>
(АНУ-ын нисэх хүчний онгоц Финландын нисэх буудал ашиглах тухай)
45. Ministry of Foreign Affairs of Mongolia. (n.d.). *Foreign policy and security overview*. <https://mfa.gov.mn>
(Файлд Монгол Улсын гадаад бодлого, тэнцвэрийн хандлага)

46. Ministry of Defense of Mongolia. (n.d.). *Defense diplomacy and cooperation*. <https://mod.gov.mn>

ХОЁРДУГААР БҮЛГИЙН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдлын талаар БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга хурандаа Т.Наранхүү
2. Монгол улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого: хамтын ажиллагаагаар аюулгүй байдлаа хангах нь., Улаанбаатар 2013 он
3. Батлан хамгаалах бодлогын хувьсал, өөрчлөлт., Улаанбаатар 2025 он
4. Энхийг дэмжих ажиллагааны туршлага, сургамж., Улаанбаатар 2023 он
5. Монгол улсын батлан хамгаалахын цагаан ном., Улаанбаатар хот
6. Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагаа, энхийг сахиулахын цагаан ном., 2015 он
7. Government of Mongolia. (2000). *Diplomatic Service Act of Mongolia*. Government of Mongolia.
8. Government of Mongolia. (n.d.). *National Security Concept of Mongolia*. Government of Mongolia.
9. Government of Mongolia. (n.d.). *Foreign Policy Concept of Mongolia*. Government of Mongolia.
10. Ministry of Defense of Mongolia. (1993-2020). *Reports on international defense cooperation and peacekeeping participation*. Ministry of Defense of Mongolia.
11. General Staff of the Mongolian Armed Forces. (n.d.). *Peacekeeping operations participation report*. Mongolian Armed Forces.
12. United Nations. (n.d.). *UNMISS: United Nations Mission in South Sudan*. <https://peacekeeping.un.org>
13. United Nations. (n.d.). *UNAMID, UNISFA, MINURSO & other peacekeeping operations reports*. <https://peacekeeping.un.org>
14. NATO. (n.d.). *Kosovo Force (KFOR)*. <https://www.nato.int>
15. Various authors. (n.d.). *Studies on Mongolia's third-neighbour policy and Asia-Pacific regional security*. Academic and policy publications.
16. Ministry of Defense of Mongolia & Ministry of National Defense of the People's Republic of China. (1993-2014). *Bilateral military cooperation and assistance protocols*.
17. Ministry of Defense of Mongolia & Ministry of Defense of the Russian Federation. (n.d.). *Bilateral military cooperation agreements*.

ГУРАВДУГААР БҮЛГИЙН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. The Camp David U.S.-Japan-Korea Trilateral Summit: An Exchange among CSIS Japan and Korea Chairs, <https://www.csis.org/analysis/camp-david-us-japan-korea-trilateral-summit-exchange-among-csis-japan-and-korea-chairs>;
2. Mutual Defense Treaty Between the United States and the Republic of Korea, October 1, 1953;

3. Oberdorfer, D., & Carlin, R. (2014). *The Two Koreas: A Contemporary History* (3rd ed.). Basic Books;
4. U.S. Department of War, 2022, <https://www.war.gov/>;
5. Cha, V. D., & Kang, D. C. (2003). *Nuclear North Korea: A Debate on Engagement Strategies*. Columbia University Press;
6. Bandow, D. (2020). *Time for South Korea to take over its own defense*. Cato Institute Policy Analysis;
7. Revere, E. J. R. (2017). *THAAD and the future of the U.S.-ROK alliance*. Brookings Institution;
8. Dower, J. W. (1999). *Embracing Defeat: Japan in the Wake of World War II*. W.W. Norton & Company;
9. Green, M. J. (2001). *Japan's Reluctant Realism: Foreign Policy Challenges in an Era of Uncertain Power*. Palgrave Macmillan;
10. Samuels, R. J. (2007). *Securing Japan: Tokyo's Grand Strategy and the Future of East Asia*. Cornell University Press;
11. Funabashi, Y. (1991). *Japan and the New World Order*. Council on Foreign Relations Press;
12. Hughes, C. W. (2009). *Japan's Remilitarisation*. Routledge;
13. Smith, S. A. (2015). "Missile Defense Cooperation Between the United States and Japan." *Asian Security Studies Journal*;
14. Schoff, J. (2021). "U.S.-Japan Security Alliance in the Indo-Pacific Era." *Carnegie Endowment for International Peace*;
15. Hughes, C. W. (2017). *Japan's Foreign and Security Policy Under the 'Abe Doctrine'*. Palgrave Macmillan;
16. Smith, S. A. (2019). *Intimate Rivals: Japanese Domestic Politics and a Rising China*. Columbia University Press;
17. Green, M. J. (2022). *Line of Advantage: Japan's Grand Strategy in the Era of Abe Shinzō*. Columbia University Press;
18. Treaty of Good-Neighborliness and Friendly Cooperation Between the People's Republic of China and the Russian Federation. https://www.mfa.gov.cn/eng/zy/qb/202405/t20240531_11367098.html;
19. Trends Research. (2024). Russian-Chinese collaboration in defense technology: Prospects and limits. <https://trendsresearch.org/insight/russian-chinese-collaboration-in-defense-technology-prospects-and-limits/>;
20. AP News. (2025, August 26). China and Russia to hold joint naval exercise near Japan next month, CEIAS. (2024). The Sino-Russian military nexus: New strategic shifts.
21. Reuters. (2025, August 26). China, Russia should safeguard security, development interests, says Xi;
22. Reddit. (2022). China-North Korea Mutual Aid and Cooperation Treaty (1961);
23. Green, Mark A. "China and Russia: Quietly Going Steady?" *Wilson Center*, 2024. <https://www.wilsoncenter.org/blog-post/china-and-russia-quietly-going-steady>;
24. Cozad, Mark, Cortez A. Cooper III, Alexis A. Blanc, David Woodworth, Anthony Adler, Kotryna Jukneviute, Mark Hvizda, and Sale Lilly. "Future Scenarios for Sino-Russian Military Cooperation: Possibilities, Limitations, and Consequences." *RAND*, 2024. https://www.rand.org/pubs/research_reports/RRA2061-5.html;

25. President of Russia. "Joint Statement of the Russian Federation and the People's Republic of China on the International Relations Entering a New Era and the Global Sustainable Development." President of Russia, 2022. <http://en.kremlin.ru/supplement/5770>;
26. Russia-North Korea Relations, <https://www.congress.gov/crs-product/IF12760>;
27. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт, Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс;
28. Монгол Улсын Гадаад харилцааны яам. 2022. Монгол Улсын гуравдагч хөршийн бодлого;
29. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
30. Smith, A. (2021). Defense cooperation in the 21st century: Opportunities and challenges. Security Studies Review, 15(2), 99-120;
31. https://en.wikipedia.org/wiki/List_of_intergovernmental_organizations#/media/File:Alliances_expansive_Map.png
32. International Security Organizations by Anna Molnar, Dora Molnar, Monika Szente-Varga, Budapest, 2024;